

# Лиахоно

**Аврагчийн  
итгэл найдвар,  
чөлөөлөлтийн  
захиас, 18-р хуудас**

Урам тань хугарах үед Найн  
дахь бэлэвсэн эмэгтэйг  
санаарай, 12-р хуудас

Христийн амилсны баярын  
дуу хөгжим: “Ариун тэр  
цэцэрлэгт,” 24-р хуудас

Хэрхэн амар амгаланг  
олж, хууран мэхлэгдэхээс  
зайлсхийж болох вэ?,  
26-р хуудас





СҮМ  
ЭНД  
БИЙ

# Исланд

## Рейкьявик







Цаст Эсья уулын бэлд орших Рейкьявик хот бол өнгө өнгийн барилга бүхий Исландын нийслэл бөгөөд Европын эх газраас 1000 милийн (1609 км) зайд орших тус арлын оронд тавтай морилно уу хэмээн урин дууддаг. МЭ 874 онд анх викингчүүдийн ирж суурьшсан Рейкьявик хот нь Исландын соёл, эдийн засаг, засаг төрийн үйл ажиллагааны төв бөгөөд дэлхийн хамгийн цэвэрхэн, ногоон, аюулгүй хотуудын нэг юм.

1851 онд хамгийн анхны хоёр исланд хүн Данид баптисм хүртжээ. Тэд удалгүй Исланд руу буцсан ба 1853 онд анхны салбар зохион байгуулагдсан байна. Өнөөдөр Исланд нь Рейкьявик, Акурейри болон Селфосс хотуудад ойролцоогоор 300 гишүүнтэй гурван салбартай болжээ. Хамгийн ойр байрлах ариун сүм нь Рейкьявикаас 1177 милийн (1894 км) зайд орших Английн Лондон дахь ариун сүм юм.

Хэдийгээр Сүмийн гишүүдийн тоо цөөн ч гэлээ Сүм улам бүр өссөөр байна. Алслагдсан байршил, Сүмийн материалуудын орчуулга, цаг уурын хүндрэл, соёлын саад бэрхшээл гэх мэт асуудал байгаа ч Сүмийн удирдагчид Исланд хэзээ нэгэн цагт бусад улс үндэстэнд гэрэлт цамхаг нь байх болно хэмээн амласан. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Исландад зочлон ирэхдээ Сүмийн гишүүдэд “агуу зүйлсийг хийх ‘хүч, чадвартай’ хүмүүс” болохыг нь сануулсан билээ (“Wonderful to Have Sweet, Good Land,” *Church News*, Sept. 21, 2002, 10).

- Исландын номлол 1894 онд байгуулагдсан ч гадуур явж номлохыг 1914 онд зогсоосон юм. Исланд нь 1975 онд Данийн Копенгаген номлолын хэсэг болсон.
- 1977 онд тухайн үед Далын чуулгын гишүүн байсан ахлагч Жозэф Б.Вертлин (1917–2008) Исландыг сайн мэдээний номлолын төлөө онцгойлон адисалжээ.
- 1981 онд Мормоны Номыг Исландаас өөр хаана ч ярьдаггүй исланд хэлээр хэвлэн гаргасан байна.





Урам тань хугарах үед  
Найн дахь бэлэвсэн  
эмэгтэйг санаарай  
Кийт Ж.Вилсон

12



Аврагчийн чөлөөлөх  
хүчинд итгэ  
Ерөнхийлөгч Хэнри  
Б.Айринг

18



Хайр, баяр баясгалан,  
амар амгалангийн  
талаарх гурван  
сургамж  
Брайн К.Аштон

26



Тохинууллыг  
баяр баясгалант  
болгох нь  
8

# Урам тань хугарах үед

**А**мьдралд өөдлөх, уруудах үе бий. Заримдаа бид сэтгэлээр унахдаа Бурханы хийж байгаа зүйлийн талаар, биднийг хайрладаг Эцэг яагаад ийм зүйл болохыг зөвшөөрч байгаа юм бэ? гэж боддог. Иймэрхүү хүнд асуудалд орох нь биднийг “Бурхан миний төлөө чин сэтгэлээсээ санаа зовдог болов уу?” гэж асуухад хүргэдэг юм.

Үүнтэй адил нөхцөл байдалд надад дараах судрууд тусалдаг болохыг би олж мэдсэн. Тухайлбал:








- **Дуулал 8:4-5:** “Хүн гэгч юу болоод Та түүнд санаа тав[ина] . . . вэ? Та түүнийг Бурханаас арай дор болгож, Алдар ба хүндэтгэлийн ийн титмийг түүнд өмсгөжээ.”
- **Иохан 10:14:** Есүс энэ дэлхий дээр байх хугацаандаа Өөрийгөө “Би бол сайн хоньчин мөн. Би Өөрийнхийгөө мэдэх бөгөөд Өөрийнхөн минь Намайг мэднэ” хэмээсэн.
- **Моше 1:39:** Энэ нь миний хамгийн дуртай судрын шүлгүүдийн нэг бөгөөд Их Эзэн бошиглогч Иосеф Смитэд Өөрийг зорилгыг: “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” хэмээн илчилсэн байдаг.
- **Лук 7:11-16:** Миний хувьд энэ нь үхлийг давах Аврагчийн хүчийн талаар зааж, Христийн амилсны энэ баяраар үүнийг бидэнд сануулахын зэрэгцээ, Тэрээр бидний хүн нэг бүрийг сайн мэддэг болохын хамгийн оновчтой жишээ юм. Есүс Христийн үзүүлсэн гайхамшгуудын дундаас Найн дахь эмэгтэйд тохируулсан явдал нь Түүний өр нимгэн, энэрэнгүй сэтгэлийг хамгийн сайн харуулсан байдаг. Миний хуваалцсан нийтлэлд (12-р хуудсыг үзнэ үү) орсон энэ түүх Аврагч бидний амьдралд юу болж байгааг сонирхдог бөгөөд бидний хүн нэг бүрийг хайрладаг болохыг харуулдаг.


Кийт Вилсон

Бригам Янгийн Их Сургуулийн дэд профессор





- 5 Тэр амилсан!**  “Үхлийг ялан дийлж, хүмүүн чөлөөтэй болов. Христ тийн ялалт байгуулав”
- 6 Итгэлийн хөрөг:** Боб болон Лори Төрстон— Камбож Пномпень номлол  Тэдний номлол бодож байснаас нь тэс өөр байв. Гэхдээ энэ нь мөн тэднийг төсөөлөхийн аргагүй арга замаар адисалсан.
- 8 Тохинууллын зарчмууд:** Тохинууллыг баяр баясгалант болгох нь Жинхэнэ баяр баясгаланг олж болох арга замуудын нэг бол үйлчлэл юм.
- 12 Урам тань хугарах үед Найн дахь бэлэвсэн эмэгтэйг санаарай**  
*Кийт Ж.Вилсон*  
Аврагч Найн дахь бэлэвсэн эмэгтэйд тусалсантай адил хамгийн их тусламж хэрэгтэй үед маань бидэн дээр ирэх болно.
- 18 Аврагчийн чөлөөлөх хүчинд итгэ**  
*Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг*  
Биднийг илүү зөв шударга болох үед Их Эзэн сорилт бэрхшээлээс маань биднийг чөлөөлнө.
- 24 Дуу хөгжим:** Ариун тэр цэцэрлэгт  *Тамми Симистэр Робинсон*  
Аврагч бидний төлөө амьдарч, нас барсан.
- 26 Хайр, баяр баясгалан, амар амгалангийн талаарх гурван сургамж**  
*Брайн К.Аштон*  
Та нар байгаа нөхцөл байдлаасаа үл хамааран аз жаргалтай болж болно.
- 32 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой:**  Хуй салхи хуримын төлөвлөгөөг нураав; мөнх бус амьдрал гэж яг юу вэ; итгэл найдвар төрүүлсэн дуу; хүлээн авсан урилга.
- 36 Бие даасан байдлаас ирдэг адислалууд:** Бизнес цэцэглэж байна  *Жошуа Ж.Перки*  
Хуульч залуу ажлын байраа алдсан ч Сүмийн бие даах чадвар хөгжүүлэх ангиас сүнсний өдөөлтийг олж авчээ.
- 38 Бидний гэр орон, гэр бүл:** Бидний хүү бол Тэнгэрлэг Эцэгийн хүү  *Жерлин Мөрфи*  
Бид үр хүүхдүүдээ хэчнээн их хайрладаг байсан ч Бурхан тэднийг биднээс илүү хайрладаг.
- 40 Өсвөр үеийн болон бага насны хүүхдүүдэд заах:**  
Эмгэнэлт явдлыг даван гарах нь  Хүүхдүүдэд тань амар амгаланг мэдрэхэд туслах санаанууд.

 Богино өгүүллүүд



**Хавтсан дээр**  
Вэнди Кэллэр,  
Еммау хүрэх замд.

## Хэсгүүд

### Залуучуудад зориулав

42

Өдөр бүр сонголт хийж, **амьдралыг өөрчлөх шийдвэрүүдийг** гаргахдаа

бидэнд зориулсан

**Бурханы төлөвлөгөөг дагаж байгаага** бид хэрхэн мэдэж болох вэ?

**Илчлэлт хүлээн авах** тухай өгүүлсэн энэ сарын нийтлэлтэй танилцана уу.



### Өсвөр үеийнхэнд зориулав

50

Энэ сарын нийтлэлүүдийг уншихдаа патриархын адислалаа ашиглаж суран, **Христийн амилсны баярын шинэ уламжлалыг** эхлүүлэхэд сүнсээр өдөөгдөж, өөрийгөө болон бусдыг **амар амгалан болго.**



### Хүүхдүүдэд зориулав

Есүс Христ, Түүний Цагаатгал болон Амилалт мөн эдгээр нь бидний хувьд ямар утга учиртай болох тухай уншиж, яагаад бид **Христийн амилсны баярыг тэмдэглэдэг** талаар илүү ихийг олж мэд.






## ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД



## Сүнсэлэг булчингаа хөгжүүлэх нь

Аспэн Стандэр

Гэрчлэлээ сулруулахгүйн тулд бид сүнсэлэг булчингаа тогтмол хөгжүүлж байх ёстой.



## Та сайн мэдээг чин сэтгэлээсээ дагаж амьдарч чадахгүй байна уу?

Шакэлл Вордлэй

Үнэндээ Сүмд завгүй байх, сайн мэдээнд идэвхтэй байх хоёр хоорондоо ямар ялгаатай вэ?

ДӨРӨВДҮГЭЭР 2019 ОНЫ 4-Р САР, 20, №2  
ЛИАХОНА 18604 363

Есүс Христийн Хожмын Уеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

**Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга:** М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күж, Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андарсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссас Соарэс

**Эрхлэгч:** Рэнди Д.Фанк  
**Зөвлөхүүд:** Бриэн К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Бэжи Крайвэн, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд Л.Холлстром, Ларри С.Качер, Эрик В.Копишк, Линн Г.Роббинс

**Гүйцэтгэх захирал:** Ричард И.Хийтон  
**Сүмийн сэтгүүлийн захирал:** Аллан Р.Лойборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Адам С.Олсон

**Гүйцэтгэх захирлын туслах:** Раян Карр

**Хэвлэлийн туслах:** Камилла Кастрион  
**Редакцийн баг:** Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Гарретт Х.Гарфф, Жон Райн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мердок, Салли Жонсон Оджерк, Жошуа Ж.Гэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Сэлү, Лори Фүллэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Вилддисон

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:** Ж.Скотт Кнудсэн

**Зургийн дарга:** Тадд Р.Пэтэрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнгли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, Брэд Тизри, К.Никол Вокенорст

**Оюуны өмчийн зохицуулагч:** Коллэтт Нэбжэр Аун

**Хэвлэлийн менежер:** Жэйн Анн Пэтэрс  
**Хэвлэх баг:** Ира Глэн Адэйр, Жоли Бердтэт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Мэрисса М.Смит

**Хэвлэлийн эх бэлтгэгч:** Жошуа Дэннис, Аммон Харрис

**Хэвлэлийн захирал:** Стивэн Т.Льюис  
**Хуваарилалт хариуцсан захирал:** Трой Р.Баркер

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернет вэбсайт** liahona.lds.org руу, шуудангаар Liahona, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь уггаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литов, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португаль, румын, свахили, самоа, себу, словени, солонгос, сингал,

тагалог, тай, тамил, тахити, телугу, тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстон, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

**Зохиогчийн эрхийн талаарх**

**мэдээлэл:** Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ Лиахона гаас материал хувиран авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

## ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон comefollowme.lds.org вэбсайт дээр дараах зүйлсийг хийж болно.

- Сэтгүүлийн энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийн түүх, санал зөвлөмжийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад захиалж өгч, бэлэглэ.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцахаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

## БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.lds.org вэбсайт руу илгээ эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:  
Liahona, flr. 23

50 E. North Temple Street  
Salt Lake City, UT, 84150-0023, USA

## For Readers in the United States

and Canada: April 2019 Vol. 20, No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada, \$6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.lds.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431) POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.



**Т**эр амилсан! Тэр амилсан!  
Баяр хөөртэйгөөр тунхагла.  
Гурван өдрийн гянданг яллаа.  
Газар ертөнц хөөрч баярла.

Үхлийг ялж, биднийг сулла.

Христ Эзэн ялагч боллоо.

(“Тэр амилсан” Сүмийн дуулал болон  
Хүүхдийн дуу, х.55).

Та энэ Христийн амилсны баяраар Аврагчийг дурсан санахдаа [lds.org/go/4195](https://www.lds.org/go/4195) руу орж, гайхамшигтай уран зургуудыг болон Аврагчийн ямар зан чанар Цагаатгал, Амилалтыг боломжтой болгосон талаарх төлөөлөгчдийн гэрчлэлийг үзэж болно.





## Боб болон Лори Төрстон

Камбож Пномпень номлолд үйлчилсэн



*Бид бүгд Бурханы хүүхэд тул хэл яриа, соёлын ялгаанаас үл хамааран утга учиртай тохинууллыг хийж болно гэдгийг Боб, Лори Төрстон хоёр эхнийхээ номлолоос сурчээ.*

**ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН**

### Боб:

Нэг өдөр бид чанга хөгжим сонсож, майхан барьж байгааг олж харсан. Камбожид энэ нь хэн нэгэн гэрлэж байгаа эсвэл нас барсан гэсэн үг байв.

### Лори:

Тав, зургаан хүүхдийн эх нас барсныг бид олж мэдэж билээ. Бидний сонсож мэдсэнээр, тэр нөхөргүй нэгэн байв. Хүүхдүүд нэг өглөө сэрээд л ээжийгээ амьсгал хураасан байсныг мэджээ.

Нэг охин нь мэгшин уйлж байв. Орчуулагчаар дамжуулан тэр “Би хамгийн том нь. Би ийм олон дүү нараа тэжээхийн тулд юу хийхээ мэдэхгүй байна” гэсэн.

Би түүнийг чанга тэврэв. Би тэврэхгүй байж чадна гэж үү дээ? Тэр охин эхийгээ дөнгөж алдчихаад байгаа шүү дээ. Би түүнд англиар “Намайг ойлгохгүй байгааг чинь би мэдэж байгаа ч чи ээжтэйгээ дахин уулзана гэдгийг би амлаж байна. Юм бүхэн сайхан болно. Чи ганцаараа орхигдохгүй” гэж хэлсэн юм.

Ийм олон олон туршлага биднийг Камбожийн ард түмэнтэй онцгой байдлаар холбож өгсөн.

### ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Итгэлийн өөр хөргийг  
[lds.org/go/18](https://www.lds.org/go/18) вэбсайтаас үзнэ үү.







# Тохинууллын зарчмууд

# ТОХИНУУЛЛЫГ

# баяр баясгалант

# БОЛГОХ НЬ

Хайраар үйлчлэх нь үйлчлэл үзүүлэгч, хүлээн авагч хоёрт хоёуланд баяр баясгаланг авчирдаг.

**З**аримдаа энэ амьдралд аз жаргалыг эрэлхийлэх нь гүйлтийн зам дээр гүйхтэй адилхан мэт байдаг. Бид гүйж байгаа мөртлөө байрнаасаа хөдлөхгүй байгаа юм шиг санагддаг. Харин зарим хүний хувьд бусдад тохинуулах тал дээр ажил дээр нь дахиад ажил нэмж өгч байна даа гэж бодогддог.

Гэхдээ Тэнгэрлэг Эцэг маань биднийг баяр баясгаланг амсаасай хэмээн хүсдэг бөгөөд “баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:25) хэмээн хэлсэн. Бусдад тохинуулах нь өөрсдийн болон бусдын амьдралд баяр баясгаланг авчрахын нэн чухал хэсэг болохыг Аврагч заасан.

## **Баяр баясгалан гэж юу вэ?**

Баяр баясгалан гэдэг нь “асар их баяр хөөр, аз жаргалыг мэдрэхийг”<sup>1</sup> хэлнэ. Хожмын үеийн бошиглогчид баяр баясгалан хаанаас ирдэг мөн хэрхэн олж авдгийг тодотгосон. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Бидний баяр баясгалан амьдралын маань нөхцөл байдлаас биш, харин амьдралдаа юунд ач холбогдол өгч байгаатай холбоотой” бөгөөд “. . .Баяр баясгалан [Есүс Христийн] ачаар, [Есүс Христээс] ирдэг. Тэр бол бүхий л баяр баясгалангийн эх үүсвэр юм”<sup>2</sup> гэж заасан.





## Тохинуулал баяр баясгаланг авчирдаг

Лихай амьдралын модны жимснээс хүртэж, бодгаль нь “агуу баяраар” (1 Нифай 8:12) дүүргэгдсэн. Түүний эхний хүсэл бол энэ жимсийг хайртай хүмүүстэйгээ хуваалцах явдал байсан.

Бусдад тохинуулах хүсэл маань ийм баяр баясгаланг бидэнд болон тэдэнд авчирч болно. Хэрэв бид Түүнтэй холбогдсон байвал бидний авчирдаг үр жимс бидэнд бүрэн дүүрэн баяр баясгаланг мэдрэхэд тусалдаг болохыг Аврагч Өөрийн шавь нарт заасан (Иохан 15:1–11-ийг үзнэ үү). Үйлчилж, бусдыг Түүнд авчрахыг эрэлхийлэх замаар Түүний ажлыг хийх нь баяр баясгаланг авчирдаг

## ЖИНХЭНЭ БАЯР БАЯСГАЛАНГИЙН ЭХ СУРВАЛЖ

Мөнх бус амьдралынхаа хугацаанд бид жинхэнэ баяр баясгаланг үйлчлэлээр дамжуулан олох боломжтой болохын төгс үлгэр жишээг Аврагч бидэнд харуулсан.

(Лук 15:7; Алма 29:9; Сургаал ба Гэрээ 18:16; 50:22-ыг үзнэ үү). Бид эсэргүүцэлтэй тулгарч, зовлон бэрхшээл амссан ч энэ баяр баясгаланг амсах боломжтой (2 Коринт 7:4; Колоссай 1:11-ийг үзнэ үү).

Мөнх амьдрал дахь жинхэнэ баяр баясгалангийн хамгийн агуу эх сурвалжийг үйлчлэлээр дамжуулан олох боломжтой гэдгийн төгс үлгэр жишээг Аврагч бидэнд үзүүлсэн. Бид ах, эгч нартаа Аврагчийн адил зүрх сэтгэлээсээ энэрэл, хайраар үйлчлэх юм бол ердийн аз жаргалаас илүү их баяр баясгаланг мэдрэх болно.

“[Тохинууллыг] дуулгавартай зүрх сэтгэлээр хүлээн авснаар . . . Бид Сионы хүмүүс болоход илүү ойртох болно. Бид шавь байхаар аялахдаа үйлчлэл үзүүлсэн хүмүүстэй хамт гайхамшигтай баяр баяслыг мэдрэх болно” хэмээн Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам эгч заасан.<sup>3</sup>





## Бид тохинууллыг хэрхэн илүү баяр баясгалантай болгож болох вэ?

Тохинуулалдаа илүү их баяр баясгаланг авчирч болох олон арга зам бий. Энд хэдэн жишээ авч үзье.

- 1. Тохинууллынхаа зорилгыг ойлго.** Тохинуулах олон шалтгаан байгаа. Эцсийн эцэст бидний гаргах хүчин чармайлт “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Моисе 1:39) гэсэн Бурханы зорилготой нийцсэн байх ёстой. Бусдад гэрээний зам дээрээ үлдэхэд нь туслах ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны урилгыг хүлээн авснаар бид Бурханы ажилд оролцон, баяр баясгаланг олж авч чадна.<sup>4</sup> (Тохинууллын зорилгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Ministering Principles: The Purpose That Will Change Our Ministering,” in the January 2019 *Liahona*-аас үзнэ үү.)
- 2. Тохинууллыг ажил талаас нь биш, харин хүн талаас харж сур.** Ерөнхийлөгч Томас С.Монсон бидэнд “Шийдвэрлэх ёстой асуудлыг хайрлах ёстой хүнээсээ хэзээ ч илүүд бүү тавь”<sup>5</sup> хэмээн байнга сануулсан. Тохинуулал бол ажил хийх тухай биш, харин хүнийг хайрлах тухай юм гэдгийг сана. Бид Аврагчийн адил хайрлаж сурснаар үйлчлэлээс ирдэг баяр баясгаланг хүлээн авахад илүү нээлттэй болдог.
- 3. Тохинууллыг хялбарчил.** Арван хоёр Төлөөлөгчийн

Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч ерөнхийлөгч М.Рассэлл Баллардын хэлсэнчлэн, “Өчүүхэн мөн энгийн зүйлсээр агуу их зүйлс улиран авчрагддаг. . . . Бидний сайхан сэтгэлийн угаас хийдэг өчүүхэн жижиг үйлдэл, үйлчлэл хуримтлагдсаар Тэнгэрлэг Эцэгийг хайрлах хайр, Их Эзэн Есүс Христийн үйл хэрэгт зориулсан чин сэтгэл мөн нэг нэгэндээ тусламжийн гараа сунгах бүрд мэдрэгдэх амар амгалан, баяр баясгалангаар дүүрэн амьдрал болж хувирна.”<sup>6</sup>

- 4. Тохинууллыг шахалт дарамтгүй хий.** Хэн нэгнийг авралд авчрах нь таны үүрэг биш. Энэ нь тухайн хувь хүн, Их Эзэн хоёрын хоорондын асуудал юм. Бидний үүрэг хариуцлага бол тэднийг хайрлан, Аврагч Есүс Христэд хандуулах явдал билээ.

## Үйлчлэлээс ирэх баяр баясгалангаа бүү хойш тавь

Заримдаа хүмүүс тусламж хүсэхээсээ халгадаг. Тиймээс өөрсдийн үйлчлэлийг санал болгох нь тэдэнд яг хэрэгтэй байгаа зүйл нь байж болох юм. Гэхдээ өөрсдийгөө хүмүүст тулгах нь бас л үүний хариулт биш. Тохинуулахынхаа өмнө зөвшөөрөл хүсэх нь оновчтой санаа юм.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф эхлээд өөрөө, дараа нь хүүхдүүд нь салхин цэцэг туссан өрх толгойлсон эхийн талаар ярьсан. Ердийн цагт толбо ч үгүй цэвэрхэн байдаг байсан гэр орон нь эмх замбараагүй, бохир заваан болсон байв. Аяга таваг, хувцас хунар нь овоорчээ.

Сэтгэлээр бүрэн унах яг тэр мөчид Халамжийн нийгэмлэгийн эгч нар хаалгыг нь тогшлоо. Тэд “Тусламж хэрэгтэй бол бидэнд хэлээрэй” гэсэнгүй. Тэд нөхцөл байдлыг хараад, ханцуй шамлан шууд ажилдаа оржээ.

“Тэд эмх замбараагүй болсон зүйлсийг цэгцэлж, гэр оронг нь гэрэл гэгээтэй, цэвэр цэмцгэр болгон, шаардлагатай зарим хүнсний зүйлийг авчирч өгөхийг найзаасаа хүссэн байна. Тэднийг ажлаа дуусгаад, баяртай гэж хэлэх үед залуу ээж баярлаж талархан, хайрын нулимстай хоцорсон юм.”<sup>7</sup>

Авч, өгч байгаа хүмүүс хоёулаа баяр баясгалангийн халуун дулаан мэдрэмжийг мэдрэсэн.



## Амьдралдаа баяр баясгаланг авчир

Бид өөрсдийн амьдралд хэдий чинээ их баяр баясгалан, амар амгалан, сэтгэл хангалуун байдлыг авчирна, төдий чинээ тохинуулалдаа тэдгээрийг бусадтай хуваалцаж чадна. Баяр баясгалан нь Ариун Сүнсээр дамжиж ирдэг (Галат 5:22 болон Сургаал ба Гэрээ 11:13-ыг үзнэ үү). Бид энэ тухай залбирч (Сургаал ба Гэрээ 136:29-ийг үзнэ үү), үүнийг өөрсдийн амьдралд урин авчрах боломжтой. Баяр баясгаланг өөрсдийн амьдралд авчрах хэд хэдэн санааг доор дурдав.

### 1. Адислалуудаа тоол. Амьдралдаа дүн шинжилгээ хийж,

Бурханы өөрийг тань адисалсан зүйлсийг тэмдэглэл дээрээ бич. <sup>8</sup> Эргэн тойронд тань байгаа сайн сайхан бүхнийг олж хар. <sup>9</sup> Баяр баясгаланг мэдрэхэд саад болж байж болзошгүй зүйлсэд анхаарч, тэдгээрийг шийдвэрлэхэд буюу илүү сайн ойлгоход туслах арга замыг бичиж тэмдэглэ. Христийн амилсны баярын өдрүүдээр Аврагчтай илүү ойртон холбогдож болох арга замыг эрэлхийл (Сургаал ба Гэрээ 101:36-г үзнэ үү).

### 2. Анхааралтай байх дадлага хий. Чимээгүй орчинд бясалгал хийхэд баяр баясгаланг хамгийн амархан олдог. <sup>10</sup> Танд юу баяр баясгаланг авчирдаг болохыг мэдэхийн тулд анхааралтай сонс (1 Шастир 16:15-ыг үзнэ үү). Заримдаа анхааралтай байх дадлага хийхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээс хэсэг хугацаанд хол байх хэрэгтэй байдаг. <sup>11</sup>

### 3. Өөрийгөө бусадтай харьцуулахаас зайлсхий. Харьцуулах нь баяр баясгалангийн хулгайч гэж хэлэх нь бий. Паул “өөрсдийгөө өөрсдөөрөө хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг нь ухаангүй” (2 Коринт 10:12) хүмүүс хэмээн сэрэмжлүүлсэн.

### 4. Хувийн илчлэлт эрэлхийл. Аврагч “Хэрэв чи асуух аваас, чи баяр хөөрийг авчирдаг, амьдралыг авчирдаг тэрхүү нууцууд хийгээд амар амгалангийн зүйлүүдийг мэдэж болохын тулд илчлэлт дээр илчлэлт мэдлэг дээр мэдлэг хүлээн авах болно” (Сургаал ба Гэрээ 42:61) хэмээн заасан.

## Үйлдэхэд урих

Та тохинууллаар дамжуулан амьдралдаа олж авах баяр баясгаланг хэрхэн өсгөн нэмэгдүүлж болох вэ? ■

Энэ нийтлэл дээрх зарчмуудыг өдөр тутмын харилцаандаа ашиглаж болох ч, эдгээр нь тохинуулагч ах, эгч нарын өөрсдийн дааж авсан хувь хүн, гэр бүлүүдийг адислахын тулд гаргадаг хүчин чармайлтад нь туслахад зориулагдсан.

## ЭШЛЭЛҮҮД

1. “Joy,” en.oxforddictionaries.com
2. Рассэлл М.Нэлсон, “Баяр баясгалантай байж, сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэх нь,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 72.
3. Жийн Б.Бингам, “Аврагчийн адил тохинуулах нь,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 132.
4. Рассэлл М.Нэлсон, “Биднийг хамтдаа урагшлахад,” *Лиахона*, 2018 оны 4-р сар, 4–7-г үзнэ үү.
5. Томас С.Монсон, “Аялалдаа баяр баяслыг олох нь,” 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 98.
6. М. Russell Ballard, “Finding Joy through Loving Service,” *Liahona*, May 2011, 49.
7. Дийтр Ф.Угдорф, “Сайн мэдээний дагуу аз жаргалтай амьдрах нь,” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 140–144-ийг үзнэ үү.
8. Henry V. Eyring, “O Remember, Remember,” *Liahona*, Nov. 2007, 67-г үзнэ үү.
9. Жийн Б.Бингам, “Та нарын баяр баясгалан дүүрэн болохын тулд,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 80-ийг үзнэ үү.
10. Дийтр Ф.Угдорф, “Хамгийн чухал зүйлсийн тухай,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 25-ыг үзнэ үү.
11. Гари И.Стивэнсон, “Сүнслэг киртэлт,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 33-ыг үзнэ үү.









# Урам тань хугарах үед Найн дахь бэлэвсэн эмэгтэйг санаарай

Ялангуяа биднийг мартсан эсвэл орхисон мэт санагдах үед, Аврагч бэлэвсэн эмэгтэйд тусламж хэрэгтэй байх яг тэр үед нь ирж тусалсан бөгөөд бидэнд ч бас туслахаар ирнэ гэдгийг бид санах ёстой.

**Кийт Ж.Вилсон**

Бригам Янгийн Их сургуулийн эртний судрын дэд профессор

**З**аримдаа өөдөлж, уруудах амьдралын харгүйд Бурхан бидний өдөр тутмын амьдралд идэвхтэй оролцдоггүй юм байна гэж бодогдох үе гардаг. Бидний амьдралын хэв маяг уйтгартай, нэг хэвийн мэт санагдах үе бий. Өөрчлөгдсөн гээд байх юмгүй, бас заримдаа Бурханы шууд оролцоо орсон ганц зүйл юу юм бол гэдгийг заахад хүртэл хэцүү байдаг. Миний амьдрал ач холбогдолгүй юм байна гэсэн бодол төрөх үед би Шинэ Гэрээн дээрх түүхэнд гардаг эмэгтэйн талаар үргэлж боддог. Түүний нэр сударт тэмдэглэгдээгүй байдаг ч амьдардаг тосгоных нь нэр болон гэрлэлтийн байдлаар нь амархан мэддэг.

Тэрээр Найн хотын бэлэвсэн эмэгтэй байсан бөгөөд зөвхөн евангелист Лук түүний гайхалтай түүхийг цэдэглэсэн. Миний хувьд тэр эмэгтэй Аврагчийн хүн рүү чиглэсэн тохинууллын мөн чанарыг болон Тэрээр нийгэм дэх урам нь хугарсан энгийн хүмүүст тусламжийн гараа хэрхэн сунгадаг байсныг төлөөлдөг. Энэ түүх Бурхан бидний хэн болохыг мэддэг гэдгийг харуулдаг бөгөөд бидний төлөө санаа тавьдаг эсэхтэй холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлэдэг.

Лук номын 7-р бүлгийн товч тоймд Есүс оршуулгын ёслолын дундуур орж, нас барсан залууг гайхамшигтайгаар амилуулсан талаар өгүүлсэн байдаг. Гэхдээ орчин тойрных нь талаарх өөр олон зүйлийг бид ойлгосон байх ёстой. Бүх гайхамшгийн адилаар, тэр тусмаа энэ үйл явдлыг ойлгоход нөхцөл байдал амин чухал үүрэг гүйцэтгэдэг. Бригам Янгийн Их Сургуулийн Иерусалим дахь төвд зааж байсны хувьд би энэ гайхамшгийн талаарх өөрийн бодол санааг хуваалцъя.




Найн нь Есүсийн амьдарч байх үед Морэ уулын эсрэг талд, Иезреелийн хөндийн зүүн зүгт оршдог, тариалан эрхэлдэг жижигхэн тосгон байжээ. Уг тосгон шороон замаас зайдуу байрладаг байв. Тийшээ ганцхан замаар очдог байжээ. Есүсийн амьдарч байсан үед энэ тосгон харьцангуй жижигхэн, ядуу тарчиг байсан ба одоо ч тэр хэвээр байдаг. Түүхэндээ энэ тосгон тойрон хүрээлсэн 34 байшин, 189-хөн хүнтэй үе ч байсан.<sup>1</sup> Одоо энэ тосгонд ойролцоогоор 1500 хүн амьдардаг.

Лук энэхүү түүхийн эхэнд Есүс Капернаумд өмнөх өдөр нь байсан бөгөөд зуутын даргын боолыг эдгээсэн талаар өгүүлдэг (Лук 7:1–10-ыг үзнэ үү). Дараа нь Аврагч “удалгүй” (11-р шүлэг; тодотгол нэмэгдсэн) Найн хэмээх хот руу олон шавиа дагуулан явсан тухай мэдэж авдаг. Үйл явдлын энэ дараалал маш чухал. Капернаум хот нь Галилын тэнгисийн хойд эргээр, далайн түвшнээс 600 тохой (183 м) доор байрладаг. Найн нь Капернаумаас баруун өмнөд зүгт 30 бээрийн (48 км) зайд, далайн түвшнээс 700 тохой (213 м) дээр газарт байрладаг учраас тийшээ очихын тулд дээшээ өгсөж, нэлээн хүч гаргаж байж очдог. Капернаумаас Найн руу явган явж хүрэхийн тулд хамгийн багадаа нэгээс хоёр өдөр шаардагдах байв. Саяхан би БЯИС-ийн Иерусалим дахь төвийн суралцагчдыг тийшээ авч явахдаа засмал замаар 10 цаг явган явж хүрсэн. Тиймээс Есүс “удалгүй”<sup>2</sup> тийшээ очиж, оршуулах ажиллагааг зогсоохын тулд өглөө үүрээр сэргж, шөнө алхах хэрэгтэй байсан байж ч болох юм.

Христ хүнд аяллын дараа, хорь орчим<sup>3</sup> насны залууг оршуулах дамнуурган дээр аваад гарч явж байгааг харжээ. Лук энэ залууг нэгэн бэлэвсэн эмэгтэйн ганц хүү гэдгийг хэлсэн ба зарим эрдэмтэн энэ хэсгийг түүнд тэр залуугаас өөр үр хүүхэд байгаагүй гэж грек хэлнээс орчуулсан байдаг.<sup>4</sup> Тосгоны олон хүн уг эмэгтэйн гэр бүлд тохиолдсон гай зовлонг хуваалцахаар дагажээ.

Хүүгээ алдах нь ямар ч хүний хувьд эмгэнэлтэй зүйл боловч тэрхүү бэлэвсэн эмэгтэй ямар ээдрээтэй байдалд орсныг бодож үзнэ үү. Эртний Израилд өв залгамжлагчгүй үлдэх гэдэг нь нийгэм, сүнслэг байдал, санхүүгийн







хувьд ямар байдалд орно гэсэн үг байсан бэ? Хуучин Гэрээний цаг үед нөхөр нь өтөлж хөгшрөхөөсөө өмнө үхвэл нүглийн төлөө Бурханы өгсөн шийтгэл хэмээн үздэг байжээ. Тиймээс зарим хүн бэлэвсэн эмэгтэй Бурханы шийтгэлийг хүртэж байна гэдэгт итгэж байсан. Рут номд Наоми залуудаа бэлэвсрээд “Нэгэнт ЭЗЭН миний эсрэг гэрчилж, Төгс хүчит Нэгэн намайг зовоосон” (Рут 1:21, Олон улсын жишиг хувилбар)<sup>5</sup> хэмээн гашуудан өгүүлсэн байдаг.

Найн дахь бэлэвсэн эмэгтэй сүнслэг болон сэтгэл санааны зовлон шаналлаас гадна өлсгөлөнд нэрвэгдэхээр байв.<sup>6</sup> Гэрлэснээр эмэгтэй хүн нөхрийнхөө гэр бүлийн санхүүгийн хамгаалалтан доор ордог байж. Нөхөр нь нас барснаар энэ үүргийг ууган хүүгийн эрх бүхий хүү нь хүлээж авдаг байв. Харин одоо тэр бэлэвсэн эмэгтэйн ууган хүүгийн эрхтэй цорын ганц хүү нь нас барж, санхүүгийн эх үүсвэр нь ч үгүй болжээ. Хэрэв хүү нь 20 гаруй настай байсан бол тэр эмэгтэй дундаж насны, тариачдын алслагдмал жижигхэн хотод амьдардаг бөгөөд сүнслэг байдал, нийгэм, санхүүгийн хувьд үгүйрч хоосорсон тийм нэгэн эмэгтэй байв.

Энэ эмэгтэйн хүүг хотынхон нь оршуулахаар авч явж байх яг тэр мөчид Есүс оршуулгын ёслолтой тааралдаж, “ихэд өрөвд[жээ]” (Лук 7:13). Энэ нь Лукийн хамгийн дутуу хэлсэн хэсэг байж болох юм. Есүс яагаад ч юм тэр бэлэвсэн эмэгтэйн цөхөрсөн байдлыг мэдэрсэн. Магадгүй уг эмэгтэй шөнөжингөө







шороон шалан дээрээ тэрийн унаж, Тэнгэрлэг Эцэгээс яагаад гэдгийг мэдэхийг хүсэн залбирсан байж болох юм. Тэрээр энэ дэлхий дээр цаашид амьдрахыг өөрөөс нь шаардаж байгаа шалтгааныг асуусан байж ч магадгүй. Эсвэл тэрээр өөрт нь тулгарах ганцаардлаас айж байсан байж болох юм. Бид үүнийг мэдэхгүй. Гэхдээ Аврагч Капернаумаас шууд гарч явсан гэдгийг бид мэдэх бөгөөд биеийг нь газарт булахаас өмнө оршуулгын ёслолыг болиулахын тулд Тэр шөнөжингөө алхах хэрэгтэй байсан.

Тийм ээ, Тэрээр ёслолын сүүлд алхаж буй эмэгтэйн нулимс урссан царайг хараад, түүнийг ихэд өрөвдөв. Гэхдээ Тэрээр оршуулгын ёслолыг болиулахаар “гэнэт тэнд” явж очихоосоо өмнө өрөвдөх сэтгэл төрсөн байсан бололтой. Тэрээр уг эмэгтэйд тусламж хэрэгтэй байсан яг тэр мөчид очсон юм.

Дараа нь Есүс бэлэвсэн эмэгтэйд “Бүү уйл” (13-р шүлэг) хэмээн хэлсэн. Тэрээр оршуулгын ёслолоос цэрвэлгүй “авсанд гараа хүргэтэл ёслолд явж байсан хүмүүс зогслоо.” Тэгээд Тэр “Би чамд хэлж байна. Залуу минь, бос!” хэмээн тушаахад “үхсэн хүн босоод ярьж эхлэв. Ингэж Есүс түүнийг эхэд нь эргүүлэн өгөв” (14–15-р шүлэг). Хотынхон болон Есүсийн дагалдагчид

гайхаж, уй гашуу нь баяр хөөрөөр солигджээ. Тэд бүгдээрээ “Бурханыг алдаршуулж—Бидний дунд агуу эш үзүүлэгч гарч ирлээ” (16-р шүлэг) гэгцгээж байлаа. Гэхдээ энэ гайхамшиг нь нэгэн цөхөрсөн бодгалийг аварсан тухай өгүүлдэг. Өөрийн соёлд дорд үзэгддэг энэ эмэгтэйн хувьд шударга бус зүйл болж байгааг Есүс мэдэрсэн. Хэдийгээр Тэрээр яг тохирох цаг мөчид нь очихын тулд хол зам туулах хэрэгтэй байсан ч тэр эмэгтэйн нөхцөл байдал нэн даруй тусламж үзүүлэхийг шаардаж байсан. Тэрээр түүний цөхөрснийг мэдсэн бөгөөд хурдхан ирсэн. Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) “нэгэн өдөр бид амьдралынхаа тохиолдлын зүйл мэт санагдсан зүйлсийг эргэж хараад, тэдгээр нь тохиолдлынх биш байсныг ухаарах болно”<sup>7</sup> хэмээн хэлжээ.

Хэдийгээр энэхүү түүх урам зориг өгдөг ч энэ нь бидний хувьд Библийн баяр хөөртэй нэгэн түүхээс ч илүү чухал болох ёстой. Энэ нь Есүс тэрхүү ядуу, мартагдсан, цөхөрсөн бэлэвсэн эмэгтэйн талаар мэддэг байсан гэдгийг маргаангүй баталж өгдөг. Ялангуяа бидэнд мартагдсан, орхигдсон эсвэл ач холбогдолгүй мэт санагдах үед Аврагч уг бэлэвсэн эмэгтэйд тусламж хэрэгтэй үед нь



ирж тусалсан төдийгүй бидэнд ч бас туслахаар ирнэ гэдгийг санах ёстой. Түүнчлэн Аврагчийнхаа жишээнээс авч болох хоёр дахь сургамж бол эргэн тойрныхоо хүмүүст тусламжийн гараа сунгаж адислахын ач холбогдол юм. Эргэн тойронд тань байх олон хүн үе үе сэтгэлээр унадаг. Хэрэв та тэдэнд “Найн дахь эмэгтэйн” талаар мөн түүний урам хугарч, хувийн томоохон асуудалд орсныг нь Их Эзэн хэрхэн яг таг мэдэж байсан тухай хэлэх юм бол энэ нь харанхуйг гэрлээр солих болно. Үүнд тохирох сануулгыг ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) хэлсэн байдгийг санаарай. “Бурхан биднийг анзаарч, харж хандаж байдаг. Гэвч ингэхдээ бидний хэрэгцээг ихэвчлэн өөр хүнээр дамжуулан хангадаг.”<sup>8</sup>

Дэлхий дээр байх хугацаандаа үйлдсэн Есүс Христийн гайхамшгууд дундаас

Найн дахь эмэгтэйд тохинуулснаас илүү өр нимгэн, энэрэнгүй сэтгэл харуулсан нь цөөхөн. Энэ нь бид Түүний хувьд чухал бөгөөд Тэрээр хэзээ ч биднийг мартахгүй гэдгийг сануулдаг юм. Бид үүнийг мартаж өсгүй. ■

#### ЭШЛЭЛҮҮД

1. E. Mills, *Census of Palestine 1931: Population of Villages, Towns, and Administrative Areas* (1932), 75-ыг үзнэ үү.
2. S. Kent Brown, *The Testimony of Luke* (2015), 364-ийг үзнэ үү.
3. Brown, *The Testimony of Luke*, 365-ыг үзнэ үү.
4. Brown, *The Testimony of Luke*, 365-ыг үзнэ үү.
5. Исаиа 54:4-т Их Эзэн Израилын бэлэвсэн эмэгтэйд “Бэлэвсрэлийнхээ доромжлолыг цашид дурсахгүй” (New English Translation) хэмээн хэлсэн.
6. Brown, *The Testimony of Luke*, 365-ыг үзнэ үү.
7. Thomas S. Monson, in Joseph B. Wirthlin, “Lessons Learned in the Journey of Life,” *Liahona*, May 2001, 38.
8. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 82.



Та [lds.org/go/041917](https://www.lds.org/go/041917) руу орж, “Widow of Nain” видео бичлэгийг үзнэ үү.









Тэргүүн Зөвлөлийн  
хоёрдугаар зөвлөх  
**Ерөнхийлөгч**  
Хэнри Б.Айринг

# АВРАГЧИЙН ЧӨЛӨӨЛӨХ ХҮЧИНД ИТГЭ

Аврагчийн Цагаатгал болон Амилалт биднийг сорилт бэрхшээлтэй тулгарахад хүчирхэгжүүлэх буюу тэдгээрээс чөлөөлөх хүчийг Түүнд өгдөг.

**Х**айртай нэгнээ алдсан хүмүүст өмнөх зам нь гуниг зовлон, ганцаардлаар дүүрэн байж болно. Харин Аврагч Есүс Христийн Цагаатгал, Амилалтын талаар мэдлэггүй хүмүүст бүр ч хэцүү байж болох юм. Та нар Еммау орох зам дээр тааралдсан Түүний эргэлзсэн хоёр шавийг санаж байгаа байх. Амилсан Их Эзэн тэдний хажууд ирж, яагаад гунигтай байгааг нь тэднээс асуусан. Лук бидэнд хариултыг нь цэдэглэн үлдээхдээ

“Тэгтэл тэд Түүнд—Назарын Есүсийн тухай юм. Тэр бол Бурханы өмнө, бүх ард олны өмнө үг ба үйлсдээ хүчирхэг эш үзүүлэгч байсан юм.

Түүнд манай захирагчид болон ахлах тахилч нар үхлийн ял тулгаж Түүнийг цовдолсон.

Гэтэл Израилийг аврах гэж байсан Нэгэн мөн гэж бид Түүнд найдаж байв. Энэ бүхнээс гадна, энэ явдлаас хойш гурван өдөр боллоо” (Лук 24:19–21) хэмээсэн байдаг.

Тэрээр Израилыг гэтэлгэсэн нэгэн *байсан* хэмээх мэдлэг, гэрчлэлээсээ бид тайтгарлыг олж авдаг. Тэр мөн “үхлийн хүлээсийг тасчсан” (Мозая 15:23) нэгэн *байсан* юм. Бас Тэрээр “нойрсогсдоос анхны үр жимс” (1 Коринт 15:20) *байсан*. Тэрээр биднийг “эртнээс хайрлаж, хэсэг хугацаанд алдсан”<sup>1</sup> хүмүүстэйгээ мөнхөд холбогдох ариун сүмийн гэрээг боломжтой болгосон нэгэн *байсан*.



Энэхүү Христийн амилсны баярын үеэр би Аврагчийн чөлөөлөх хүчийн тухай хэдэн жилийн өмнө хэлсэн үгийнхээ хэсгээс хуваалцахыг хүсэж байна. Энэ нь уг үгийг бэлдэж, хэлэх үед намайг хүчирхэгжүүлсэн юм. Та нарыг унших үед ч энэ үг та нарыг хүчирхэгжүүлэх болтугай хэмээн би залбирч байна.

### **Аврагч бидний уй гашууг мэддэг**

Зарим хүний хувьд амьдрах цаг хугацаа нь эрт дуусдаг бөгөөд эцсийн эцэст бидний цаг хугацаа ч гэсэн дуусах болно. Бидний хүн нэг бүр хайртай хүнээ алдаж соригдох болно.

Би хэд хоногийн өмнө, эхнэр нь нас барснаас хойш уулзалдаагүй нэгэн эрэгтэйтэй тааралдсан юм. Нийтгээр тэмдэглэх баярын таатай сайхан өдөр санамсаргүй уулзах боломж надад тохиосон. Тэр над руу

инээмсэглэсээр дөхөн ирэв. Би эхнэр нь нас барсныг санаад, “Чи дажгүй юү?” хэмээн хүн болгоны л тавьдаг асуултыг тавилаа.

Түүний инээмсэглэл алга болж, нүдэнд нь нулимс цийлгэнэн, сэтгэлийнхээ угаас “Би зүгээр ээ. Гэхдээ маш хэцүү байдаг юм байна” хэмээн намуухан хэлсэн юм.

Та нарын ихэнхийн мэдэж байгаачлан, бидний хүн нэг бүр хэзээ нэгэн цагт *үүнийг* маш хүнд хэцүү гэдгийг олж мэдэх болно. Энэ сорилтын хамгийн хүнд хэцүү хэсэг бол хэн нэгнийг алдсанаас ирдэг уйтгар гуниг, ганцаардал, гарз хохирлыг яаж даван туулах вэ гэдэгт оршдог юм. Уй гашуу бол архаг өвчинтэй адилхан. Заримд нь уурлах юм уу шударга бус санагдах үе ч бий.

Аврагчийн Цагаатгал болон Амилалт биднийг ийм сорилт бэрхшээлээс чөлөөлөх





хүчийг Түүнд өгдөг. Тэрээр Өөрийн биеэр бидний бүх уй гашууг амссан юм. Тэр үүнийг Сүнсний өдөөлтөөр дамжуулан мэдэж болох байсан ч үүний оронд тэдгээрийг Өөрийн биеэр туулах сонголтыг хийжээ. Энэ талаар ийнхүү өгүүлсэн байдаг.

“Мөн болгоогтун, тэр бидний эцэг өвгөдийн нутаг болох тэр Иерусалимд, Мариагаас төрөх болно, тэр нь онгон бүсгүй, Ариун Сүнсний хүчээр бүрхэгдэж мөн хөл хүнд болгогдож, мөн хүү төрүүлэх, тийм ээ, бүр Бурханы Хүүг тээгч болж сонгогдсон мөн хонгорхон нэгэн байх болно.

Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно” (Алма 7:10–12).

Та нарын эргэн тойронд буй сайн хүмүүс хайртай нэгнээ алдсан уй гашууг тань ойлгохыг хичээх болно. Тэд уй гашууг тань мэдэрч ч болох юм. Аврагч уй гашууг ойлгож, мэдрэхийн зэрэгцээ зөвхөн хувь хүнийхээ хувьд мэдэрдэг уй гашууг *тань* ч хүртэл мэдэрдэг. Бас Тэрээр таныг төгс мэдэхээс гадна зүрх, сэтгэлийг тань хүртэл мэддэг.

### **Ариун Сүнсийг урь**

Та нарыг Ариун Сүнсийг тайтгарал, адислал авахаар урих үед л Аврагч та нарын хийж болох тэр олон зүйлээс аль нь хамгийн сайн тохирохыг олж мэдэх боломжтой болдог. Мөн та нар яг хаанаас эхлэх нь зүйтэй вэ гэдгийг Тэрээр мэдэх болно. Заримдаа энэ нь залбирал байж болно. Харин заримдаа энэ нь өөр хэн нэгнийд очиж тайтгаруулах явдал байж болох юм. Өвчнөөсөө болж хүч тэнхээ суларсан ч өөр нэгэн бэлэвсэн эмэгтэйг эргэж тойрсон нэгэн бэлэвсэн эмэгтэйг би танина.

*Аврагч бидний уй гашууг Сүнсний*

*өдөөлтөөр дамжуулан мэдэж*

*болох байсан ч үүний оронд*

*тэдгээрийг Өөрийн биеэр туулах*

*сонголтыг хийжээ.*

Би айлчилж очиход нь хамт байгаагүй ч Их Эзэн тэрхүү итгэлт шавьдаа өөр хүнд тусламжийн гараа сунгахыг сүнсээр өдөөж, ийнхүү хоёуланг нь халамжилж чадсан гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Уй гашууд автсан хүмүүсийг яг тэдэнд тохирсон байдлаар халамжлах олон арга зам Аврагчид байдаг. Гэхдээ Тэрээр үүнийг уй гашууд автсан хүмүүст болон тэдний эргэн тойрныхонд хамгийн сайн тохирох арга замаар хийдэг бөгөөд хийх ч болно гэдэгт та эргэлзэх хэрэггүй. Бурхан уй гашуугаас хүмүүсийг чөлөөлөхөд тэд Түүний өмнө бяцхан хүүхдийн адил даруу болсон байгаагаа мэдэрдэг явдал бол хэзээ ч үл хувирах зүйлсийн нэг юм. Итгэлтэй даруу байдлын хүчийг үзүүлсэн агуу жишээг Иовын амьдралаас харж болно (Иов 1:20–22-ыг үзнэ үү). Өөр нэгэн үл хувирах зүйл нь бас л Иовт байсан бөгөөд энэ нь Аврагчийн Амилалтын хүчинд итгэх бат бөх итгэл юм (Иов 19:26-г үзнэ үү).

Бид бүгдээрээ мөн нас барсан хайртай хүмүүс тань ч гэсэн амилуулагдана. Бид тэдэнтэй биесгүйгээр биш, харин үхэшгүй, хөгширч, сул дорой болохгүй биетэйгээр дахин уулзах болно.

Аврагч амилсныхаа дараа төлөөлөгчдөдөө үзэгдэхдээ тэдний уй гашууг хуваалцахын зэрэгцээ бидний хүн нэг бүрд тохиолдох уй гашууг мөн адил хуваалцсан юм. Тэрээр тэднийг болон биднийг “Амар амгалан та нарт байх болтугай. . .

Миний гар, Миний хөлийг хараач. Энэ чинь Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм гэв” хэмээн тайтгаруулсан (Лук 24:36, 39).

Их Эзэн биднийг уй гашуугаасаа хамгийн тохирох арга замаар чөлөөлөгдөх хүчээс хүртэхэд сүнсээр өдөөж чадна. Бид Их Эзэний өмнөөс бусдад үйлчлэх сонголтыг хийж болно. Бид бас Аврагч, Түүний сайн мэдээ, Сүмийнх нь сэргээлт, Амилуулалтынх нь талаар гэрчилж, зарлигуудыг нь сахиж болно.

Эдгээр сонголт бүгд Ариун Сүнсийг урин авчирдаг. Гагцхүү Ариун Сүнс л бидэнд таарсан арга замаар биднийг тайтгаруулах чадалтай. Харин Сүнсний өдөөлтөөр бид Амилуулалтын талаар гэрчлэлтэй болж, ирээдүйд болох гайхамшигт уулзалтаа тодорхой харж чадна. Би өөрийн таньдаг мөн хэзээ нэгэн цагт энгэртээ тэврэх болно гэдгээ мэдэх хүнийхээ булшны чулууг харж байхдаа тэрхүү тайтгарлыг



мэдэрсэн билээ. Үүнийг мэдсэнээр би уй гашуугаасаа чөлөөлөгдөхийн зэрэгцээ баяр хөөрөөр дүүрэн хүсэн хүлээх болсон юм.

Тэр бяцхан хүн насанд хүрч чадсан бол өөр сорилт бэрхшээлээс чөлөөлөгдөх хэрэгтэй байх байсан. Тэр хүн бүрд тулгардаг бие махбод болон сүнслэг байдлаараа Бурханд итгэлтэй хэвээр үлдэх эсэхээрээ соригдох байсан. Хэдийгээр бие махбод гайхамшигтай сайхан бүтээл ч гэлээ, үүний үйл ажиллагааг хэвийн явуулах гэдэг нь бидний хувьд өөр нэгэн сорилт юм. Хүн бүр өвчин зовлон, хөгшрөлтийн нөлөөг тэсвэрлэн давах ёстой.

### **“Чи даруу бай”**

Сорилт бэрхшээлээс маань чөлөөлөх хүч хүчин төгөлдөр. Энэ нь хайртай нэгнээ алдсанаар ирэх сорилт бэрхшээлээс чөлөөлөгдөхтэй адилхан ажилладаг. Чөлөөлөгдсөнөөр хайртай хүнийхээ амийг эргүүлэн авдаггүйтэй адил, бусад сорилт бэрхшээлээс чөлөөлөгдөх гэдэг нь тэдгээрийг авч хаяна гэсэн үг биш ээ. Биднийг Цагаатгалын хүч амьдралд маань ажиллаж эхлэхэд хүргэх тэрхүү сонголтуудыг хийх итгэлээ хөгжүүлтэл

*Аврагч уй гашууд автсан*

*хүмүүст болон тэдний*

*эргэн тойрныхонд хам-*

*гийн сайн тохирох арга*

*замаар халамжилдаг.*

Их Эзэн чөлөөлөхгүй байж ч болох юм.

Тэрээр бидний зовлонг хайхардаггүйдээ биш, харин биднийг хайрладаг тул үүнийг шаарддаг.

Тухайн үед Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч байсан Томас С.Марш амьдралын сөрөг зүйлээс чөлөөлөх Их Эзэний хүчийг хүлээн авах удирдамжийг авсан. Тэрээр хүнд хэцүү сорилт бэрхшээлтэй тулгарч байсан ба цаашид өөр олон сорилт бэрхшээлтэй тулгарна гэдгийг нь Их Эзэн мэдэж байсан. Би түүнд өгсөн зөвлөгөөг энд өөрийн





зөвлөгөө болгон та нарт өгье. “Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно” (Сургаал ба Гэрээ 112:10).

Их Эзэн биднийг үргэлж илүү зөв шударга болгох замаар чөлөөлөлт рүү хөтлөхийг хүсдэг. Энэ нь наманчлалыг шаарддаг. Энэ нь мөн даруу байдлыг шаарддаг. Тиймээс, Их Эзэнд биднийг асуудал бэрхшээл дундуур, ариусгалд авчрахыг хүсэж байгаа тэр газар луу гараас маань хөтлөн аваачих боломж олгохын тулд чөлөөлөлтөд хүрэх зам нь үргэлж даруу байхыг шаарддаг.

Сорилт бэрхшээл нь дургүйцэх, урам хугарахад хүргэж болно. Их Эзэнээр гараасаа хөтлүүлэхэд хэрэгтэй, надаас болон та нараас шаардагдах даруу байдал итгэлээс ирдэг. Энэ нь Бурхан үнэхээр амьд, Тэр биднийг хайрладаг бөгөөд хэдийгээр хүнд хэцүү байсан ч гэсэн Түүний хүссэн зүйлс үргэлж бидний сайн сайхны төлөө байдаг гэдэгт итгэх итгэлээс ирдэг.

Аврагч бидэнд тэрхүү даруу байдлыг харуулсан билээ. Тэрээр бидний төсөөлөн бодох, даван туулах, тэр ч бүү хэл дүрслэн хэлэх чадвараас давсан зовлон шаналлыг бидний өмнөөс Гетсеманийн цэцэрлэгт үүрч байхдаа хэрхэн залбирсныг нь та уншсан. Та түүний “Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч Миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг гэв” (Лук 22:42) хэмээх залбирлыг санаж байгаа.

Тэрээр Өөрийн Тэнгэрлэг Эцэг, агуу Елохимыг мэддэг мөн Түүнд итгэж найддаг байсан. Тэрээр бас Эцэгээ бүхнээс хүчтэй, дуусашгүй сайхан сэтгэлтэй гэдгийг мэдэж байсан. Хайрт Хүү нь бяцхан хүүхдийн адил даруухан үгсээр Түүнд чөлөөлөх хүчийг өгч туслахыг гуйсан.

### **Урам зориг, тайтгарал олж ав**

Эцэг Хүүгийнхээ сорилт бэрхшээлийг авч, чөлөөлөөгүй. Бидний төлөө Тэрээр үүнийг хийгээгүй бөгөөд Аврагчид ирсэн зорилгоо биелүүлж дуусгах боломжийг олгосон юм. Гэсэн хэдий ч бид Эцэгийн өгсөн тусламжийн талаар мэдсэнээр үргэлж урам зориг, тайтгарлыг олж авч чадна.

“Тэгтэл тэнгэрээс тэнгэр элч Түүнд үзэгдэн, Түүнийг тэнхрүүлж байлаа.

Тэр зовж, шаналж байсан тул маш шаргуу залбирч байлаа. Түүний хөлс нь цусны дусал мэт газарт дусалж байв.

Тийнхүү залбирсныхаа дараа Тэр босож шавь нар уруугаа очоод, уй гунигаасаа болж унтаж буй тэднийг олж хараад, тэдэнд—Та нар юунд унтана вэ? Босоцгоо, сорилтод орохгүйн тулд залбирцгаа гэж айлдав” (Лук 22:43–46) хэмээсэн байдаг.

Аврагч чөлөөлөх хүчийн төлөө залбирсан. Түүнийг сорилт бэрхшээлээс нь салгах биш, харин үүнийгээ гайхамшигтай сайн даван гарахад хангалттай тайтгарлыг өгсөн.

Дор бүрнээ соригдож байсан шавь нартаа өгсөн Түүний зарлиг бол бидэнд зориулсан удирдамж юм. Бид үүнийг нь дуулгавартай дагах,

*Есүс Христ биднийг үхэл болон нүглээс  
чөлөөлөхийн тулд бидний болон Тэн-  
гэрлэг Эцэгийн бүхий л хүүхдийн бүх  
нүглийн төлөөсийг төлсөн юм.*

агуу итгэл, даруу байдлаар босож, залбирах шийдвэрийг гаргаж чадна. Эцэст нь бид Марк номд нэмж оруулсан “Бос, явцгаа” (Марк 14:42) хэмээх зарлигийг дагаж чадна.

Үүнээс та амьдралд тулгарах биеийн болон сүнслэг сорилт бэрхшээлийг даван туулах зөвлөгөөг авч болно. Чадах бүхнээ хийсний тань дараа танд Бурханы тусламж хэрэгтэй. Тиймээс босож яв. Гэхдээ чөлөөлүүлэхийг гуйхын тулд сорилт бэрхшээлийг хүлээлгүйгээр аль болох эртнээс Түүний тусламжийг аваарай.

Бурхан Эцэг амьд бөгөөд биднийг хайрладаг гэдгийг би гэрчилж байна. Би үүнийг мэднэ. Бидэнд зориулсан Түүний аз жаргалын төлөвлөгөө төгс бөгөөд энэ нь үнэхээр аз жаргалын төлөвлөгөө юм. Есүс Христ амилсан бөгөөд бид ч мөн амилуулагдана. Тэрээр сорилт бэрхшээлтэй тулгарах үед биднийг харж халамжилж болохын тулд зовж шаналсан. Тэрээр мөн биднийг үхэл болон нүглээс чөлөөлөхийн тулд бидний болон Тэнгэрлэг Эцэгийн бүхий л хүүхдийн бүх нүглийн төлөөсийг төлсөн юм.

Есүс Христийн Сүмд Ариун Сүнс биднийг Эзэнийг дагах үед тайтгаруулж, цэвэршүүлэхээр ирдэг гэдгийг би мэднэ. Та нар хэрэгтэй үедээ мөн амьдралд тань тохиолдох бүхий л сорилт, бэрхшээл дундуур Түүний тайтгарал, хайр халамжийг хүртэх болтугай. ■

*2008 оны 1-р сарын 15-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “Чөлөөлөлтийн хүч” үгээс авав.*

### **ЭШЛЭЛ**

1. “Lead, Kindly Light,” *Hymns*, no. 97.





ГЕТСЕМИИ, КӨРК РИЧАРДСЫН УРАН ЗУРГИЙН ХЭСГЭС. ЧИДУН МОДНЫ МӨЧРИЙГ ГЕТТУ IMAGES ЭЭС АВАА.



# Ариун тэр цэцэрлэгт

Бодлогоиронгүй ♩ = 60-68

Үг, аяыг Тэмми Симистер Робинсон

1. А - риун тэр цэ - цэр - лэгт би Ач и - вээ - лээр ав - рагд - сан.  
 2. Та - ны хүс - лээ - рээ өргө - сөн, Тар - чил - сан би - ейг хар - сан.  
 3. Ая - гыг би у - руул - даа барьж, А - миа өгс - нийг тань дур - саж,

Гет - се - ма - нид сөг - дөн Та Ми - ний тө - лөө зал - бир - сан.  
 Бүг - дийн тө - лөө зов - сон Та Ми - ний тө - лөө нас бар - сан.  
 Ав - рагч та - ныг хүн - дэт - гээ. Та - ныг о - доо гэрч - илье би.

Ми - ний тө - лөө зал - бир - сан. Гэмш - сэн зүр - хээ би өр - гөө;  
 Ми - ний тө - лөө нас бар - сан. Гэмш - сэн зүр - хээ би өр - гөө;  
 Та - ныг о - доо гэрч - илье би. Гэмш - сэн зүр - хээ би өр - гөө;

Хүс - лийг тань өө - рийн бол - гоё. Гет - се - ма - нид сөг - дөн Та  
 Хүс - лийг тань өө - рийн бол - гоё. Бүг - дийн тө - лөө зов - сон Та  
 Хүс - лийг тань өө - рийн бол - гоё. Та - ны зов - лон ийн төг - сөг.

Ми - ний тө - лөө зал - бир - сан. Мин - ий тө - лөө зал - бир - сан.  
 Ми - ний тө - лөө нас бар - сан. Ми - ний тө - лөө нас бар - сан.  
 Та - ны тө - лөө амьд - арна би. Та - ны тө - лөө амьд - арна би.

© 2003 Tammy Simister Robinson. Бүх эрх хамгаалагдсан.

Энэхүү дуулыг ашгийн бус зорилгоор Сүм дээр болон гэр орондоо ашиглахаар хувилж болно.

Энэ мэдэгдэл хэвлэсэн хувь бүр дээр байх ёстойг анхаарна уу.

2019 оны 4-р сар





Ням гаргийн ангийн  
ерөнхий ерөнхийлөгчийн  
зөвлөлийн хоёрдугаар зөвлөх  
**Брайн К.Аштон**

## Хайр, баяр баясгалан, амар амгалангийн талаарх гурван сургамж

Эдгээр гурван зөвлөгөөг хэрэгжүүлэх нь таны амьдралд томоохон өөрчлөлтийг авчраад зогсохгүй Сүнсний үр жимсийг мэдрэхэд тань туслах болно.

**Б**и коллежийн оюутан байхдаа ирээдүйнхээ талаар их боддог байв. Би тэр ирээдүйдээ буюу коллежийн дараах амьдралдаа амьдралд минь томоохон өөрчлөлт авчирсан гурван чухал сургамжийг олж авсан юм. Эдгээрээс суралцахад та нарыг надтай адил цаг алдахгүй байх гэж найдан, уг сургамжуудыг та нартай хуваалцахыг би хүсэж байна. Тэдгээр нь танд амьдралдаа илүү их баяр баясгаланг олж авч, эцэст нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт өргөмжлөлийг хүртэхэд туслах болно.

### **1. Аз жаргал, амар амгалан, Ариун Сүнснийг эрэлхийл**

Би номлолоосоо эргэж ирээд, 6 сарын дараа, коллежийн 2-р курст байхдаа эхнэр Мэлиндатайгаа танилцсан юм. Би тэр даруй л Мэлиндатай гэрлэхийг хүссэн. Харин Мэлиндагийн хувьд тийм байсангүй. Тэр надтай гэрлэх нь зүйтэй гэсэн хариугаа таван жилийн дараа л авсан юм.



*Жижигхэн  
зүйлсийг хийж,  
Есүс Христийн  
золиослолд итгэж  
найдах юм бол  
нөхцөл байдал  
тань ямар байхаас  
үл хамааран  
та хайр, баяр  
баясгалан, амар  
амгаланг олох  
боломжтой.*

Тэрхүү таван жилийн хугацаанд амьдралын маань хамгийн хүнд хэцүү сорилт бэрхшээлийн нэг нь надад тохиолдож билээ. Би хэнтэй гэрлэхээ мэдэж байсан бөгөөд Сүнс хүртэл шавдуулж байсан ч тэр зорилгодоо хүрч чадахгүй л байв.

Намайг коллежоо төгссөний дараахан Мэлинда номлолд явахаар шийдсэн бөгөөд надаас холдохын тулд л явж байна даа гэсэн бодол надад зэрвэсхэн төрж билээ. Түүнийг номлолд байхад байхгүй зүйлдээ хэт анхаарнаас болж бүр хөөрхийлөлтэй байдалд орж байсан үе надад байсан. Гэхдээ би судраас суралцан, өдөр бүр залбирч, Сүмдээ үйлчилж, Ариун Сүнсийг амьдралд маань урин авчирдаг зүйлсийг хийхийг хичээж байлаа.

АНУ-ын Миннесотагийн Миннеаполист нэгэн хүйтэн өглөө эрт Сүмийн цуглаанд оролцохоор машинаараа явж байхад “Уг нь одоо надад үнэхээр зовлонтой байх ёстой доо. Миний хүссэнээр болж байгаа ганц ч юм байхгүй байтал би огтхон ч шаналахгүй байна. Би бүр гайхалтай аз жаргалтай байна гээч!” гэсэн бодол надад орж ирэв.

Өөрийнхөө хувьд туйлын хүнд хэцүү сорилт бэрхшээлтэй тулгарч байж би яагаад аз жаргалтай байж чадаж байгаа юм бол?

Хариултыг Галат 5:22–23 дээрх “Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайн сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм” гэсэн шүлгээс олж болно.

Амьдралдаа Сүнсийг авчирдаг зүйлсийг хийж байсан тул би Бурханы хайрыг мэдэрч байсан байв. Би баяр баясгалан, амар амгаланг мэдэрч байсан. Зовлон маань удаан үргэлжлэх байсан ч би аз жаргалтай хэвээр байх байв.

Гэр бүлдээ, амьдралдаа мөн гэрлэлтдээ хайр, баяр баясгалан, амар амгалангаар дүүрэн байх нь том байшин, сайхан машин, сүүлийн үеийн загварын хувцас, ажил

мэргэжлийн хувьд амжилттай байх эсвэл аз жаргал авчирдаг хэмээн дэлхийнхний хэлдэг өөр зүйлүүдээс ирдэггүй. Үнэндээ хайр, баяр баясал, амар амгалан нь Сүнснээс ирдэг тул эдгээрийг мэдрэх нь бидний зуурдын нөхцөл байдалтай холбоотой байх шаардлага огт байхгүй.

Бид үргэлж аз жаргалтай эсвэл бидний зуурдын нөхцөл байдал аз жаргалд хэзээ ч нөлөөлөхгүй хэмээн би хэлээгүй гэдгийг ойлгоорой. Үнэндээ бид гашууныг амсахгүйгээр чихэрлэгийг мэдэх боломжгүй (Сургаал ба Гэрээ 29:39 мөн Мосе 6:55-ыг үзнэ үү).

Заримдаа бид зовох хэрэгтэй. Цаашилбал, бие махбодын болон сэтгэл санааны зарим нөхцөл байдал бидэнд

асар их зовлон шаналлыг авчирч, Сүнсийг мэдрэхэд их хэцүү болгодог. Гэхдээ бид өөрсдийн амьдралд Сүнсийг байлгахыг хичээж, Бурханд итгэж найдах юм бол ихэнхдээ аз жаргалтай байж чадна.

Энэ нь үнэн болохыг би өөрийн туршлага дээр үндэслэн гэрчилж байна. Мэлиндаг номлолд байх үед болсон үйл явдлаас хойш, хэрэв амьдралдаа Сүнсийг авчирдаг зүйлсийг, тухайлбал бүх зүйл Бурханы хүслээр болж бүтнэ гэдэгт итгэж, хүлээн зөвшөөрөх юм бол би ихэнхдээ аз жаргалтай байдгаа олж харсан юм (Иаков 3:2-ыг үзнэ үү).<sup>1</sup>

## **2. Хуурамч мэдрэмжид бүү итгэ**

Сатан биднийг төөрөгдүүлж, залилан мэхлэхийн тулд Бурханы хийдэг бүх зүйлийн хуурамч хувилбарыг гаргадаг. Хэдийгээр Сатан бидэнд тийм биш гэж итгүүлэхийг оролдсон ч “ялзарсан мод ч сайн үр жимс өгч [чадахгүй]” (3 Нифай 14:18) хэмээн Аврагч бидэнд заасан. Сатан ялзарсан мод тул бидэнд “хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан [болон] өөрийгөө захирах байдл[ыг]” (Галат 5:22–23) мэдрүүлж чадахгүй. Харин ч Сатан биднийг зовоохыг хүсдэг (2 Нифай 2:27-г үзнэ үү).

Тэгэхээр Сатан юу хийдэг вэ? Тэр биднийг хууран мэхлэх гэдэг.

Миний найз, сонгогдсон нэгэн хууран мэхлэгдсэн юм. Найз маань номлолд үйлчилсэн ба ер бусын сайн номлогч байв. Тэр номлолоосоо буугаад, Сүнсийг амьдралд нь авчирдаг бас номлолд нь хүчирхэгжүүлж байсан бүх зүйлийг хийхийг хүсэж байлаа. Тэр нэг хэсэгтээ бүх зүйлийг хийсэн.



*Сатан биднийг*

*төөрөгдүүлж,*

*залилан*

*мэхлэхийн*

*тулд Бурханы*

*хийдэг бүх*

*зүйлийн хуурамч*

*хувилбарыг*

*гаргадаг. Аврагч*

*бидэнд “ялзарсан*

*мод ч сайн*

*үр жимс өгч*

*[чадахгүй]”*

(3 Нифай 14:18) хэмээн заасан.

Гэхдээ тэр номлолоос буусан олон найз нь ням гараг бүр сүмд ирдэг ч, сүмээс гадуур дэлхийнхний адил амьдарч байгааг харсан юм. Тэд аз жаргалтай байгаа юм шиг харагддаг байлаа. Тэд “хөгжилтэй” зүйлсийг хийж байв. Бас тэдний амьдралын хэв маяг түүнийх шиг олон зүйл шаарддаггүй мэт санагдаж байлаа.

Аажим аажмаар тэр номлолд нь сүнслэг хүч чадал өгдөг байсан жижиг зүйлсээ хийхээ болив. Түүнд гэрчлэл байсан ч тэр надад “Хэрэв би зөвхөн Сүмийн цуглаанд явж байхдаа зүгээр л, зам дээрээ байж л байх байсан ч” гээд цааш нь “харин сүнслэг байдлын хувьд би идэвхгүй байсан”<sup>2</sup> гэж хэлсэн юм. Тэр дэлхийнхний адил амьдарсан болохоор нэг муу сонголт нь дараагийн муу сонголт руу хөтөлсөөр, удалгүй тэр жирэмсэн болов.

Зөв шударга бус сонголтуудынх нь үр дагавар яваандаа гарч эхэлжээ. Тэр аз жаргалгүй байлаа. Үүнийгээ ч тэр өөрөө мэдэж байв. Аз болоход найз маань хууран мэхлэгдсэн гэдгээ ухаарч, наманчилсан юм.

Энэ түүх бидний хамгийн сайн нь ч гэсэн хууран мэхлэгддэг гэдгийг харуулж байна. Цаашилбал, түүний түүх бид хууран мэхлэгдэхгүйн тулд үргэлж соргог байх ёстой гэдгийг онцолж байгаа юм. Бид үүнийг Сүнсний бидний амьдралд авчирдаг жижигхэн зүйлсийг хийснээр хэрэгжүүлж чадна.

Өнөөдөр найз маань аз жаргалтай, зарлигуудыг дуулгавартай дагахыг хичээж, бие болон сүнсээрээ сайн мэдээнд идэвхтэй нэгэн болсон гэдгийг хэлэхдээ би баяртай байна.

Сатаны хууран мэхлэлт олон арга замаар ирдэг. Би зөвхөн цөөн хэдийг дурдъя.

Сатан бидэнд материаллаг зүйлсийг сүнслэг зүйлсээс дээгүүр тавих хэрэгтэй хэмээн итгүүлэхийг хичээдэг. “Би \_\_\_\_\_ завгүй, хэт ядарсан байна” гэж хэр их хэлж байгаагаа ажигласнаар нэн чухал гэж үзэж буй зүйлсийн маань дараалал алдагдсан байна

уу үгүй юу гэдгийг мэдэх боломжтой. Энэ хоосон зайд нь ариун сүмд орох, тохинуулах, судраас суралцах, тунгаан бодох, дуудлагаа хийх эсвэл бүр залбирах гэж гүйцээн бичиж болно.

Сатан бидний анхаарлыг сарниулахын тулд завгүй ажилладаг учраас бидэнд завгүй мэт санагддаг. Тэр бидний гарт байх ухаалаг утас, машин дахь радио, гэрт байх зурагт болон тоолохын аргагүй өөр олон зүйлийг ашиглан анхаарлыг маань үргэлж сарниулах гэдэг. Үүний үр дүнд бидэнд бодит байдлаас илүү завгүй мэт санагддаг.

Ийнхүү анхаарлыг сарниулахын өөр нэгэн үр дагавар бол бид тунгаан бодохоо улам бүр багасгаж байгаа явдал юм. Тунгаан бодох нь, ялангуяа судрын талаар бодох нь

илүү гүн хөрвөлт, илчлэлт рүү хөтөлдөг тул Сатан бидний анхаарлыг сарниулах гэж ажилладаг.

Сатаны өөр нэгэн хууран мэхлэх арга зам бол бидний гаднах үйлдэл доторх сэдлээс илүү чухал хэмээх санаа юм. Бидэнд сүнслэг зүйлсийг хийх зохих сэдэл байхгүй бол бид сайн мэдээний баяр баясгаланг мэдэрч чаддаггүй. Ийнхүү зарлигуудыг сахих нь бидэнд дарамт мэт санагдаж эхэлдэг бөгөөд ийм мэдрэмж төрүүлж чадах юм бол бид хийх ёстой хэмээн мэддэг зүйлээ хийхээ болих магадлал өндөр гэдгийг Сатан мэддэг.

Сатан мөн бидэнд баяр баясгалан, аз жаргал нь амар хялбар амьдралаас эсвэл үргэлж зугаатай хөгжилтэй байснаар ирдэг гэдэгт итгүүлэн, хууран мэхлэх гэдэг. Эдгээр нь ийм замаар ирдэггүй. Үнэндээ даван гарах ямар нэгэн зүйлгүйгээр баяр баясгалан буюу аз жаргал ирдэггүй (2 Нифай 2:11, 23-ыг үзнэ үү).

Миний дурдахыг хүссэн Сатаны хамгийн сүүлчийн хууран мэхлэлт бол тэр ёс бус явдал болон үүнийг дагалдан ирэх түр зуурын жаргал цэнгэл нь жинхэнэ аз жаргал хэмээн бидэнд итгүүлэхийг оролддог явдал юм. Ядаж тухайн цаг мөчид зарим мэдрэмж эсвэл сэтгэл хөдлөл бидэнд (1) Сүнсний үр жимснээс хүртэж байна гэж бодогдуулах, (2) бидний хүслийг тэдгээр үр жимс юм байна гэж бодогдуулах



(3) тэдгээрийг орлуулж болдог юм байна гэж мэдрүүлдэг болохыг Сатан мэддэг.

Жишээлбэл, Сатан биднийг хайрын оронд шунал тачаалыг эрэлхийлэхэд уруу татаж болно. Тэр биднийг урт хугацааны баяр баясгалангийн оронд жаргал цэнгэлийг хөөцөлдөхөд хүргэж болно. Тэрээр бидэнд амар амгаланг өгөхийн оронд анхаарлыг маань сарниулах гэж оролддог. Тэр биднийг өөрийнхөө зөв гэдэгт бат итгэлтэй, хичээнгүй, амь биеэ үл хайрладаг байлгахын оронд улс төрийн хувьд зөв, үргэлж дуулгавартай, зөвхөн зохих хэмжээнд сүнслэг байдалд анхаарлаа төвлөрүүлдэг байлгахыг хүсдэг. Түүний уруу таталтууд биднийг эргэлзэхэд хүргэж, улмаар зарлигуудыг дагахгүй байх нь аз жаргал авчирдаг хэмээх бодлыг бидэнд төрүүлдэг юм.

### 3. Жижиг зүйлсийг хий

Ихэвчлэн жижиг зүйлс бидний амьдралд Сүнсийг авчирч, хууран мэхлүүлэхээ сэргийлж, эцсийн эцэст бидэнд зарлигуудыг дуулгавартай дагаж, мөнх амьдралыг хүлээн авах хүч чадлыг олж авахад тусалдаг. Аврагч энэ зарчмыг Охайо дахь Көртландын Сүмийн ахлагчдад заасан. “Иймийн тул, сайныг үйлдэхэд шантрамтгай бүү бай, учир нь та нар агуу ажлын суурийг тавьж байна. Мөн агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг” (Сургаал ба Гэрээ 64:33).

Яагаад жижиг зүйлс тийм их ач холбогдолтой байна вэ? Дараагийн мөрөнд Аврагч “Их Эзэн зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг шаарддаг билээ” (Сургаал ба Гэрээ 64:34) хэмээн тайлбарласан. Яагаад Аврагч жижиг зүйлс хийхийг зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюунтай холбосон бэ? Учир нь бид жижиг зүйлсийг тогтмол хийснээр зүрх сэтгэл, оюун ухаанаа Бурханд зориулдаг ба энэ нь биднийг ариусган цэвэршүүлдэг (Хиламан 3:35-ыг үзнэ үү).



Энэхүү ариусан, цэвэрших нь бидний мөн чанарыг бага багаар өөрчилж, улмаар бид Аврагчтай улам бүр адилхан болдог. Энэ нь мөн Ариун Сүнсний өдөөлтийг хүлээн авах бидний чадварыг өсгөж, хууран мэхлэгдэх магадлалыг багасгадаг.

Ахлах сургуулиа төгсөх жил аав минь надад семинарын хичээлийг гэрээр заасан юм. Тухайн жилийн сэдэв Мормоны Ном байсан тул аав үүнийг шүлэг, шүлгээр нь хамтдаа уншиж, бид сурсан зүйлээ ярилцахаар шийдэв. Биднийг уншиж байхад аав надаас уншиж байгаа зүйлийнхээ талаар бодоход хүргэсэн асуултыг тавьж, ойлгохгүй байгаа зүйлсийг тайлбарладаг байлаа. Би Аврагчийн талаар суралцаж, Тэрээр үнэхээр нифайчууд дээр ирсэн ба Түүний Цагаатгалын ачаар нүглээсээ уучлагдах боломжтой гэдгээ мэдэрснээ өнөөдөр ч санадаг.

Аавтайгаа хамт судар уншсан тэр цаг хугацаа судрын үндэс суурийг тавих эхлэл байсан. Би уншиж байхдаа ямар нэгэн зүйлийг мэдэрдэг байсан. Магадгүй хамгийн чухал нь хүсэл, сэдэл, үйлдэл маань өөрчлөгдсөн явдал юм. Би илүү сайн байхыг хүсэх болж, хаана хууран мэхлэгдэж байгаагаа харж эхэлсэн ба илүү их наманчилдаг болсон. Тэгээд би коллежийн нэгдүгээр курсээ төгсгөх үедээ судраас өдөр бүр уншдаг болсон байлаа.

Энэ үеэр ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) Сүмийн гишүүдээс Мормоны Номыг уншиж, сурсан зүйлсээ амьдралдаа хэрэгжүүлэхийг хүссэн юм.<sup>3</sup> Тиймээс, би өөр юу ч уншиж байсан бай, нэмээд Мормоны Номоос бага ч гэсэн уншдаг болов.

Би номлолд байхдаа үнэхээр судраас суралцаж, үгс дээр нь найрлах гэгч юу болохыг мэдэж авсан. Би уншиж байхдаа Ариун Сүнсийг мэдрэхийн зэрэгцээ өөрийнхөө болон сонирхогчдынхоо асуултын хариултыг



*Хэрэв та суд-  
рын үгсэд,  
ялангуяа Мор-  
моны Номон  
дээр өдөр бүр*

*найрлах юм бол  
Сүнсийг өөрийн  
амьдралд урин  
авчрах бол-  
но гэдгийг би  
амлаж байна.*

их унших болсноор амьдралд маань улам их хүч ирэхийг би анзаарсан. Би илүү их баяр баясгалантай болсон байлаа. Би аливаа зүйлсийг илүү тодорхой ойлгож, илүү их наманчлах болж, бусдад тохинуулж, тэднийг аврахыг хүсэх болов. Сатаны хууран мэхлэлт, уруу таталтад өртөх маань багассан. Мөн би Аврагчийг илүү их хайрлах болсон юм.

Тэгээд 11-р сард нь би тойргийнхоо бишпоор дуудагдав. Ерөнхийлөгч Хинклигийн уриалсан зүйлийг хийж гүйцэтгэсэн минь намайг уг дуудлагад бэлдсэн. Түүнээс хойш

би ажил болон сүм дээр завгүй байх тусам судруудаас, ялангуяа Мормоны Номоос илүү их суралцах хэрэгтэй юм байна гэдгээ олж харсан юм.

Та ч бас өдөр бүр судрын үгсэд найрлах юм бол үүний адил адислал, хүчийг амьдралдаа авах боломжтой. Хэрэв та судрын үгсэд, ялангуяа Мормоны Номон дээр өдөр бүр найрлавал танд Сүнсийг өөрийн амьдралд урин авчирч, өөрийн эрхгүй өдөр бүр залбиран, илүү их наманчилж, долоо хоног бүр сүмд явж, ариун ёслолоос хүртэх нь илүү амархан байх болно.

Та жижигхэн зүйлсийг хийж, Их Эзэнд итгэж найдах юм бол нөхцөл байдал тань ямар байхаас үл хамааран хайр, баяр баясгалан, амар амгаланг олж авах болно гэдгийг би гэрчилж байна. Мөн би энэ бүхэн Есүс Христийн золиослолын ачаар боломжтой болсон гэдгийг гэрчилж байна. Сайн юм болгон Түүнээс ирдэг (Моронай 7:22, 24-ийг үзнэ үү). ■

*2017 оны 12-р сарын 5-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “Аз жаргал, заль мэх, жижигхэн зүйлс” үгээс авав.*

#### ЭШЛЭЛҮҮД

1. Бидний Христэд итгэх итгэл бат бөх байснаар нөхцөл байдал ямар байхаас үл хамааран бид Бурханы хайран дээр найрлах боломжтой.
2. Ярилцлагын тэмдэглэл, бичвэрүүд нь зохиогчийн эзэмшилд байгаа болно.

3. Ezra Taft Benson, “A Sacred Responsibility,” *Ensign*, May 1986, 77–78; see also “The Book of Mormon—Keystone of Our Religion,” *Ensign*, Nov. 1986, 4–7-г үзнэ үү.
4. Gordon B. Hinckley, “First Presidency Message: A Testimony Vibrant and True,” *Ensign*, Aug. 2005, 2–6-г үзнэ үү.

судраас олохоор эрэлхийлэхдээ баяр баясгаланг мэдэрч эхэлсэн юм.

Номлолынхоо дараа би өдөр бүр судрын үгс дээр найрласаар байв. Энэ дадал хэвшил миний амьдралд Ариун Сүнсийг урьдаг байсан тул Түүнээс цаг хугацаагаа илүү үр бүтээлтэй ашиглахад туслах удирдамжийг хүлээн авдаг байлаа. Үүний үр дүнд би сургуульдаа, хожим нь ажилдаа илүү сайн байх болсон юм. Сайн шийдвэр гаргахад ч илүү хялбар болов. Би илүү их залбирч, дуудлага бүр их хичээнгүйлэн хийх болсон. Өдөр бүр судрын үгс дээр найрлах нь миний бүх асуудлыг шийдвэрлээгүй ч амьдралыг илүү амар хялбар болгож байв.

2005 оны 8-р сард ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Мормоны Номыг он дуусахаас өмнө нэг биш удаа уншихыг уриалсан.<sup>4</sup> Би тухайн үед Мормоны Номоос өдөр бүр уншиж байсан тул Ифер эсвэл Моронай хавьд аль хэдийн очсон байв. Үүнээс хойш ганц, хоёрхон долоо хоногийн дараа би өөрийгөө ерөнхийлөгч Хинклигийн урилгыг биелүүлчихсэнд тооцсон юм.

Гэтэл тэр үед итгэлтэй гэрийн багш маань манай гэрт айлчлан ирэв. Тэр надаас ерөнхийлөгч Хинклигийн урилгыг хэрхэн биелүүлж байгааг асуув.

Би аз болж Мормоны Номыг ерөнхийлөгч Хинклигийн урилгаас өмнө уншиж эхэлсэн байснаа түүнд хэлсэн юм. Дараа нь би урилгыг нь хүлээн авч уншиж дуусгасан хэмээн өөрийгөө зөвтгөн хэлэв.

Харин гэрийн багш маань үүнийг арай өөрөөр харж байсанд би баярладаг. Тэр миний бодлыг эвтэйхэн залруулах үед Сүнс надад гэрийн багшийн маань зөв байсныг шивнэсэн.

Харин би жилийн эцэс гэхэд дахин уншиж дуусгахын тулд өдөрт хоёр бүлэг унших хэрэгтэй болж билээ. Мормоны Номоос илүү



## Хуй салхи хүртэл биднийг зогсоогоогүй

**Б**и номлолоосоо бугаад удаагүй байхдаа, бүжгэнд явах урилга хүлээн авсан юм. Бүжгэн дээр би утсаа алга болгосон бөгөөд нэг залуу надад олж өгч тусаллаа. Бид ярилцаж байхдаа, хоёулаа эргэж ирсэн номлогч бөгөөд бодол санаа, зорилгын хувьд олон зүйл дээр санал нийлж байгаагаар олж мэдэцгээв.

Бидний харилцаа гүнзгийрсээр, бид сүй тавьсан юм. Бид Вашингтон Ди Си ариун сүмийг 2018 оны 3-р сард засварт орохоор хаагдахаас өмнө тэнд лацдан холбуулахыг хүсэж байв. Харин ийм шийдвэр гаргасны маань дараа бидэнд сорилт ирсэн юм. Эхлээд би ажлаа алдаж, ариун сүм рүү аялах мөнгө цуглуулах ямар ч боломжгүй болов. Дараа нь биднийг гэрлэхийн өмнөхөн Пуэрто Рикод хуй салхи дайрч өнгөрнө гэсэн урьдчилсан мэдээ гарсан байлаа.

Мариа хуй салхи ирж, манай үзэсгэлэнт арлыг сүйтгэв. Дэлгүүрүүд хаагдаж, цахилгаангүй болж; уух ус,

хоол хүнс болон өөр бусад хэрэглээний зүйл ч олдхоо болов. Бид хүлээн авалтдаа ашиглахаар төлөвлөж байсан бүх зүйлээ алдсан юм. Бид хүлээн авалтаа цуцалж, хуримаа ч гэсэн цуцлах хэрэгтэй болов. Пуэрто Рико руу орж, гарахыг хязгаарлаж, хэр удаан ийм байхыг хэн ч мэдэхгүй байлаа. Би сэтгэлээр унах болж, төөрөгдөлд орж бас эргэлзэх болов.

Нэг орой би сүйт залуугайгаа хамт өөрсдийн нөхцөл байдлын тухай ярилцсан юм. Гарч болох эсэх нь тодорхойгүй, хүлээн авалт хийхгүй мөн хуримын хувцас ч үгүй болсон ч бид Их Эзэнд итгэх хэрэгтэй болохыг Сүнс батлав. Хамгийн чухал зүйл бол ариун сүмд лацдан холбуулах явдал байлаа. Бид Тэнгэрлэг Эцэгт хандан тусламж хүсэн залбирсан.

Пуэрто Рикогоос гадагшаа гарах нислэг дахин үйлдэж эхлэхэд бид нисэх төлөвлөгөөгөө шинэчлэн, лацдан холбуулах өдрөө өөрчиллөө. Хуй салхины дараа бид хэдэн долоо

хоногийн туршид гадагшаа холбогдож болохгүй байсан ч найзын маань гар утас ажиллаж байв. Тэр бидэнд утсаа ашиглуулан ариун сүмтэй холбогдоход тусалсан юм. Бид лацдан холбуулахад шаардлагатай бүх зүйлээ хийж чадсан билээ! Аялалд гарахаас хэдэн долоо хоногийн өмнө гэр бүлийнхэн болон найз нөхөд маань гутал, хувцас өгч, хуримд хэрэгтэй олон зүйлийг авахад тусалсан.

Энэ бүхний эцэст бид ариун сүмд орох үедээ, санааг маань зовоож байсан бүх зүйлээ ардаа орхив. Бид гар гараасаа барилцсаар ирээдүй рүүгээ алхлаа. Би Их Эзэний мутар биднийг хөтөлж байгааг мөн Түүнд итгэж найдах л юм бол бүх зүйл зүгээр болно хэмээн урамшуулахыг үнэхээр мэдэрсэн. Өнөөдөр бид хөөрхөн хүүтэй болж адислагдсан бөгөөд үүрд мөнхөд лацдан холбогдсон гэр бүл болсон. ■

**Корайма Сантьяго дэ Хэсүс,  
Пуэрто Рико, Сан Хуан**

**М**ариа хуй салхины дараа бид хуримаа цуцлах хэрэгтэй болов.





## “Энэ бол мөнх бус амьдрал шүү дээ”

Нэгэн өвлийн үдэш би бишопын хувьд ярилцлага хийсээр гэртээ оройтож ирэв. Би маш их ядарсан байв. Олон долоо хоног ажил дээр их ачаалалтай, дарамттай байсан бөгөөд гэр бүл, Сүмийн үүрэг хариуцлагуудаа гүйцэтгэхэд миний бие хүрэлцэхгүй байлаа.

Би маргааш өглөө нь ажилдаа явахын тулд уг орой машинаа засах хэрэгтэй байв. Би комбинзоноо өмсөж, бишопын үүргээ механикчийн үүргээр солив. Хүйтэн гараашийн шалан дээр, машины доор хэвтээд, би ажиллаж эхэллээ. Би өдөржингөө өчнөөн их ажилласан байтлаа яагаад даарч, ядарч, гар хуруугаа өвдтөл ажиллах хэрэгтэй гэж? Миний тэвчээр алдагдан, гомдоллож, Тэнгэрлэг Эцэгтгээ хандан залбирсан юм.

“Та надад жаахан ч гэсэн тусалж болдоггүй юм уу?” гэж би хэллээ. “Би сайн эцэг, нөхөр, бишоп байх гэж мөн зарлигуудын дагуу амьдрах гэж чадлаараа хичээж байна. Би түр зуур ч гэсэн амсхийвэл илүү сайн үйлчлэхгүй гэж үү? Надад үүнийг засаж дуусаад, орондоо ороход туслаач” гэв.

Гэнэт надад “Энэ бол мөнх бус амьдрал шүү дээ” гэсэн тод, томруун үгс оюун ухаанд минь орж ирлээ.

“Юу?” гэж намайг хэлэхэд

“Энэ бол мөнх бус амьдрал шүү дээ” гэсэн үгс дахин орж ирлээ.

“Энэ бол мөнх бус амьдрал шүү дээ” гэсэн үгс гурав дахь удаагаа орж ирэхэд оюун ухаан, зүрх сэтгэл минь ойлголтоор дүүрэв. Эдгээр үг миний сүнсэнд зориулагдсан байлаа. Энэ нь “мөнх бус амьдрал” байсан бөгөөд би Тэнгэрлэг Эцэгийн хүсдэг шиг тийм хүн нь болоход надад тусалдаг өсөлт хөгжлийг мэдэрч байсан байв. Яг л Сүнс надад “Чи дэлхий дээрх энэ аяллынхаа үеэр ямар ч зовлон бэрхшээлийг туулахгүй гэж бодсон юм биш биз?” гэж хэлж байгаа мэт байсан. Хүйтэн бетонон шалнаас босохдоо би өөр хүн болсон байлаа.

Бид тэдгээрт хэрхэн хандахаас шалтгаалан, сорилт бэрхшээлийг Тэнгэр дэх Эцэгийнхээ бидэнд өгсөн бэлэг хэмээн харж болно. Тэрээр биднийг Өөрт нь ханддаг болгож сургахын тулд бидэнд сорилт бэрхшээлийг өгдөг. Харин Түүнд хандсанаар бид суралцаж, сүнслэг өсөлт хөгжлөөр адислагддаг.

*Намайг машин дээрээ ажиллаж байхад оюун ухаанд минь тодорхой үгс орж ирэв.*

Тэрхүү хүйтэн шөнө, гараашийнхаа хүйтэн шалан дээр байхад оюун ухаанд минь орж ирсэн тэр үгс намайг 35 гаруй жилийн туршид адисалсан. Би ямар ч зовлон бэрхшээлийг үр ашиггүй өнгөрөөхгүй байхыг хичээдэг. Би мөн сорилт бэрхшээлийг өөр ямар ч арга замаар сурахгүй байх байсан зүйлсийг сурч мэдэх боломж бололцоо хэмээн хардаг. ■

**Ричард Ж.Андэрсон, АНУ, Юта**



# Аавынхаа дуулж байгааг харах нь

**Б**и АНУ-ын Хавайн Хонолулу дахь номлолдоо очоод, дөрвөн сар хагасын дараа татаж унан, эпилепси өвчин гэж оношлогдсон юм. Дараагийн хэдэн сарын турш бид эмнэлэгт очиж үзүүлэн, тоо томшгүй олон шинжилгээ өгч, сэтгэлээр унахуйц их гаж нөлөөтэй шинэ эм хэрэглэх болов.

Энэ явдал болох хүртэл би анхаарлаа зөвхөн номлолын ажилдаа хандуулсан байсан тул гэрээ тийм ч их санадаггүй байлаа. Харин унадаг болсноос хойш сэтгэл тавгүйтэх болсон юм. Би эцэг эхээ санаж, гайхалтай сайхан хүмүүсээр хүрээлэгдсэн байсан ч ганцаардах болов. Гэртээ буцахыг хүсээгүй ч амар амгаланг мэдрэхийг хүсэж байлаа.

Номлолын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр би эцэг эхтэйгээ утсаар ярьж, ууж буй эмийнхээ талаар ярьсан юм. Аавын маань Ариун сүмийн талбайн табернаклын найрал дуунд

орох олон жилийн мөрөөдөл биелсэн байсан бөгөөд тэр маргааш нь эхлэх байсан Ерөнхий чуулганаар надад зориулан зүрх сэтгэлээсээ дуулна гэж хэллээ.


Маргааш өглөө нь би надад гарцаагүй хэрэгтэй байсан амар амгалангийн төлөө залбирав. Ерөнхий чуулганы үеэр би өөрт байсан хэдэн тодорхой асуултынхаа хариултыг авч, дахин удирдамж авч чадна гэдэгтэй итгэлээ. Ерөнхий чуулганы нээлтээр найрал дуучид “Dearest Children, God Is Near You” (*Hymns*, no. 96) дууллыг дуулав. Эхний ганц минутад л би аавыгаа зурагтын дэлгэцээр харлаа. Камер түүний царайг нэлээн удаан харуулав.

Нүдийг минь нулимс бүрхэн, гайхалтай амар амгалан намайг нөмрөн авлаа. Бурхан надад хайртай гэдгийг би мэдэрч байв. Тэр өдөр надад яг юу хэрэгтэй байсныг, тухайлбал Тэрээр миний дэргэд

байж, намайг хэн болохыг мэддэг гэдгийн энгийн баталгаа хэрэгтэй байсныг би мэдэж авч билээ. Би Бурханы хайрыг, улмаар гэр бүлийнхээ болон хамтрагчийнхаа мөн номлолын ерөнхийлөгчийнхөө хайрыг мэдэрсэн. Одоо би өвчнөө дарамт гэж үзэхийн оронд Их Эзэнтэй илүү ойртох боломж хэмээн харах болсон.

Миний биеийн байдал сайжирсан ч бүрэн эдгээгүй. Эцэст нь би цагаасаа өмнө номлолоосоо буусан ч Бурхан байгааг мөн Тэр намайг хайрладгийг мэдсэн. Энэ баталгаа олон зовлон шаналал, харанхуй цаг мөчүүдэд итгэл найдварыг надад өгч байсан юм. Зарим нь үүнийг тохиолдлын зүйл гэж бодож болох ч аавыгаа Бурханы хайрын тухай дуулахыг харсан явдал миний хувьд хэрэгтэй үед өгөгдсөн бяцхан гайхамшиг байж билээ. ■

**Мариа Ока, АНУ, Калифорни**



**А**авыгаа зурагтын дэлгэцээр харахад нүдийг минь нулимс бүрхлээ.

# Рикардогийн урилга

**Б**и Сүмийн үйл ажиллагааны талаар сонсонгуут гишүүн бус 10 хүнийг үргэлж урьдаг. Үүнийг би олон жилийн турш хийсээр ирсэн. Би урилга хийж, цагаан дугтуйд хийгээд, Сүнсний удирдамж зааврын төлөө залбирч, дараа нь урилгуудаа тараадаг. Арвуулаа ирэх нь ховор ч гэлээ, нэг нь ч гэсэн ирвэл надад амжилтад хүрсэн мэт санагддаг.

Хэдэн жилийн өмнө би гэрлэсэн хосуудад зориулсан галын дэргэдэх ярилцлагын 10 урилга бэлдсэн юм. Би ажлынхаа есөн хүнд тарааж өгсний дараа нэг урилга үлдэв. Үүнийгээ хэнд өгөхөө би мэдэхгүй байлаа. Хэдэн минутын дараа борлуулалтын ажилтан Рикардо миний ширээний хажуугаар өнгөрөв. Хэдийгээр тэр манай өөр нэг ажилтны сүмийн үйл ажиллагаанд очих урилгаас татгалзсан ч надад түүнийг урих хэрэгтэй гэсэн мэдрэмж төрлөө. Рикардо сонирхохгүй байх л даа.

Гэтэл түүнийг миний ширээний хажуугаар дахин өнгөрөх үед надад нөгөө мэдрэмж дахиад төрлөө. Тэр орж ирсэн даруйдаа гарсан тул надад түүнтэй яриа өрнүүлэх боломж олдсонгүй. Хэрэв Рикардод урилга өгөх ёстой юм бол түүнийг эргүүлж ирүүлээч гэж би залбирлаа.

Залбирч дууссаны минь дараа Рикардо надаас ямар нэг зүйл асуухаар эргэн ирэв. Дараа нь би түүнд “Рикардо, манай сүм дээр гэрлэсэн хосуудад зориулсан үйл ажиллагаа болох гэж байгаа. Бид өдөр бүрийг хэрхэн аз жаргалтай өнгөрүүлэх талаар туршлагаасаа хуваалцах юм. Дараа нь бүжиг болно. Би чамайг урьвал чи ирэх үү?” хэмээн асуулаа.

“Мэдээж!” гэж Рикардо хэлсэн ч түүний хариултад би итгэсэнгүй.



**Б**и ажлынхаа есөн хүнд урилга тарааж өгсний дараа нэг урилга үлдэв. Үүнийгээ би хэнд өгөхөө мэдэхгүй байлаа.

“Ямар ч байсан би өөрийн хийх зүйлийг хийлээ” гэж би дотроо бодлоо.

Эхнэр бид хоёр үйл ажиллагаанд эрт ирж, орж ирж байгаа хүмүүсийг угтан авч, мэндчилэв. Гэнэт би Рикардог эхнэр Рэжинатайгаа хамт байхыг олж харлаа. Би тэднийг эхнэртэйгээ болон ирсэн зарим хүнтэй танилцуулав. Тэр орой Рикардо эхнэртэйгээ хамт цагийг сайхан өнгөрүүлж байгаа харагдлаа. Тэд илүү ихийг сурч мэдэхээр ням гарагт сүмд ирнэ гэдгээ хэлэхэд би гайхав.

Рикардо, Рэжина хоёр хоёр хүүхэдтэйгээ хамт илүү ихийг сурч

мэдсэн. Эцэст нь тэд Сүмд нэгдсэн юм. Дараа нь тэд ариун сүмд лацдан холбуулсан. Рикардо надад эхнэртэйгээ салах талаар ярьж байсан гэдгээ мөн яг тэр мөчид Их Эзэн түүнийг миний оффис руу хөтөлсөн гэдгийг надад хэлсэн юм.

Тэр үйл явдлаас хойш би Рикардог урилгыг маань хүлээн авахгүй гэж бодож байсандаа Бурханаас уучлалт хүссэн билээ. Энэ явдлаас би бүх хүнийг урихын ач холбогдлын талаар сурсан. Чухам хэн нь хүлээж авахыг та мэдэхгүй шүү дээ. ■

**Мартин Аполо Кордова, Бразил, Парана**



# Бизнес цэцэглэж байна

Жошуа Ж.Перки

Сүмийн сэтгүүл

Бие даах чадвар хөгжүүлэх ангид сурсан зүйлийнхээ ачаар Тэдди Рэйэсийн хувьд нэг хаалга хаагдахад, удалгүй өөр нэгэн хаалга нээгдсэн байна.

**Д**оминиканы Бүгд Найрамдах Улсын Санто Домингод үүрийн 4:00 болж байв. Тэдди Рэйэс аль хэдийн босож, ажиллаж эхэлсэн байлаа. Тэр цэцэглэж буй бизнесээ авч явахын тулд өнөөдөр шаргуу ажиллах хэрэгтэй. Тэр эхлээд улаан лооль, талхаа зүснэ. Дараа нь өөрийн тусгай сүмсээ хийнэ.

6:00 гэхэд хоёр ажилтан нь ирж түүнд туслах бөгөөд бэлтгэл ажил хурдасна. 8:00 гэхэд тэд 300 хачиртай талх хийн, тус бүрийг хүнсний гялгар цаасаар ороогоод, ууталсан байлаа. Дахиад 6 ажилтан нэмэгдэн ирж, бүгдээрээ худалдан борлуулах ажилдаа орно.

9:00 гэхэд багийнхныгаа хооллохоор хадгалсан гурав дөрөвхөн хачиртай талхнаас бусад нь борлууллагдсан байна.

Тэддигийн хувьд бизнес сайн явж байгаа аж. Гэхдээ түүний хувьд бүх зүйл дардан шулуун байсангүй. Үнэндээ сүүлийн таван жилийн хугацаанд өөрийн сонгосон мэргэжлээр буюу хуульчаар тогтвортой ажил олж чадахгүй байжээ.

Тэгэхээр Тэдди хэрхэн үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгдөг байснаа хүмүүст хачиртай талх зарах болов? Мэдээж амар хялбар байгаагүй. Гэхдээ тэр Сүмийн бие даах чадвар



хөгжүүлэх санаачилгаар дамжуулан ангиас сурсан зарчмуудаа ягтшал хэрэгжүүлсний ачаар энд хүрч чадсан байв.

### **Ажлын байраа алдсан нь**

Таван жилийн өмнө Тэддигийн амьдрал сайхан харагдаж байв. Тэр сайхан ажлын байранд хуульчаар ажиллан, дөнгөж гэрлэчихсэн мөн эхнэртээ баптисм хүртээгээд байлаа. “Гэхдээ бидэнд асуудал тулгарч, би ажлаа алдсан” гэж тэр хэлсэн юм.

Дараагийн дөрвөн жилийн туршид Тэддид ажил олдохгүй хэцүү байв. “Хийж болмоор ажил олон байсан ч хэн ч надад ажлын хөлс төлөхийг хүсэхгүй байлаа. Би бие дааж төрөл бүрийн ажил хийх гэж үзсэн ч нэг л болж өгөхгүй байсан” гэж тэр хэлсэн юм.

Түүний эхнэр Стефани сайн ажилтай байсан ч цалин нь сар бүрийн зарлагыг төлөхөд хүрэлцэхгүй байлаа. Хос залуу удалгүй хүүхэдтэй болов. Тэд баяртай байсан ч, санхүүгийн байдал нь улам бүр хүндрэв. Тэд байшингаа алдаж, машинаа зарж, хураасан бүх мөнгөө хэрэглэж дуусжээ. Удалгүй тэд Стефанийн ээжийн эзэмшдэг жижигхэн байшинд нүүж оров.

Гэсэн хэдий ч Тэдди бууж өгсөнгүй. Удалгүй гэнэтийн сайхан боломж өөрөө гарч ирэх нь тэр.

### **Бие даасан байдлын хүч**

Олон жил зовсны эцэст Тэдди өөрчлөгдөх цаг болсон гэдгээ мэдэж байлаа.

Тэрээр “Би Сүмийн бие даах чадвар хөгжүүлэх ангид суухаар шийдлээ. Би энэ ангийн талаар сондог байсан ч надад зориулсан зүйл биш гэж дандаа боддог байв. Ангид зөвхөн бие дааж юм хийх талаар л

ярьдаг гэж боддог байлаа. Харин ангиуд гайхалтай байсан” гэв.

Эхлээд Тэдди Хувийн санхүү гэсэн бүлэгт хамрагдсан аж. Дараа нь Хувийн бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь бүлэгт оров. Бүлгийн ангиуд Тэддид хэрэгтэй байсан бизнесийн мэдлэгийг өгөхөөс гадна сүнслэг байдлын хувьд өсөж хөгжихөд нь тусалсан байна.

“Тэр ангиудад сууснаар бүх зүйлийг өөрчилсөн. Би тэдний заасан бүх зүйлийг хийхээр шийдсэн юм. Мөн миний санхүүгийн байдал ч тэр даруй өөрчлөгдсөн. Би аравны нэгээ бүрэн төлж, өдөр бүр залбирч, судраас суралцан, итгэлээ хөгжүүлж эхэлсэн юм. Бүх зүйл өөрчлөгдөж, би мөнгө хуримтлуулж, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих болсон. Бүх зарчим намайг адисалсан” хэмээн тэр хэлэв.

Бизнесээ эхлүүлж, өргөжүүлэх нь бүлэгт Тэдди амьдарч байгаа газартаа ашигтай байх боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлж сурчээ. Түүнийг хүмүүсийн хайж байгаа зүйлд үнэлгээ хийж байх үед сүнслэг өдөөлт орж ирэх болов. Түүний амьдарч байсан газарт хүмүүс шинэхэн хачиртай талханд дуртай байхаас гадна хүргүүлэхийг хүсдэг байсан байна.

“Олон ресторан өөрийн гэсэн онцгой сүмстэй байдаг ба тэр нь хоолыг нь бусдаас ялгаруулдаг байв. Тиймээс би хачиртай талхныхаа сүмсийг өөрөө найруулсан юм” гэж Тэдди хэлэв.

### **Бизнесээ хөгжүүлсэн нь**

Бизнесээ нээсэн өдрөө Тэдди хачиртай талх гучийг хийжээ.

“30 минут өнгөрсний дараа намайг гэртээ ирээд, буйдан дээрээ хэвтэж байгааг харан, эхнэр маань санаа зовсон аж. Тэр надаас гэртээ

ийм эрт юу хийж байгаа юм бэ, хачиртай талх зарж байх ёстой биш билүү гэж асуусан. Харин би аль хэдийн бүгдийг нь зарсан байлаа!” гэж тэр хэлжээ.

Тэдди дараагийн хэдэн сарын туршид орон нутгийнхаа бизнес, сургуулиудтай холбогдсон байна. Ихэнх нь хачиртай талх авахыг хүсэж байсан ба түүний бизнес ч өсөж эхэллээ. Тэр шинэхэн ногоог муутгахгүй хадгалахын тулд юу хийх ёстойг хурдан сурав. Тэр мөн онцгой сүмсээ хэр удаан хадгалахаа яг таг мэддэг болжээ. Тэр талхаа захиалж, орой болгон авдаг байна. Даваа гараг гэхэд муудахааргүй, хямдарсан ногоог бямба гарагт худалдан авдаг болов.

Удалгүй тэр олон төрлийн хачиртай талхны захиалга авдаг болсон бөгөөд онцгой үйл явдлуудад зориулсан захиалгынх нь тоо улам өсдөг болжээ. Түүнд тусламж хэрэгтэй болсон бөгөөд ажилтан авч эхлэв.

Орон нутгийнхаа сургууль, бизнесстэй найрсаг харилцаа тогтоосноор Тэдди тогтмол худалдан авах чадвартай, идэвхтэй үйлчлүүлэгчидтэй болжээ. Дөрвөн сарын дотор тэр 8 ажилтан авч, өдөр бүр 300 хачиртай талх хийж, долоо хоногийн 5 өдөр зардаг болсон юм. Түүний борлуулалтын баг сургуулиуд амарсан зуны цагаар хүртэл хачиртай талх зарж, маш үр дүнтэй ажиллаж чадсан байна. Харин одоо Тэдди бизнесээ дахин өргөжүүлэхэд бэлэн.

Тэр бие даах чадвар хөгжүүлэх ангид суусан тул хачиртай талхны бизнес эхлүүлэх сүнсний удирдамжийг хүлээн авсан. “Сүмийн энэхүү удирдамж болон хүлээн авсан адислалынхаа ачаар Сүм болон Есүс Христийн талаарх гэрчлэл маань хүчирхэгжсэн” гэж тэр хэлсэн юм. ■





## Бидний хүү бол Тэнгэрлэг Эцэгийн хүү

Жерлин Мөрфи

**Б**идний бяцхан өхөөрдөм хүү Хэйдэн энэ дэлхийд мэндлэхдээ хөв хөх царайтай, амьсгалж ч чадахгүй, амьдрах гэж тэмцсээр ирсэн. Тэр уйлахгүй бас хөдлөхгүй байв.

Эмч, сувилагчид эмнэлгийн өрөө рүү гүйлдэн ирэхэд би ямар нэгэн муу зүйл боллоо гэдгийг мэдсэн. Миний нөхөр, аав хоёр Хэйдэнд санваарын адислал түргэхэн өгсөн бөгөөд түүнийг эрчимт эмчилгээний тасаг руу яаралтай шилжүүлсэн юм. Удалгүй түүнийг зүрхний ховор тохиолддог гажигтай болохыг тогтоов. Хэдэн өдрийн дараа тэр хэд хэдэн зүрхний мэс засалд орж билээ.

Санваарын адислал, мацаг, залбирлын гайхамшигт хүчийн ачаар Хэйдэн байж болох бүхий л зүйлийг даван гарч, амьд үлдсэн юм. Бид хүүгээ гэртээ авчран, шинэ амьдрал эхлүүлж байгаадаа маш их баярлаж байв.

Хэйдэн бидний амьдралд хязгааргүй их баяр хөөрийг авчирсан юм. Бид түүнийг хайрлаж, өхөөрддөг байв. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам хүүгийн маань эрүүл мэнд хүсэн хүлээж байснаар сайжрахгүй л байлаа. Хэдийгээр мэргэжилтнүүд бие нь аяндаа сайжирна гэсэн боловч хүүдээ туслах гэж хичээх тусам сэтгэл минь зовнисон хэвээр л байв.

Нөхөр бид хоёр Хэйдэний өвчний талаар боломжийнхоо хэрээр судалж, бас эмчийн хий гэж хэлсэн бүхнийг хийж байв. Гэсэн ч сайжрахгүй л байлаа.

Би ядарч туйлдан, сэтгэлээр унах болсон юм. Би Тэнгэрлэг Эцэгт хандан, Хэйдэнд тусалж чадах хүнийг олоход бидэнд туслаач хэмээн

гуйсан боловч тусламж ирэхгүй л байлаа. Хэйдэний биеийн байдал улам дордов. Тэр унаж тусах болж, бид түүнийг алдчих вий хэмээн эмээх болсон.

Нэг орой би хариулт эрж, шөнө хүртэл суунгаа Хэйдэндээ захиа бичив. Би түүнд ямар их хайртай мөн түүний амьдралыг хөнгөлөхийн тулд ямар их хичээж байгаагаа бичиж билээ. Түүнд хэрэгтэй тусламжийг өгөхийн тулд амьдралынхаа үлдсэн өдрүүдийг зарцуулна гэдгээ би амлав.

Урам хугаралт, тодорхой бус байдал гэнэт намайг эзэмдэв. Би өвдөг сөгдөн, Тэнгэр дэх Эцэгээсээ “Яагаад?” гэж асуулаа. Би хүүдээ туслахаа хэзээ ч зогсохгүй гэдгээ мэдэж байсан тул Тэрээр надад Хэйдэнийг илгээсэн гэж бодож байсан юм. Тийм байтал яагаад надад хариулт олдохгүй байгаа юм бол? Яагаад шинэ эмч, шинэ эмчилгээ бүрийн дараа дахиад л мухардалд ордог билээ? Тэнгэрлэг Эцэг Хэйдэнд хайртай биш гэж үү?

Би тэр цаг мөчийг хэзээ ч мартахгүй. Гэнэт хайрын мэдрэмж намайг бүрхэн авав. “Жерлин, чи түүнийг Надаас илүү хайрладаг гэж бодож байна уу?” гэсэн өмнө нь огт орж ирж байгаагүй бодол надад төрөв.

Би мэл гайхав. Цаг зогссон мэт боллоо. Нүднээс минь нулимс урам хугарснаас биш, харин итгэл найдвар, ойлголт, хайрыг мэдэрсэн учир урсаж эхэлсэн юм.

Яг тэр үед бүх зүйл өөрчлөгдөв. Миний зүрх сэтгэл зөөлөрч, тавьдаг асуулт маань ч өөрчлөгдсөн юм. Тэнгэр дэх Эцэг минь

Хэйдэнийг төгс хайрладаг гэдгийг би одоо мэдэх болсон. Хэйдэн энд өөрийн хэрэгцээнд тохирохуйц өсөж хөгжих, сурч боловсрох боломжтой ирсэн. Тэр бидний хүн нэг бүрийн адил өөрийн гэсэн чадвартай, асуудалтай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энэ дэлхий дээр онцгой зорилготой ирдэг Тэнгэрлэг Эцэгийн үнэ цэнтэй, хайртай хүүхдүүд гэдгийг би мэдэж авсан юм.

Нөхөр бид хоёр үргэлж хариулт, адислалууд хүлээн авдаг ч тэдгээр нь бидний хүссэн биш, харин Их Эзэний хүссэн цаг хугацаанд ирдэг.

Хэйдэнд мөнх бус амьдралдаа амжилт гаргахад туслах зөв ном, эмчилгээ мөн сургууль, багш руу Тэрээр биднийг хөтөлсөн. Бид Хэйдэнийг өөрсдийн хүссэн замаар биш, харин Тэнгэр дэх Эцэгийнхээ түүнд зориулсан замаар явуулахыг хичээдэг. Бид Хэйдэнд бурханлаг чадавхдаа хүрч, Тэнгэрлэг Эцэгийн түүнд зориулсан амьдралаар амьдруулахын тулд чадах бүхнээ хийдэг. Хэйдэн бидний хүүхэд болохоосоо өмнө Түүнийх байсан гэдгийг ойлгосноор бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний талаар улам тодорхой мэдэх болсон юм. ■

*Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.*

---

“Чи түүнийг Надаас илүү хайрладаг гэж бодож байна уу?” гэсэн өмнө нь хэзээ ч бодогдож байгаагүй бодол санаанд минь орж ирэв.



#### **БИЕ МАХБОД: ҮНЭТ БЭЛЭГ**

“Ямар нэгэн үл мэдэгдэх шалтгаанаар зарим хүн хөгжлийн бэрхшээлтэй төрдөг. Биеийнх нь тодорхой хэсэг согогтой байж болно.

Зохицуулах системийнх нь тэнцвэртэй байдал ч алдагдсан байж болно. Түүнчлэн бүх хүний бие өвчин, үхэлд өртдөг. Гэсэн хэдий ч бие махбодын бэлэг бол өөрөө гайхамшиг юм. Үүнгүйгээр бид баяр хөөрийн бүрэн байдлыг хүлээн авч чадахгүй.

Бурханлаг чадавхдаа хүрэхийн тулд төгс биетэй байх шаардлагагүй. Үнэндээ, хамгийн энхрий зөөлөн сүнснүүд хамгийн сул дорой биед оршдог. Сул дорой биетэй хүмүүс сорилттой тулгардаг тул тэд асар их сүнслэг хүчийг хөгжүүлсэн байдаг. Ийм хүмүүс итгэлтэй бөгөөд дуулгавартай хүүхдүүддээ зориулан Бурханы бэлдсэн бүх адислалыг хүртэх эрхтэй.”

President Russell M. Nelson, “We Are Children of God,” *Ensign*, Nov. 1998, 86–87.



# ЭМГЭНЭЛТ ЯВДЛЫГ ДАВАН ГАРАХ НЬ

Эрт орой нэгэн цагт хүүхдүүд гэртээ юм уу гэрээсээ хол байхдаа эмгэнэлт зүйлтэй учрах болно. Гэвч “бидний эргэн тойронд дэлхий үймээн самуунд нэрвэгдэж байсан ч бид дотоод амар амгалангийн адислалыг хүлээн авах боломжтой.”<sup>1</sup> Амар амгаланг мэдрэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд таны хийж болох зарим зүйлийг доор өгөв.



## Тогтвортой байдал

Ямар нэгэн эмгэнэлт зүйл тохиолдох үед хүүхдүүдэд өөрсдийнх нь ертөнц тогтворгүй болсон мэт санагдаж болно. Тэдэнд тууштай байдлын үлгэр жишээ бол. Тухайн асуудлын талаар тайван, өөртөө итгэлтэй ярь. Тогтсон дэг жаягаа аль болох хадгалж үлд. Гэр бүлийн үдэш хийх, судраас суралцах, залбирах болон бусад гэр бүлээрээ хийж хэвшсэн зүйлээ үргэлжлүүлэн хийхийн тулд чадах бүхнээ хий. Хүүхдүүдийн ертөнц ганхсан ч гэлээ цаг хугацаа өнгөрөхийн хэрээр сайн мэдээ аливаа зүйлийг өөрөөр харах боломж олгодог бөгөөд амьдрал үргэлжилсээр байх болно гэдгийг тэд сурна.

## Хүндлэх

Хүүхдүүдийн сэтгэлийг хүндэл. Хүүхдүүдийг сонсож, тэдний мэдрэмжийг хүлээн зөвшөөр. Тэдний асуудлыг чухалчлан авч үзэж байгаагаа харуул. Тэдэнд орон зай хэрэгтэй бол гаргаж өгч, ярих хэрэгтэй бол бэлэн гэдгээ хэл. Хүүхдийн насанд тохируулан гарч ирсэн асуултуудад нь үнэн зөв хариул. Айдас болон сэтгэлийг нь зовоож байгаа зүйлийнхээ талаар ямар ч үед ярьж болно гэдгийг хүүхдүүдэд мэдүүл.



## Удирдан залах

Хүүхдүүд тань “Яагаад Бурхан муу зүйлс болохыг зөвшөөрдөг вэ?” гэж асууж магад. Сайн, муу зүйлсийн аль аль нь амьдралын болон Бурханы мөнхийн төлөвлөгөөний нэгэн хэсэг гэдгийг тайлбарла. Тэр хүн нэг бүрд өөрийн гэсэн сонголт хийх боломжийг олгодог ба заримдаа хүмүүс муу сонголт хийснээсээ болж зовдог. Өөр үед эмгэнэлт явдал хэн нэгний буруугаас биш, зүгээр л байгалийн нэгэн хэсэг байдаг. Юу ч болсон бай Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахад үргэлж бэлэн байдаг. Түүний тусламжтайгаар бид хүнд хэцүү туршлагаасаа суралцаж, өсөж хөгжих боломжтой. Бид Түүнд хандан амар амгаланг олж чадна.

### Урам зориг өгөх

Хүүхдүүдэд тусламж өгөх боломж олгох замаар өөрчлөх хүч тэдэнд байгаа гэдгийг харуул. Жишээлбэл, тэд байгалийн гамшгийн хохирогчдод зориулсан хандивыг цуглуулж туслан, өвдсөн эсвэл гэмтэж бэртсэн найзаа эмнэлэгт очиж эргэж, гэр бүлийн гишүүнээ алдсан хүнд урам зориг өгч, зовлон бэрхшээлтэй хүмүүсийн төлөө залбирч болно. Бүгдийг засаж залруулах боломжгүй ч бид асар их сайн үйл хийх чадавхтай ба “хэн нэгний зовлон зүдгүүрийг нимгэлэхээр туслах бүрдээ амар амгаланг авчрахаар ажиллаж байдаг.”<sup>2</sup>



### Тайтгаруулах

Хүүхдүүддээ Бурхан тэднийг хайрладаг, та ч бас тэднийг хайрладгийг сануул. Тэдэнд ямар ч муу зүйл хэзээ ч тохиолдохгүй хэмээн буруу ташаа зүйл бүү амла. Харин одоо айх зүйл байхгүй бөгөөд тэднийг хамгаалахын тулд чадах бүхнээ хийнэ гэдгээ тэдэнд ойлгуул. Тэнгэрлэг Эцэг тэдэнд тохиолдох ямар ч сорилт бэрхшээлийг даван гарахад тусална гэдгийг хэл.

Хэрэв зовлон зүдгүүрээс болж сэтгэлээр унасан бол эцсийн эцэст сайн сайхан зүйлс муу муухайг ялан дийлнэ гэдгийг санаарай. Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) “Бид нүгэлтэй дайтаж байгаа ч, . . . цөхөрч болохгүй. Бид энэ дайнд ялж чадна, ялах ч болно. Ингэж ялахад хэрэгтэй арга замыг Тэнгэр дэх Эцэг маань бидэнд зааж өгсөн юм” гэж хэлсэн. Бурхан залуур дээр байна. Тиймээс бид айж эмээх хэрэггүй.”<sup>3</sup> ■

### ЭШЛЭЛҮҮД

1. “Peace,” Gospel Topics, topics.lds.org.
2. “Peace,” Gospel Topics.
3. Thomas S. Monson, “Looking Back and Moving Forward,” *Liahona*, May 2008, 90.

### ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Энэ сарын *Найз* сэтгүүлд:

- “Би түүнийг дахин харна” (H20-р хуудас)
- “Тайтгарлын карт” (H21-р хуудас)

Бусад эх сурвалжийг [lessonhelps.lds.org](http://lessonhelps.lds.org) руу орж, “Lesson Helps by Topic” дээр дарж харна уу.



### ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Энэ дугаарт:

- “Хүнд хэцүү үед өөртөө болон бусдад амар амгаланг олох нь” (52–53-р хуудас).

Бусад эх сурвалжийг [youth.lds.org](http://youth.lds.org) руу орж харна уу.





## Бурхан намайг удирдан залдаг уу?

**Б**идний амьдрал ямар ажил мэргэжил эрхлэх, хэнтэй гэрлэх, хаашаа сургуульд явах гэх мэт том том асуудлаар дүүрэн байдаг. Мөн амьдрал маань цагаа хэрхэн зөв ашиглах, сургаалыг ойлгох гэж хичээх, зовлон бэрхшээл дунд амар амгаланг олох гэх мэт өдөр тутмын асуудлаар дүүрсэн байдаг. Энэ бүгдэд **бид хувийн илчлэлт авах хэрэгтэй**. Гэхдээ үүнийг заримдаа хэрхэн хүлээн авах, хүлээн авсныхаа дараа хэрхэн ялган танихад хэцүү байж болно. Бид хариултаа авахгүй эсвэл ялган таньж чадахгүй байвал “Энэ нь Сүнс байсан уу эсвэл миний өөрийн бодол байсан уу?”, “Яагаад би үүнийг хий гэсэн сүнсний өдөөлтийг мэдэрсэн ч бүтэлгүйтсэн бэ?”, “Яагаад надад Бурхан миний залбирлыг хариулахгүй байгаа юм шиг санагддаг вэ?” гэх мэт бодол орж ирдэг.

Аз болоход “Шийдвэр гаргах нь: Сонгох эрх ба илчлэлт” (44-р хуудас) гэх нийтлэлд Эрин амьдралыг нь орвонгоор нь өөрчилсөн шийдвэрийг гаргахад хүлээн авсан хувийн илчлэлтийнхээ тухай түүхийг хуваалцсан. **Бурхан биднийг удирдан залахыг хүсдэг** ч бидэнд өөрсдийн сонгох эрх дээр тулгуурлан сайн сонголт хийж сурахад туслахыг мөн адил хүсдэг.

Ариун Сүнс хэрхэн тантай хувь хүний тань хувьд хандаж ярьдаг талаар сурах нь илчлэлт хүлээн авч, ялган таних өөр нэгэн амин чухал хэсэг юм. Энэ нь бидний хүн нэг бүрийн хувьд өөр өөр байж болно. 48-р хуудсан дээр олон **залуучууд хэрхэн илчлэлт хүлээн авдаг талаараа хуваалцсан**.

Зөвхөн дижитал хэлбэрээр гардаг нийтлэлд, хувийн илчлэлт авахын тулд “Сүнслэг булчингаа хөгжүүлэх” шаардлагатай гэдгийг Аспэн тайлбарлажээ.

Ирээдүйн талаар бодох нь хүнд хэцүү, тэр ч бүү хэл аймшигтай санагдаж магадгүй. Ялангуяа залуучуудын хувьд ийм байх нь олонтоо. Гэхдээ өмнө нь хэрхэн **Бурхан миний амьдралыг удирдан залж байсан** гэдгийг санах нь надад урагш явж, үйлдэж мөн уг замаар явж байх явцад **Тэрээр надад хэрэгтэй удирдамжийг үргэлжлүүлэн өгнө** гэдэгт итгэж найдахад урамшуулдаг.

Хүндэтгэсэн,

Кэйти Сью Эмблий

*Kate Sue*



## ХАМГИЙН САЙН ЗӨВЛӨГӨӨ . . .

*Залуучууд хувийн илчлэлт хүлээж авах талаарх хамгийн сайн зөвлөгөөгөө хуваалцав. Тухайлбал:*

“Өсвөр үеийнхний зөвлөх маань нэг удаа надад ‘Сүнсний Эцэгийн тань хувьд Бурхантай харилцаагаа хөгжүүл. Та хоёрын харилцаа хэдий чинээ хүчтэй байна, төдий чинээ сайн ойлгож, удирдагдан хөтлөгдөх болно’ гэж хэлсэн. Энэ нь миний залбиралд ихээхэн өөрчлөлтийг авчирсан юм.”

—**Грант Гүүлси, АНУ, Калифорни**

“Манай гадасны патриарх бүх хүнд ‘илчлэлт хүлээн авахын тулд илчлэлтийг унш’ гэсэн үгийг цээжлүүлсэн. Намайг судраас уншиж байхад энэ нь надад маш их тусалсан.”

—**Шэлби Типпэттс, АНУ, Миссури**

“Тунгаан бодох цаг гарга. Иосеф Смит үйлдэх шийдвэр гаргахынхаа өмнө Иаков 1:5-ын талаар тунгаан бодсон. Заримдаа Тэнгэрлэг Эцэг хариулт өгөхөөсөө өмнө биднээс залбирч, судлахад цаг гаргаасай хэмээн хүсдэг. Бид ихэвчлэн ийм замаар суралцдаг.”

—**Наташа Хөрбст, АНУ, Юта**

“Чихээрээ биш, харин зүрх сэтгэлээрээ сонсоорой.”

—**Сай Туа, Америкийн Самоа**

*Наманчлалын талаар хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөө тань юу байсан бэ? Хариултаа [liahona.lds.org](http://liahona.lds.org) вэбсайтаар 2019 оны 4-р сарын 30-ны дотор бидэнд ирүүлнэ үү.*

## ЗАЛУУ НИЙТЛЭГЧДИЙН ТУХАЙ

**Эрин Райдэр** бол хуульч бөгөөд подкастын хамтран хөтлөгч юм. Тэр анхныхаа хагас марафонд оролцсон. Чөлөөт цагаараа тэр ном унших, уулаар зугаалах, усан дээгүүр цанаар гулгах мөн гэр бүл, найз нөхөдтэйгөө цагийг өнгөрүүлэх дуртай.



**Аспэн Стэндэр** АНУ-ын Ютад амьдардаг зохиолч, редактор юм. Тэр уулаар зугаалах, аялах, унших, төгөлдөр хуур тоглох дуртай.



**Кэйти Сью Эмблий** түүхийг нь хуваалцвал зохих сайхан хүмүүсээр дэлхий дүүрэн гэж боддог. Тэр сэтгүүлчээр болон испани хэлээр сурсан бөгөөд #сайнсайхныг хуваалц гэсэн зорилготой.



## ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

Танд хуваалцах гайхалтай сайхан түүх байна уу? Эсвэл та аль нэгэн сэдвээр бичсэн нийтлэлийг уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таны үгийг сонсохыг хүсэж байна! Та өөрийн нийтлэл болон санал, сэтгэгдлийг [liahona.lds.org](http://liahona.lds.org) руу илгээнэ үү.

## ЭНЭ ХЭСЭГТ

**44** Шийдвэр гаргах нь: Сонгох эрх ба илчлэлт  
Эрин Райдэр

**48** Хувь хүн рүү чиглэсэн хувийн илчлэлт



Эдгээр болон өөр нийтлэлийг доорх эх сурвалжаас олно уу. Тухайлбал:

- [liahona.lds.org](http://liahona.lds.org)
- **YA Weekly** (Gospel Library аппликэйшн дээрх “Young Adults” хэсэг)
- [facebook.com/liahona](https://www.facebook.com/liahona)

## ЗӨВХӨН ДИЖИТАЛ ХЭЛБЭРЭЭР

Сүнслэг булчингаа хөгжүүлэх нь  
Аспэн Стэндэр





Бид том шийдвэр гаргахдаа, бидний юу хийх ёстойг хэлж өгөх эсэхэд Бурханд хэр их найдах хэрэгтэй вэ?

# Шийдвэр гаргах нь: Сонгох эрх ба ИЛЧЛЭЛТ

Эрин Райдэр

**Б**идний хүн нэг бүр өдөр бүр олон шийдвэртэй тулгардаг. Зарим нь “Би юу өмсөх вэ?,” “Өдрийн хоолонд юу идэх вэ?,” “Би шинэ машин худалдаж авах цаг болсон уу эсвэл хуучныгаа дахиад жоохон унасан нь дээр үү?” гэсэн ердийн шийдвэрүүд байдаг. Гэхдээ заримдаа “Би сургуульдаа эргэж орох уу?,” “Би энэ ажилд орох нь зөв үү?,” “Би өөр хот руу нүүсэн нь дээр үү?,” “Байшин худалдаж авах уу?,” “Би энэ хүнтэй болзох нь зөв үү?,” “Би энэ хүнтэй гэрлэх нь зөв үү?” гэх мэт том шийдвэр гаргах хэрэгтэй болдог.

Том шийдвэр гаргах шаардлагатай бол бид сонголт хийхдээ зохих ёсоор арай илүү цаг зарцуулдаг. Бид Сургаал ба Гэрээ 9:8–9 дэх Оливер Каудерид өгсөн зөвлөгөөг дагадаг. Их Эзэн:

“Гэвч, болгоогтун, би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно.

Гэвч энэ нь зөв биш аваас чамд ийм мэдрэмж байхгүй байх болно, харин буруу зүйлийг мартахад чамайг хүргэх дүйнгэ бодол санаа чамд байх болно” хэмээн хэлсэн.

Хэдийгээр энэ нь сайн зөвлөгөө ч гэлээ, заримдаа бид том шийдвэр гаргахдаа Бурхан бидэнд юу зөв гэдгийг хэлж өгнө гэдэгт хэт анхаарлаа хандуулж, харин оюундаа тунгаан бодох тухайд анхаарлаа хангалттай сайн хандуулдаггүй юм шиг надад санагддаг. Бурхан бидний шийдвэрийг зөв гэж батлахыг нь хүлээж цагаа барснаар бид гайхамшигтай боломжуудыг хажуугаараа өнгөрүүлдэг. Бид сонгох эрхийн гүйцэтгэдэг үүргийг хүлээн зөвшөөрч болох хэдий ч урьдчилан тодорхойлсон “төлөвлөгөөний” замаас биднийг гаргах шийдвэрийг гаргахаас айж, цээжин бие дотор шатаж, тэнгэрээс дуу сонсох хүртэл өөрсдийн шийдвэрийг буруу хэмээн бодож эхэлдэг. Бидний олонхын хувьд сонгох эрх, хувийн илчлэлт хоёрын хоорондох үгээр илэрхийлэмгүй энэ сөргөлдөөн дундаас “Биднийг шийдвэр гаргахад Бурхан ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?” гэсэн нэгэн чухал асуулт гарч ирдаг.

## Биднийг шийдвэр гаргахад гүйцэтгэдэг Бурханы үүрэг

Магадгүй энэ асуултад Жаредын ахын түүхээр дамжуулан хариулах нь дээр байх. Энэ түүхэнд Бурхан биднээс шийдвэрээ хэрхэн гаргахыг хүсдэг арга



замын талаар бидэнд заадаг өсөлт хөгжлийн сонирхолтой загвар өгөгдсөн байдаг. Бабелын цамхагт хүмүүсийн хэл бусниулагдсаны дараа Жаред ахаасаа тухайн нутгийг орхин явах хэрэгтэй эсэх, хэрэв тийм бол хаашаа явах талаар Их Эзэнээс лавлан асуухыг хүссэн (Ифер 1:36-43-ыг үзнэ үү). Жаредын ах асууж лавласнаар, Их Эзэн тэднийг далайн эрэгт хөтлөн авчирдаг. Аялж байх замд нь Их Эзэн тэдэнд хандан үүлэн дундаас ярьсан ба алхам бүрийг нь зааж өгчээ. Эцэст нь тэд далайн эрэгт хүрч очсон бөгөөд тэндээ дөрвөн жил амьдарсан байна.

Дөрвөн жилийн дараа Бурхан Жаредын ахад далайг туулахад бэлдэж, том завь барь хэмээн хэлэв. Жаредын ах завинд агаар байхгүй гэдгийг олж мэдээд мөн л загварыг дагаж, юу хийхээ Бурханд хандаж асуужээ. Хүлээж байсанчлан, Их Эзэн түүнд завины орой болон ёроолыг нүхэл хэмээн нарийн заавар өгсөн байна. Илчлэлтийн дараах загварыг олж харна уу. Бурхан тэдэнд төлөвлөгөө өгч, тэд уг төлөвлөгөөг хэрхэн гүйцэлдүүлэх талаар асуулт тавьж мөн хариуд нь Бурхан дэлгэрэнгүй, тодорхой хариулт өгдөг.

Гэвч завийг нүхэлсний дараа Жаредын ах завинд ямар ч гэрэл байхгүй болохыг ойлгосон. Тэр дахин юу хийх ёстойгоо Бурханаас лавлаж асуудаг. Харин хариулахын оронд Бурхан түүнээс “Та нар хөлгүүд дотроо гэрэлтэй байхын тулд намайг хэрхэхийг та нар хүснэ вэ?” (Ифер 2:23) хэмээн асуудаг. Өмнө нь өгсөн дэлгэрэнгүй зааврынхаа оронд энэ удаа Их Эзэн Жаредын ахын юу хийхээ шийдэхийг нь хүлээдэг.

Их Эзэнээс ирдэг ийм маягийн хариултыг шийдвэр гаргахдаа ойлгох хамгийн хэцүү. Бидэнд залбирч,



хариултаа хүлээхийг заадаг тул ямар ч хариулт ирэхгүй бол аяндаа санаа зовж эхэлдэг. Тодорхой хариулт ирэхгүй бол энэ нь уг сонголт буруу гэдгийг тодорхойлдог “дүйнгэ бодол санаа” мөн эсэх талаар ч бодож эхэлдэг. Харин заримдаа энэ нь биднийг хариултаа сонсохуйц зохисгүй юм болов уу эсвэл бид “үнэн хүсэлтэйгээр” залбираагүй юм болов уу гэж бодоход хүргэдэг (Моронай 10:4-ийг үзнэ үү). Гэхдээ заримдаа бид гурав дахь сонголт байдаг гэдгийг авч үздэггүй. Бурхан Жаредын ахтай адил *биднээс өөрсдийн* шийдвэрийг өөрсдөө гаргахыг хүсэн хүлээж байж ч магадгүй.

### Шийдвэр гаргах нь

Саяхан надад сонгох эрх болон хувийн илчлэлтийн талаар өөрийн бодолд эргэлзэхэд хүргэсэн нэгэн үйл явдал болсон юм. Магистрын зэрэг авахаар төгсөх жилдээ сурч байхад надад өөр өөр хотод ажиллах ажлын хэд хэдэн санал ирсэн бөгөөд би

алиныг нь сонгохоо шийдэж чадахгүй байлаа. Жаредын ахын адил би чухал шийдвэр гаргахдаа залбирч байсан ба Бурхан надад хангалттай тодорхой хариулт өгдөг байв. Тэрхүү өмнөх туршлагууд дээрээ үндэслэн би аль ажлыг авбал зүйтэй вэ хэмээн Бурханд хандан залбирсан юм. Би бас өөрийн зүгээс шаардагдах зүйлээ хийж, ажил болгоны талаар судалж, олон хүнээс зөвлөгөө авч билээ. Гэвч хэчнээн их залбирч, мацаг барьсан ч гэлээ тэнгэр нам гүм байсаар, би ямар ч хариулт хүлээн авсангүй.

Шийдвэр гаргах цаг ч ойртож, би сандарч эхлэв. Энэ шийдвэрийг гаргахад Их Эзэний тусламж хэрэгтэй гэдэг нь тодорхой байсан ч яагаад Тэр хариулахгүй байгаа юм бол? Миний ямар ажил сонгох нь Түүнд хамаагүй байж болох ч, аль хот руу нүүх нь миний амьдралд гарцаагүй нөлөөлөх учраас Тэр үүнд санаа тавих нь дамжиггүй. Өмнө нь шийдвэр гаргахад Их Эзэн үргэлж санаа тавьдаг байсан

мөртлөө яагаад үүнд санаа тавихгүй байгаа юм бол?

Гэхдээ би хэчнээн их хичээсэн ч ямар ч хариулт аваагүй. Би Бурханаас холдсон тул Түүний хариултыг сонсохгүй байгаа юм болов уу гэж хүртэл бодох болов. Эсвэл сэтгэлийнхээ угт түүний хариултыг сонсохыг хүсэхгүй байгаа болохоор сонсохгүй байгаа юм болов уу ч гэж бодогдож билээ. Эцэст нь шийдвэр гаргах өдрийн урд өдөр сонголт хийх хэрэгтэй гэдгээ би мэдэж байсан тул өөрийнхөө бодолд тулгуурлан шийдвэр гаргав. Тэр орой нь би хариулт маань зөв буруу эсэхийг хэлж өгөхийг хүсэж Түүнд хандан залбирсан юм. Ямар ч хариулт ирээгүй тул би сэтгэл шулуудан, ажил хүлээн авав.

Хэдэн сар өнгөрсөн ч гэсэн би шийдвэртээ эргэлзсэн хэвээр байсан тул бататгахын тулд санваарын адислал авахыг хүссэн юм. Адислалаар Их Эзэн миний гаргасан шийдвэрт сэтгэл хангалуун байсан тул залбиралд маань хариулаагүй хэмээн хэлсэн



билээ. Бидний ямар шийдвэр гаргах нь ихэнхдээ тийм ч чухал биш хэмээн хэлсэн номлолын ерөнхийлөгчийн маань урьд өмнө өгч байсан зөвлөгөөг энэхүү адислал бататгасан юм. Бурхан биднээс бие дааж, өөрсдийн амьдралыг хэрхэн шийдэх талаар суралцаасай гэж хүсдэг. Бурхан бидний Тэнгэрлэг Эцэгийн хувьд, хэрэв бид чин сэтгэлээсээ юу хийхээ мэдэхээр хичээх юм бол биднийг шийтгэхгүй төдийгүй амласан боломжуудаа ч эргүүлэн авахгүй гэдгийг надад номлолын ерөнхийлөгч маань сануулсан билээ.

Жаредын ах завийг гэрэлтүүлэхээр юуг ч санал болгож болох байсан ба Их Эзэн аль ч саналыг нь зөвшөөрөх байсан болов уу. Энэ туршлагын хувьд асуудал нь Жаредын ах итгэлээ хөгжүүлэхийн зэрэгцээ хэрхэн шийдвэр гаргаж сурсанд оршиж байгаа юм.

### **Сонгох эрхээ ашиглах нь**

Мөнхийн талаас нь харах юм бол, сонгох эрхээ ашиглах нь хувийн өсөлт

хөгжлийн салшгүй нэгэн хэсэг юм. Үүнгүйгээр бид бүрэн чадавхдаа хүрэхэд туслах шийдвэрүүдийг гаргаж чадахгүй. Өсөлт хөгжил нь сайн мэдээний бусад зүйлийн адил “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгддөг. Бурхан биднийг хөдөлгөөнгүй биш, харин бэлэн хүмүүс байгаасай мөн сонгох эрхээ өөрсдийн амьдралд хамгийн сайнаараа ашиглаасай хэмээн хүсдэг.

Бид сонгох эрх, илчлэлт хоёрын хоорондын тэнцвэрийг олж сурах юм бол жинхэнэ сүнслэг өсөлт хөгжлийг мэдрэх болно. Энэ л Жаредын ахад тохиолдсон зүйл юм. Тунгаан бодсоныхоо дараа тэрээр чулууг хайлуулан гаргаж аваад, Бурханаас чулуунд гараараа хүрч гэрэлтүүлдэг болгохыг хүссэн (Ифер 3:1–5-ыг үзнэ үү). Харин энэ удаа Бурханыг хариулахад бүх зүйл өөрчлөгдсөн юм. Бурханы дуу хоолойг үүлэн дундаас сонсохын оронд Жаредын ах Их Эзэнийг бодитоор харсан ба Их Эзэн Өөрийн биеэр ирэхийн зэрэгцээ Жаредын ахад дэлхий дээр болон

ирээдүйд болох бүхний талаар гайхамшигт үнэнийг үзүүлсэн (Ифер 3:6–26-г үзнэ үү). Жаредын ах эхлээд бие дааж шийдвэр гаргаснаар хувь хүнийхээ хувьд өсөж хөгжин, өөрийгөө бэлдээгүй байсан бол үзэгдлийг хүлээн авахад сүнслэг байдлын хувьд бэлтгэгдээгүй байж байсан.

Бид шийдвэр гаргахдаа “Бүх үйлүүдээ Их Эзэнтэй зөвлө” (Алма 37:37) хэмээх Алмагийн зөвлөгөөг яг таг дагах ёстой. Их Эзэн биднээс тодорхой шийдвэр гаргахыг хүсвэл үүнийгээ бидэнд мэдэгдэж, замаасаа гарахаас сэргийлэх болно. Бид мөн хариулт ирэх эсэхээс үл хамааран босож зогсон, итгэлээрээ урагш тэмүүлэх ёстой. Бид гэрээгээ сахиж, Есүс Христийн сайн мэдээнд үнэнч хэвээр үлдэж чадах л юм бол гаргасан зөв шударга шийдвэртээ итгэлтэй байж, Их Эзэн бидний гаргасан хүчин чармайлтад сэтгэл хангалуун байгаа гэдэгт сэтгэл амар байж болно. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*





Та илчлэлт,  
өөрийн бодол  
хоёрыг хэрхэн  
ялгаж чаддаг вэ?

# ХУВЬ ХҮН РҮҮ ЧИГЛЭСЭН ХУВИЙН ИЛЧЛЭЛТ

**Б**ид олон боломж бололцоо бүхий дэлхий ертөнцөд амьдарч байна. Бид өөрсдийн ажил мэргэжил, сургууль, эхнэр нөхөр, амьдрах газар гэх мэт олон зүйлийг сонгох эрхтэй. Энэ бол үнэхээр бидний энэ цаг үеийн адислал юм. Нөгөөтээгүүр, сайн зүйл рүү хөтлөх ийм олон зам, боломж бололцоо байхад шийдвэр гаргах нь хэцүү байдаг тул энэ нь эдгээр сонголтыг улам бүр хүнд болгож байгаа билээ. Ийм олон сайн боломж байхад бид зөвийг нь хэрхэн сонгож болох вэ? Та элсэн ширхэг мэт тоймгүй олон сонголтын дунд төөрч, эргэлзэх үедээ Тэнгэрлэг Эцэг таныг удирдан чиглүүлэхийг хүсдэг болохыг мэдээрэй. Хэрэв та Түүний дуу хоолойг дагах юм бол зөв замыг сонгож, эрэлхийлж буй хариултаа авах боломжтой. Тэрээр тантай хэрхэн ярьдгийг таньж мэдэн, Түүнд итгэн найдаж, бошиглогчийг дуулгавартай дагаж, тэвчээр хатуужилтай байж, илүү өөдрөг, итгэлтэй байвал энэ бүхэн эцэст нь таныг зөв зүгт хөтлөх болно.

—*Вира Ващенко, Украин, Киев*

**А**мьдралын минь туршид Их Эзэн хэрхэн намайг хөтлөхийг би харж, байгаа бүхэндээ Түүний болон Түүний удирдамжийн ачаар хүрсэн гэдгээ ухааран ойлгодог. Тэр ч бүү хэл ганцаархнаа алхаж байна даа гэж бодогдох үед хүртэл Тэрээр үргэлж миний төлөө байдгаа надад мэдэгдэж, мэдрүүлдэг. Тиймээс би ганцаар гэж бодох үедээ ч гэсэн үргэлж итгэлээр урагшилж байхаар шийдсэн юм. Миний хувьд заримдаа зам маань тодорхой бус, ирээдүйд юу намайг хүлээж байгааг би тэр болгон харж чаддаггүй ч үргэлж итгэлээр алхалж, тэгснээрээ гэрлийг харж, Бурханы мутар миний амьдралд оролцож байгааг ухаардаг. Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христ бидэнд хайртай бөгөөд биднийг удирдан залахыг хүсдэг ч гэсэн биднээс Өөрсдөд нь итгэж, Сүнсний удирдамжийг хүлээн авахдаа үүнийг дагуу үйлдэхийг хүсэн хүлээдэг.

—*Индира Мэхиа, Доминиканы Бүгд Найрамдах Улс*





**Б**идний төгс эзэмшвэл зохих хамгийн гайхалтай арга барил бол Ариун Сүнсний намуухан шивнээг таньж сурах чадвар юм. Судраас хичээнгүйлэн суралцсан маань намайг энэ аргыг цааш нь төгс эзэмшихэд хүргэсэн билээ. Хичээнгүйлэн хайгч тэр олох болно; мөн Бурханы нууцууд тэдэнд Ариун Сүнсний хүчээр задлагдах ажгуу гэдэгт би үргэлж итгэдэг байсан (1 Нифай 10:19-ийг үзнэ үү). Өөрөөр хэлбэл, хэрэв бид Сүнснийг ялган таньж чадахыг хүсэж байвал хэрэгтэй хэрэггүй зүйлс буюу өдөр тутмын амьдралын асуудлын талаар бодолгүй, ажилдаа ханцуй шамлан орж, өөрийгөө мартаж хэрэгтэй. Энэ үед л би бэлэн болсон байх тул Сүнснийг илүү сайн ялган таних болно. Шуургаанаар усан онгоц хурдан явж чаддаггүйн адил, хэрэв бид өөрсдийн чадлаас хальсан амьдралын аар саар зүйлд автах юм бол Сүнснийг сонсож чадахгүй.


—*Эммануэл Борнгрэйт Догбий, Гана, Аккра*

**Н**ас биед хүрснээр би Сүнсний хэлийг сурах хэрэгтэй болсон. Сүнс надтай энгийн бодлоор дамжуулан ярьдаг. Үүнд дасахад хугацаа шаардагдсан ч ихэвчлэн ажил руугаа машинаар явж байх замд гэх мэт чимээгүй орчинд Сүнс над дээр ирдэг. Ихэвчлэн аливаа сэдвийн талаар бодоо ч үгүй байхад Сүнс гэнэт орж ирдэг тул энэ нь миний бодол биш гэдгийг би мэднэ.

—*Кларисса Мэй Тэйлор, АНУ, Юта*

**М**анай жижиг гэр бүлийн хувьд, бид амар амгалан мэдэрдэг тул, ялангуяа нөхөр бид хоёр хамт байхдаа Сүнснийг ялган таньж чаддаг. Хэрэв энэ нь бидний өөрсдийн бодол бол, бид яг зөв гэсэн мэдрэмжийг хүлээн авдаггүй бөгөөд цаанаа л эргэлзээ, айдас мэдрэгддэг. Харин энэ нь илчлэлт бол, бид учир шалтгааныг нь ойлгохыг хичээн, эхэндээ ямар ч утгагүй мэт санагдсан ч дандаа амар амгаланг мэдэрдэг. Бид үүнийгээ дагаж, хийж дууссаныхаа дараа бүх зүйл байр байрандаа орж, шийдэгдсэн байгааг үргэлж олж хардаг. Яг тэр үед бид хоёр бие бие рүүгээ хараад “Өө, одоо л ойлголоо” гэж хэлдэг.

—*Мариаана Врайт, АНУ, Юта*



Хэдийгээр бид бүгдээрээ хувийн илчлэлтийг өөр өөр арга замаар авч болох ч Бурхан бидэнд хандан ярьдаг гэдэг нь гарцаагүй үнэн юм. Бид зүгээр л Түүний дуу хоолойг ялган таних чадвараа хөгжүүлэхээр хичээл зүтгэл гаргах хэрэгтэй. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны зөвлөснөөр “Өөрийн асуудал, айдас, сул талуудын талаар, тийм ээ, бүр зүрхний хүсэл эрмэлзлийнхээ талаар Есүс Христийн нэрээр залбир. Тэгээд сон! Оюундаа ирэх бодол санааг бичиж ав. Төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглээд, хийхээр өдөөгдсөн үйл хэргүүдээ хийж дуусга. Та энэ үйл явцыг өдөр тутам, сар бүр, жил болгон давтан хийснээр ‘илчлэлтийн зарчимд өсөн [хөгжих]’ болно” (“Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 118). ■







## ЭНЭ ХЭСЭГТ



**52** Хүнд хэцүү үед өөрийгөө болон бусдыг амар амгалан болгох нь

Алэкс Хюгье ба Аспэн  
Стандэр

**54** Амьдрал бол марафон  
Салли Жонсон Одэкөрк

**60** Асуулт, хариулт:  
Патриархын адислал  
маань шийдвэр гаргахад  
хэрхэн тусалж болох вэ?

**62** Христийн амилсны баяраар шинэ уламжлалыг дагаж үзнэ үү  
Дэвид Диксон

**64** Сүүлчийн үг: Бурханы хайрын хамгийн агуу илрэл

Ерөнхийлөгч  
М.Рассэлл Баллард



## Анх ахлах

сургуульд ороход надад нэг асуудал тулгардаг байв. Тэр юу гэвэл, шинэ сэдэв үзэж эхлэхэд би сайн ойлгодоггүй байсан юм. Нэг орой би Тэнгэрлэг Эцэгт хандан, ойлгодог болж энэ асуудлыг шийдвэрлэхэд надад туслахыг гуйн залбирлаа. Би итгэлтэй байсан ба илүү сайн ойлгодог болж чадсан юм. Тэр үеэс хойш залбирал, итгэл хоёр сургууль дээр болон хаана ч явсан миний хийх ёстой зүйлсийн жагсаалтад орох болсон.

Хөвгүүдийн сургуулийн сурагчид зарим зохисгүй зүйлийг хийдэг тул надад хэцүү байдаг. Ийм тохиолдолд аав, ээжийн маань “Ариун Сүнснийг үргээх зүйл битгий хийгээрэй” гэсэн үгс санаанд орж ирдэг. Надад Ариун Сүнснийг сонсдог байхыг үргэлж сануулдаг ээждээ би талархдаг. Зөв зүйлийг хийхэд Бурхан биднийг адисалдаг.

**Ниамэ С.,** 16 настай, Гана



**З**аримдаа амьдрал биднийг орвонгоор маань эргүүлдэг. Та гэр бүлийн болон эрүүл мэндийн мөн сургууль дээрх аливаа асуудлуудад, түүнчлэн дэлхий дахинд болж буй ярвигтай асуудлуудад санаа зовж байж магадгүй. Ийм түгшүүртэй дэлхийд бид хэрхэн амар амгаланг олж болох вэ? Таны амар тайван байдал нөлөөллийн тань хүрээнээс хэтэрсэн үйл явдлаас болж эсвэл нөлөөлж, өөрчилж чадах зүйлээс тань болж байгаа эсэхээс үл хамааран Есүс Христээр дамжуулан сэтгэлээ амар амгалан болгох хэдэн санааг өгье.

## ӨӨРИЙГӨӨ АМАР АМГАЛАН БОЛГОХ 4 АРГА ЗАМ

### 1. Мөнхийн зүйлсэд анхаарлаа төвлөрүүлэх

Зөвхөн түр зуурын асуудалд анхаарлаа төвлөрүүлэх юм бол амар амгаланг мэдрэх хэцүү. Гэхдээ та илүү өргөн цар хүрээтэй зүйлд буюу Бурханы аз жаргалын төлөвлөгөөнд анхаарлаа төвлөрүүлэх юм бол сэтгэлийг тань зовоож байгаа зүйл мөнхөд үргэлжлэхгүй гэдгийг мэдсэнээр амар амгалан болох боломжтой. Жишээлбэл, ариун сүм бидэнд мөнхийн зүйлсэд анхаарлаа төвлөрүүлэхэд тусалдаг. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) ариун сүмд “та өөр хаана ч мэдэрч чадахгүй амар амгаланг мэдэж авах болно”<sup>1</sup> гэж хэлсэн.

### 2. Та хянаж чадахгүй зүйлээ зүгээр л орхих

Таны нөлөөлж чадахгааргүй ямар нэгэн зүйл амар амгаланг тань булаан авах үед найдвараа алдах эсвэл уурлах хүсэл төрдөг. Гэвч өөрчилж чадахгүй зүйлдээ төвлөрсөөр байх нь тус болохгүй. Үүний оронд амьдралд азгүй зүйл тохиолдвол сэтгэлдээ амар амгаланг олохын тулд Аврагчид илүү ойртох хэрэгтэй. Тэрээр танд Тайтгаруулагч буюу Ариун Сүнсийг илгээхээ амласан (Иохан 14:26–27-г үзнэ үү).

### 3. Бусдыг уучлах

Ихэвчлэн хэн нэгний танд таагүй хандсанаас болж төрсөн сөрөг мэдрэмжийг мартаж хамгийн хэцүү байдаг. Гэхдээ Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф “Бид бусдад энэхүү баяр баясгаланг өгөөмрөөр өгөх хүсэлтэй байснаар өөрсдийн амьдралд өршөөлийн баяр баясгаланг хүлээн авах болно. . . . Үр дүнд нь Их Эзэний Сүнс бидний бодгалийг ухамсрын бурханлаг амар амгаланг авчирдаг тэрхүү баяр баясгалангаар дүүргэнэ (Мозая 4:2–3-ыг үзнэ үү)” гэж заасан.<sup>2</sup> Аврагчид хандах нь танд сэтгэлийн дарамтаасаа салж, амар амгалангаар дүүрэхэд тусална.

### 4. Наманчилж, Христэд итгэж найдах

Таны амьдралд сайн сайхан юу ч болж бай, нүглийнхээ ачааг үүрэх нь таны амар амгалангаас үргэлж хумслах болно. Заримдаа бидэнд нүглээ бүрэн наманчлахад бишопын тусламж хэрэгтэй болдог. Гэвч бид тогтмол наманчилж, Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Түүнтэй адилхан болоход саад болох бүхий л зүйлээс өөрсдийгөө цэвэршүүлсэн байх ёстой.

Хүнд хэцүү үед  
өөрийгөө болон бусдыг.

# АМАР АМГАЛАН








# БОЛГОХ НЬ

Алэкс Хюгье ба Аспэн Стандэр  
Сүмийн сэтгүүлүүд

*Өөртөө болон бусдад  
амар амгаланг мэдрэхэд  
туслах найман арга  
замыг доор дурдав.*



## БУСДАД АМАР АМГАЛАН БОЛОХОД ТУСЛАХ 4 АРГА ЗАМ

### 1. Есүс Христийн сайн мэдээг хуваалцах

Аврагчид анхаарлаа төвлөрүүлснээр өөрийн амар амгаланг олж болохтой адил бид Тэрээр “амар амгаланг үндэслэгч” (Мозая 15:18) болохыг бусдад зааж өгч болно. Жишээлбэл, Есүс Христийн талаар илүү ихийг олж мэдэхэд тань тусалсан судрын буюу Ерөнхий чуулганы эшлэлийг та хуваалцаж болно.

### 2. Амар тайванг тогтоогч байх

Найз нөхөд, ах эгч дүү нарынхаа хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд тусал. Алма номонд гардаг Антай-Нифай-Лихайн хүмүүсийн адил бид хов жив хөөцөлдөх, өшөө авахыг эрэлхийлэх, амин хувиа хичээх гэх мэт дайн тулааныхаа зэвсгийг булж, тэдгээрийг эелдгээр ярих, Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах, бусдыг уучлах зэрэг энх амгалангийн зэмсгүүдээр сольж чадна (Алма 24:19-ийг үзнэ үү).

### 3. Сайн сонсогч байх

Зовж зүдэрч байгаа хүмүүс бодол санаа, мэдрэмжээ дотроо хадгалахынхаа оронд заримдаа нээлттэй ярих хэрэгтэй. Бид тэдний асуудлыг өмнөөс нь шийдэх хэрэггүй ч асуудлыг нь сонсож, тусламж дэмжлэг үзүүлэн, Христтэй адил хайрлаж, ойлгож чадна.

### 4. Тойргийнхоо болон орон нутгийнхаа хүмүүст тохинуулах

Та орон гэргүй хүмүүсийн толгой хоргодох газарт сайн дураараа ажиллаж, гэрийн багшаар үйлчилж, хөрш болсон шинэ гэр бүлийг амттанаар дайлж болно. Хүмүүст жижигхэн зүйлээс амар амгаланг олоход туслаарай. Идэж уух, унтах газартай, найдвартай сайн гэрийн багштай байх, хэн нэг нь бага ч атугай санаа тавьдаг болохыг мэдрэх нь гайхамшгийг бүтээнэ.

Есүс амар амгаланг олж чадахгүй байгаа бүх хүнийг “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай” (Иохан 14:27) хэмээн тайвшруулсан. Хэрэв бид өөрсдийгөө болон бусдыг Есүс Христэд илүү ойртуулах юм бол амьдрал хэцүүдэхэд ч гэсэн амар амгалан байж чадна. ■

#### ЭШЛЭЛҮҮД

1. Gordon B. Hinckley, in “Rejoice in the Blessings of the Temple,” *Liahona*, Dec. 2002, 33.
2. Dieter F. Uchtdorf, “Point of Safe Return,” *Liahona*, May 2007, 101.





# АМЬДРАЛ БОЛ М





# АРАФОН

*Энэхүү хожмын үеийн залуу гэгээнтнүүд өнөөдөр Шинэ Гэрээний үед төлөөлөгч Паулын амьдарч байсан газарт амьдардаг. Мөн тэд түүний үгсийн дагуу амьдардаг.*

## **Салли Жонсон Одэкөрк**

Сүмийн сэтгүүлүүд

**Х**эдэн сарын өмнө семинарын ангийнхан төлөөлөгч Паулын хүчирхгээр номлож байсан Грекийн Афин хотын ойролцоох Арейпад цугларсан байна (Үйлс 17:22–34-ийг үзнэ үү). Суралцагчид семинар болон Паулын сургаал амьдралд нь хэрхэн нөлөөлсөн талаар ярилцав.

18 настай Алексис Х. “Грект амьдрах нь Шинэ Гэрээг амилуулдаг. Аав маань Паулын зааж байсан янз бүрийн газруудын нурангаар явах дуртай бөгөөд үйл явдал хаана болсон талаар судраас хуваалцах юм уу түүхийг нь бидэнд ярьж өгдөг” хэмээв.


Паул амьд байхдаа саад бэрхшээлтэй тулгарч байсантай адил Грекийн өсвөр үеийнхэн мөн адил нийгэм, улс төр, эдийн засгийн асуудалтай тулгардаг. Өсвөр үеийнхний чуулган болон Залуу эмэгтэйчүүдийн аялал Грект ховор хийгддэг бөгөөд семинарт явахад хүртэл хэцүү байх үе бий. Эдгээр болон бусад олон саад бэрхшээлийг үл харгалзан, Грекийн өсвөр үеийнхэн Паулын өгсөн “сайн мэдээний итгэлийн төлөө нэг сэтгэлээр хамтдаа зүтгэж, нэг сүнс дотор бат зогсоцгоо” (Филиппой 1:27) хэмээх урилгыг дагадаг.

Грект амьдарна гэдэг нь Сүмийн залуу гишүүд халуун дулаан уур амьсгалд амьдарч, далайн эргээр явж, дуулж бүжиглэн, цагийг сайхан өнгөрүүлэх боломжтой гэсэн үг. Тэд бас бие биетэйгээ уулзах тун дуртай. Семинарт болон салбарын үйл ажиллагаанд оролцооноор тэдний итгэл, нөхөрлөл улам хүчирхэгжсэн.





Сайн мэдээ хаана ч адилхан юм байна гэдгийг би мэдэж авсан. Би гадаадад амьдарч байхдаа анхаарлаа өөр соёлд төвлөрүүлэхийн оронд сайн мэдээний үнэнүүдэд болон Сүнсийг мэдэрхэд төвлөрүүлж сурсан.” —**Бриана В., 15 настай**



“Би энэ жил болж өнгөрсөн бүх зүйлээ мартаггүйн тулд толин дээрээ “ЗБББТ чуулган, Залуу эмэгтэйчүүдийн аялал, семинар” гэсэн хэдэн үгийг бичсэн. Энэ нь надад хаанаас ирсэн бэ гэдгээ санахад тусалдаг.” —**Мари Х., 17 настай**



“Би семинарт очихдоо хийх ёстой зүйлээ хийж байгааддаа сэтгэл хангалуун байж, бүх зүйл сайхан болно гэдгийг мэддэг.” —**Лиззи Т., 17 настай**



15 настай Лоукиа К. залуу эмэгтэйчүүдийн аялаар яеж байхдаа анх гэрчлэлээ хуваалцсан бөгөөд дараа нь баптисм хүртсэн юм.



Семинарын бүлгийнхэн Афины цуглааны байрны өмнө

## Арейпа дахь семинар

Хэдэн жилийн өмнө Грект семинар эхлэхэд дөнгөж таван суралцагчтай байв. Тэд долоо хоногт гурван удаа өглөө цуглардаг ба зарим нь онлайнгаар оролцдог. Тэд мөн лхагва гаргийн үдээс хойш семинарт цугларч, дараа нь үйл ажиллагаа хийдэг байна. Тэд нэг нэгэндээ ойртон дотносож, үлгэр жишээг нь хардаг найз нөхдийнхөө хувьд гэрэл нь болсон юм. Найзууд нь асуулт тавихад өсвөр үеийнхэн уг асуултыг семинар болон мючелийн үйл ажиллагаан дээр авчирч тавьдаг.

15 настай Павлос К. “Семинарт явах нь өдрийг сайхан эхлүүлэх нэг арга зам бөгөөд надад гуйвшгүй хэвээр байхад тусалдаг. Энэ нь бусдад үлгэр жишээ байх хэрэгтэй гэсэн бодлыг надад төрүүлдэг. Мөн надад өдрийг Есүс Христийн талаар бодож эхлүүлэхэд тусалдаг” гэв.

Өсвөр үеийнхний хүч чадал, нэгдмэл байдал өсөн нэмэгдэх үед адислал, боломжууд тэдэнд ирдэг. Жишээлбэл, 2017 онд тэд Залуучуудын бат бөх байдлын төлөө (ЗБББТ) чуулганд буюу өсвөр үеийнхэнд зориулсан бүсийн томоохон чуулганд оролцох боломжоор адислагдсан юм. Залуу эмэгтэйчүүд мөн Грект болсон анхны Залуу эмэгтэйчүүдийн аялалд оролцсон. Үүний үр дүнд тэд бүлгээрээ бүр

илүү ойртон дотносож, хоёр ч залуу эмэгтэй Сүмд нэгдсэн байна.

## Олон улсын ЗБББТ чуулган

Германд болсон чуулганд Европын өнцөг булан бүрээс хожмын үеийн гэгээнтэн залуус цугларсан юм. Грек, Киприйн өсвөр үеийнхэн хэдэн зуун милийн цаанаас ирж оролцсон ба чуулган тэдэнд маш хүчтэй нөлөөлсөн. 14 настай Максимос А-гийн хувьд “ЗБББТ чуулганаас үлдсэн хамгийн тод дурсамж бол гэрчлэлээ хуваалцсан явдал байсан. Бүгд Сүнсийг мэдэрсэн бөгөөд энэ нь өөрийн гэрчлэлийг хөгжүүлэхэд надад сүнсээр өдөөсөн” гэж яриу.

14 настай Лоукиа К. “Эхлээд өсвөр үеийнхнээс дөнгөж дөрвөн хүүхэд явахаар төлөвлөж байсан ч эцэст нь 15 хүүхэд, үүний дотор 3 гишүүн бус найз маань нэгдсэн. Энэ нь Грекийн хувьд рекорд тоо юм.

Нэгэн ижил сайн мэдээг хуваалцаж, бусдаас ялгарахгүй байж болох газар хамтдаа байх маш сайхан байсан. Бид бүгд хамтдаа, нэг Сүнсийг мэдэрч байв. Эдгээр нь надад тусалдаг” гэв.

16 настай Жэсиана “Аав минь Сүмийн гишүүн биш бөгөөд намайг ЗБББТ чуулганд явуулахыг мөн баптисм хүртэхийг зөвшөөрдөггүй байв. Харин салбарын гишүүд миний

төлөө залбирч, эмээ минь аавтай ярьсан. Үүний дараа тэр надад явж болно гэж хэлсэн” гэлээ.

ЗБББТ чуулганд тэр олон зүйлийг анх удаа мэдэрсэн байна. Тэр “Хичээл, үйл ажиллагаануудад оролцож, гэрчлэлээ хуваалцах нь надад Ариун Сүнснийг үнэхээрийн мэдрэх нь ямар байдгийг ойлгоход тусалсан юм. Би өмнө нь Сүнснийг хэзээ ч ингэж мэдэрч байгаагүй бөгөөд маш их аз жаргалтай, сэтгэл хангалуун байсан. Би анх удаа гэрчлэлээ хуваалцсан гээч” гэв.

Өсвөр үеийнхэн сүнслэг байдлын хувьд тэжээгдэхийн зэрэгцээ, чуулганы үеэр амарч, цагийг зугаатай сайхан өнгөрүүлж чадсан. 14 настай Хайг Т. Кипрээс ирж, чуулганд оролцсон юм. “Би илүү нөхөрсөг байж, найз нөхөдтэй болсон ба хүнд хэцүү байсан ч цагийг хөгжилтэй сайхан өнгөрүүлж болдгийг сурсан” гэв.

### Залуу эмэгтэйчүүдийн аялал

Залуу эмэгтэйчүүдийн аялал ч мөн адил нөлөөлсөн. Удирдагчдынхаа хамт 12 залуу эмэгтэй Марафон хотын эрт дээр үед дайн тулаан болсон газрын дэргэд уулзсан юм. Тэд гурван өдрийг хамтдаа өнгөрүүлж, хүчирхэгжиж, урам дэм өгөхийн тулд бие биедээ итгэж найдаж сурсан.

Лоукиа “Би анх 12 настайдаа сүмд очихдоо баяртай байсан ч, тэнд надтай ойролцоо насны хүүхэд байхгүй юм байна гэдгийг мэдсэн юм. Одоо тэр үеэс хойш хоёр жил өнгөрсөн ба олон залуу эмэгтэйтэй болсон тул анх удаа Залуу эмэгтэйчүүдийн аяллыг хийсэн” гэв. Хамтдаа уулзсаны дараа тэр “Хожмын үеийн гэгээнтэн байх гэдэг нь юу болохыг би ухааран ойлгосон. Сайн мэдээний дагуу амьдрахад биднийг гэрэл хүрээлдэг” хэмээн хэллээ.



“ЗБББТ чуулганы хамгийн дуртай хэсэг бол спортын арга хэмжээ, өглөөний онцгой цугларалт, тоймлон авч үзэх зэрэг бүлгийн цуглаанууд байсан. Энэ нь надад илүү тусархаг мөн тэвчээртэй байж, судруудыг илүү их үнэлэхэд тусалсан.” —  
Хайг Т., 14 настай




Германы Штутгартад болох ЗБББТ чуулган руу явах замдаа




ЗБББТ чуулган дээр Иаков 1:5 дээрх “Асуу” гэсэн үгийг үсэглэж байгаа нь

## “Нэг сэтгэлээр хамтдаа зүтгэж, нэг сүнс дотор бат зогсоцгоо”


Филиппой 1:27



“Бид ЗБББТ чуулганаар нэг бүлэг болсон бөгөөд энэ нь биднийг хүчирхэгжүүлсэн. Бид одоо бие биенээ бүр сайн мэддэг болсон тул энэ нь мөн Грекийн өсвөр үеийнхний хөтөлбөрийн загварыг өгч, үүнд нөлөөлж тусалсан юм.” —Алексис Х, 18 настай



“ЗБББТ чуулганы тайзан дээр дуулах нь миний амьдралдаа хийж байсан хамгийн зоригтой үйлдэл байсан ба амьдралын маань хамгийн гайхамшигтай цаг мөчүүдийн нэг байсан. Тэр цаг мөчид бид энэ газар дэлхийд ямар чухал болохыг би олж мэдсэн.” —Ирини С., 17 настай



Ирини С. ЗБББТ чуулган дээр дуулж байгаа нь





*“Би Залуу эмэгтэйчүүдийн аял-  
лаар амьдрал бол марафонтой  
адилхан юм гэдгийг мэдэж  
авсан. Энэ нь надад итгэлээ  
хөгжүүлж, яг л марафонд  
оролцож байгаатай адил бид  
зөв зам дээр үргэлжүүлэн явах  
хэрэгтэй гэдгийг олж мэдэхэд  
тусалсан. Энэ үйл явдал надад  
гэрчлэлээ хөгжүүлж, итгэлтэй  
хэвээр үлдэж, зөв зам дээрээ  
зогсоход тусалсан.”*

**—Винифред К., 14 настай**

# “Амьдрал бол ойрын зайн гүйлт биш, харин марафон юм”

Залуу эмэгтэйчүүдийн аяллын уриа



Залуу эмэгтэйчүүд Грекийн Марафон хотод



*“Бид бүгдээрээ далайн эрэг дээрх чулуунууд өвөрмөц байдгийн адил өвөрмөц.”*  
**—Бриана В.**



*“Нар мандахыг харах нь амар амгалан, гайхамшигтай сайхан сүнсийн  
мэдрэмжийг авчирсан.”* —Лиззи Т.

15 настай Брианагийн хувьд, ЗБББТ чуулган болон Залуу эмэгтэйчүүдийн аялал түүнд өөрийгөө нээж, бусадтай ярилцахад тусалсан байна. “Гэр бүл маань байнга нүүдэг бөгөөд би ичимхий бүрэг тул бусадтай харилцаа холбоо үүсгэхэд хэцүү байдаг байв. Гэхдээ би ЗБББТ чуулган дээр бүлгийнхэнтэйгээ дотносож, үнэхээр сайн найзуудтай болж чадсан. Гэрчлэлийн цуглааны үеэр бид өөрсдийн мэдрэмжийг хуваалцсан бөгөөд бусад хүүхэд ч гэсэн адилхан зүйл мэдрснийг би олж мэдсэн” гэж хэлсэн.

17 настай Мари Х. “Амьдрал бол ойрын зайн гүйлт биш, харин марафон юм” гэсэн аяллын уриаг мартаагүй. Залуу эмэгтэйчүүд болон тэдний удирдагчид тэвчээртэй байж, бариандаа орж ирэхийн ач холбогдлын талаар ярилцсаныг тэр дурдсан. “Энэ нь надад тэвчиж, алхаа гишгээгээ тааруулж, бариан дээр анхаарлаа төвлөрүүлэхийг сануулсан. Хэрэв тэгж чадах юм бол би Тэнгэрлэг Эцэгийн надаар хийлгэхийг хүссэн зүйлсийг хийж чадна.”

Аяллын хамгийн тод мөч бол хамгийн сүүлчийн өглөө далайн эрэг дээр зохион байгуулсан, нар мандахыг харах онцгой цугларалт байв. 17 настай Лиззи Т. “Бид судруудаа гаргаад, онцгой цугларалтаа хийж, нар мандахыг харсан. Бид Бурханы хайрыг бүгдээрээ мэдэрсэн. Энэ нь хамтдаа өнгөрүүлсэн цаг мөчтэйгөө салах ёс гүйцэтгэх гайхалтай сайхан арга зам байв” гэж хэлэв.

## Ирээдүйг эрэлхгээр угтах нь

17 настай Ирини С. “Би ЗБББТ чуулган болон Залуу эмэгтэйчүүдийн аяллаас сайн мэдээний талаар мөн энэ нь миний амьдралд хэрхэн туслах тухай олон зүйлийг сурч мэдсэн. Би олон найзтай болж, өөрийн бодол, мэдрэмжийг илэрхийлэх нь ямар чухал болохыг олж мэдсэн. Би мөн Ариун Сүнсийг болон бидний Аврагч, Есүс Христийн хайрыг гүн гүнзгий мэдэрсэн.




2017 оны Грект болсон хамгийн анхны Залуу эмэгтэйчүүдийн аялал

Өөр хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхэнтэй хамт байх нь түүний өөртөө итгэх итгэлийг хүчирхэгжүүлсэн хэмээн тэр хэлсэн. “ЗБББТ чуулган болохоос өмнө би Бурханы бидэнд зориулан хийсэн үзэсгэлэнтэй сайхан зүйлс болон Түүний бидэнд зориулан боловсруулсаар байгаа төлөвлөгөөг олж хардаггүй байсан.

Бид сайн мэдээний дагуу амьдрахыг болиулах гэж оролдож буй эргэн тойрныхоо

ямар ч хүний эсвэл өөр бусад зүйлийн нөлөөнд автаж болохгүй” хэмээн 17 настай Манесса А. хэлэв. “Хаана ч сайн мэдээ адилхан бөгөөд бид үргэлж зөв зам дээр үлдэх ёстой.


Грект үү эсвэл дэлхийн өөр улс оронд байна уу гэдгээс үл хамааран тэр замаар хамтдаа явах нь бидэнд сүнсээрээ нэгдмэл байх боломжийг олгодог. ■




“Нэг шашин шүтлэгтэй өсвөр үеийнхэнтэй хамт байх надад маш их таалагдсан. Бид зүгээр л нэг нэгнийхээ нэрийг мэдэлцэхээс илүү хоорондоо ямар нэгэн онцгой байдлаар холбогдсон мэт надад санагдсан.”  
—Павлос К., 15 настай



“Өдөр бүр надтай адил зүйлийг үзэж туулдаг бусад өсвөр үеийнхэнтэй уулзах боломжтой байсандаа би баярлаж байна.”  
—Жошуа К., 17 настай



“Дэлхийн аль ч өнцөг буланд болж байгаа ЗБББТ чуулган болон Залуу эмэгтэйчүүдийн аялаас яг адилхан мэдрэмжийг авч болно. Цөөхөн хүнтэй Залуу эмэгтэйчүүдийн аялаар өөр хоорондоо холбогдоход илүү хялбар байсан тул надад таалагдсан.”  
—Оливиа Н., 15 настай



“Хэдийгээр би Сүмийн гишүүн биш ч аль болох долоо хоног бүр сүмд очихыг хичээдэг. Залуу эмэгтэйчүүдийн урианд би дуртай.”  
—Айрин К., 14 настай

## Грек дэх Сүм



1900-аад оны эхээр Ригас Пофантис гэх Афин гаралтай хэвлэгч Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн удирдагчдад мэдээлэл авах хүсэлт илгээжээ. Турк дахь Сүмийн номлолын ерөнхийлөгч Пофантис зааж, түүнд 1905 онд баптисм хүртээсэн байна.



1950 он хүртэл Сүм Грект өргөжин тэлээгүй бөгөөд тухайн үед АНУ-ын Ютагийн Солт Лэйк Сити дэх Грек-Америкийн Сүмийн гишүүд өөрсдийн өв уламжлалыг хадгалж, төрөлх газар нутагтайгаа холбоогоо алдахгүйн тулд Hellenic Latter-day Saint Society гэх байгууллагыг зохион байгуулжээ.



Сүмийн удирдагчид 1965 онд Афинд жижигхэн цуглаан байгуулж, 1967 онд дахин зохион байгуулсан байна. Тэд 1990 оны 7-р сард Грек Афин номлолыг зохион байгуулж, 1999 оны 5-р сард Грекийн анхны цуглааны байрыг барьж дуусгажээ.



Грек, Афин, Халандри цуглааны байр



Сүмийн гишүүнчлэл: 802  
Цуглаанууд: 3



# “Патриархын адислал маань шийдвэр гаргахад хэрхэн тусалж болох вэ?”

“Патриархын адислал нь хүлээн авагчид зориулсан илчлэлт бөгөөд амьдралынх нь туршид хамгаалж, сүнсээр өдөөж, үйлдэж, зөв шударга байх сэдлийг төрүүлдэг удирдамжийн эх сурвалж юм. Патриархын адислалд үнэндээ таны мөнхийн боломж бололцооны тухай номын бүлгүүд агуулагддаг. . . .

... Энэ бол тэнгэр дэх гэр орон руу тань чиглүүлэх гэрлийн Лиахона юм.”

President Thomas S. Monson (1927–2018), “Your Patriarchal Blessing: A Liahona of Light,” *Ensign*, Nov. 1986, 65, 67.



## Бидний хувийн Лиахона

Патриархын адислал бидэнд өөрсдийн мөнх бус оршихуйн өмнөх, мөнх бус амьдралын

үеэрх мөн мөнх амьдралын мөн чанарын талаар олж мэдэхэд тусалдаг Тэнгэрлэг Эцэгийн арга зам юм. Өөрсдийнхөө талаар энэ гурван онцгой үнэнийг мэдэж авах нь Бурханы бидэнд зориулсан төлөвлөгөөг дагахад тусалдаг. Бид хэн гэдгээ, яагаад энд байгаагаа мөн хаашаа очиж болохоо мэднэ. Лиахона нь Нифай болон түүний гэр бүлийнхнийг зөвлөгөөг нь хэр итгэлтэй, тууштай дагаж байгаагаас шалтгаалан ажилладаг байсантай адил (1 Нифай 16:28-ыг үзнэ үү) бид ч гэсэн бурханлаг чадавхад маань хүргэх өөрсдийн Лиахонаг мөн үүний зөвлөгөөг итгэлтэй, тууштай дагаж чадна.

Ахлагч Утай, 20 настай, Аргентины Салта номлол



## Мөнхийн талаас нь харах

Хэрхэн шийдвэр гаргаа мэдэхгүй байх үедээ би патриархын адислалаа уншиж, үүн дээрх тэнгэрлэг илчлэлтийн талаар тунгаан боддог.

Үүний дараа шийдвэр гаргахад хялбар болдог. Энэ нь надад дэлхий дээрх амьдралаа тэсэн гарч, амласан адислалуудаасаа хүртэхэд туслахын зэрэгцээ хэзээ нэгэн цагт Их Эзэний хаант улсад зохистойгоор ороход өөрийгөө бэлдэх хэрэгтэй гэдгийг сануулдаг. Энэ нь надад итгэлээ өсгөж, Их Эзэний хүсэлд итгэж, мөнхийн талаас нь харж амьдрахад үргэлж тусалдаг.

Абигэйл Ф., 18 настай, Филиппин, Кагаяан Валли



### Тэнгэрлэг зөвлөгөө

Миний патриархын адислал надад Тэнгэрлэг Эцэгийн зөвлөгөөг өгдөг. Хэрэв би тухайн зөвлөгөөг дагах юм бол гаргах

хэрэгтэй шийдвэрүүдийнхээ талаар илчлэлт хүлээн авах болно гэдгээ мэднэ. Тэр намайг зарим зүйлийг асуухаас ч өмнө хариулдаг.

*Ками Х., 16 настай, АНУ, Юта*

### Сүнсийг сонсох

Хэрэв та тайтгарал, удирдамж эсвэл хойшлуулшгүй чухал асуултынхаа хариултыг эрж байгаа бол та үүнийг хэзээ талаар үнэн сэтгэлээр залбиран, чин зүрхнээсээ патриархын адислалаа уншиж, Сүнсийг сонсож болно. Судраас эрж хайх нь бас тус болдог. Хэрэв та үүнийг жинхэнэ итгэлээр хийх юм бол Их Эзэн Өөрийн цагт, хамгийн сайн арга замаар хариулах болно гэдэгт би итгэдэг.

*Кэзиа Б., 15 настай, АНУ, Хавай*

### Амлагдсан адислалууд

Патриархын адислал Бурхан биднийг хэрхэн адислахыг хүсэж байгааг бидэнд хэлж өгдөг. Тэр биднийг сэрэмжлүүлж, бидэнд хэрхэн түүнтэй илүү адилхан болж болохыг тайлбарладаг. Тэнгэрлэг Эцэг бидэнд юу бэлдсэнийг мөн тэдгээрийг хэрхэн авч болохыг мэдэх юм бол бид үүнийг хүлээн авахын тулд зохих ёсоор сонголт хийж, үйлдэх болно.

*Хантэр Х., 18 настай, АНУ, Юта*

*Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.*



## Залуу эмэгтэйн хувьд би анхаарлаа боловсрол эзэмшиж, ажил мэргэжилтэй болоход төвлөрүүлэх ёстой юу эсвэл эхнэр, эх хүн болоход төвлөрүүлэх ёстой юу?

“Гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг” мөн “эхийн үндсэн үүрэг нь үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх явдал”<sup>1</sup> болохыг бид мэднэ. Мөн өөр олон шалтгаанаар бошиглогчид эрэгтэй, эмэгтэй хүмүүст боловсролтой болохыг зөвлөснийг бид мэднэ.<sup>2</sup> Түүнчлэн олон эмэгтэйд ажил мэргэжилтэй болох хэрэг гардаг буюу тэд ийм хүсэлтэй болохыг бид мэднэ.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Даллин Х.Өүкс боломж бол эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлээ сонгох уу эсвэл боловсрол, ажил мэргэжлээ сонгох уу гэдэгт оршиж байгаа юм биш хэмээн хэлсэн. Тэр “Бид хэзээ болох цаг хугацаагаа л сонгодог. Бид бас үүнийг хийхдээ Их Эзэний сүнсний нөлөөг мөн Түүний үйлчлэгчдийн сургаалыг эрэлхийлдэг”<sup>3</sup> хэмээн хэлсэн.

Боловсрол эзэмшиж, гэр бүлтэй болохоор төлөвлө. Та ажил мэргэжлээ ч мөн адил төлөвлөж болно. Энэ бүхнийг хийхдээ та Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дуулгавартай дагаж, Түүний хүслийг эрэлхийлэхэд анхаарлаа төвлөрүүлэх ёстой.

### ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” familyproclamation.lds.org.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 9-ийг үзнэ үү.
3. Dallin H. Oaks, Face to Face event with Elder Oaks and Elder Ballard (worldwide young single adult event, Nov. 19, 2017), broadcasts.lds.org.

Нэгэн залуухан эмэгтэй ажил мэргэжил, гэр бүл хоёрын алинд нь анхаарлаа төвлөрүүлэхэе сайн мэдэхгүй байгаа тухай түүхээ [lds.org/go/41961](https://www.lds.org/go/41961) дээр хуваалцсан. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон түүнд юу гэж хэлснийг үзнэ үү.

## Та юу гэж бодож байна вэ?

“Анхны үзэгдэл гэх мэт зүйлс болдог гэдэгт найзууд тань итгэдэггүй бол та юу гэж хэлэх вэ?”

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт [liahona.lds.org](mailto:liahona@lds.org) хаягаар (“Өгүүлэл эсвэл санал оруулах” гэдэг дээр дар) 2019 оны 5-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү. Эсвэл хариулт болон зургаа [liahona@lds.org](mailto:liahona@lds.org) хаягаар э-мэйлээр илгээнэ үү. Та өөрийнхөө бүтэн нэрийг болон тойрог, гадасныхаа (эсвэл салбар, дүүргийнхээ) нэрийг бичнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах магадлалтай.






**Дэвид Диксон**  
Сүмийн сэтгүүлүүд

**Б**аярын өдрүүдийн хувьд Христийн мэндэлсний баяр ихэнхдээ хамгийн их анхаарал татдаг. Гэвч Христийн мэндэлсний болон амилсны баяр болгоноор тэмдэглэдэг үйл явдлууд маш олон жилийн өмнө болоогүй байсан бол эдгээр баяр байхгүй байх байсан.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) өмнө нь “Христийн амилсны баяр байгаагүй бол Христийн мэндэлсний баяр байхгүй байх байсан. Бетлехемийн нялх Есүс Гетсемани болон Калварийн гэтэлгэгч Христгүйгээр мөн Амилуулалтын гайхамшигт ялалтгүйгээр өөр хүү байх байсан”<sup>1</sup> хэмээн заасан.

Жил бүрийн баяраараа таны нэмж хийж болох хэд хэдэн уламжлалыг дурдъя.



**1**

### **Христийн мэндэлсний баярын магтууг дуулахаар явах**

Цаа буга, элфүүдийн тухай өвөрмөц сонин дуу аялгууг эс тооцвол Христийн мэндэлсний баярын магтуунууд бүгд Есүс Христийн тухай өгүүлдэг. Христийн амилсны баяраар Аврагчийн тухай дуулах, тийм ээ, хөршүүдийнхээ үүдний өмнө хүртэл зогсож дуулахад хамгийн тохиромжтой цаг билээ.

Хэрэв танд ямар нэгэн санаа орж ирэхгүй бол дууллын номын “Христийн амилсны баяр” болон “Цагаатгал” гэсэн хэсгээс дуунууд харна уу. Есүс Христийг магтан дуулсан ямар ч дууг Христийн амилсны баярын магтуу хэмээн үзэж болно.



**2**

### **Хэн нэгнийг уучлах**

Наманчлалын бэлэгт та хэр олон удаа талархаж байсан бэ? Христийн амилсны баяр бидэнд бусдыг хэрхэн уучлах талаар илүү их бодох боломжийг олгодог.

Есүс “Иймийн тул, та нар бие биенээ уучлах ёстойг та нарт хэлнэ би;

Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” (Сургаал ба Гэрээ 64:9–10) хэмээн заасан.

Та өөрөөсөө “Та хэний талаар таагүй бодол тээж явдаг вэ?” гэж асууж болно. Уг хүнээ уучлах хүчийг өгөхийг хүсэн залбирч, тэдгээр зовлонтой мэдрэмжүүдийг алга болгох боломжийг Аврагчид олго.



**3**

### **Дуу бүжигт наадам, жүжиг болон өөр бусад тоглолт хийх**

Та Христийн амилсны баярын тоглолт зохион байгуулж болно. Үүний энгийн нэг жишээ бол гэр бүлийн үдшээр судраас унших эсвэл нийтээрээ дуулах концерт ч байж болно.

# **Христийн амилсны баяраар шинэ уламжлалыг дагаж үзнэ үү**



4

### Хайртай хүмүүсийнхээ булшийг эргэж очих

Есүс Христийн ачаар үхлийн хатгуур үгүй болсон (1 Коринт 15:55-ыг үзнэ үү). Хайртай хүмүүсийнхээ булшин дээр очиж, энэ агуу мэдээний талаар тунгаан бодоорой.

Та бас тэдгээр булшин дээр очихдоо Амилалтын талаар өгүүлсэн дуртай шүлгээсээ чанга уншиж болно. 1 Коринт 15:20–22; Алма 11:42–44; Сургаал ба Гэрээ 88:14–16 гэх мэт хэдэн (олон шүлгээс) судрыг үүнд ашиглаж болно.



5

### Байгаагаасаа илүү сайн байх

Христийн амилсны баяраар Гетсемани болон загалмайд дээр болж өнгөрсөн мөн гурав дахь өдөр Аврагч үхлээс боссон, дараа нь тэнгэрт дээш аваачигдахынхаа өмнө 40 хоногийн туршид тохируулсан зэрэг үйл явдлуудыг тэмдэглэдэг.

Түүнчлэн тэнгэрт дээш аваачигдсаныхаа дараа Есүс Христ нифайчууд дээр ирж, тэдэнд тохируулсан (3 Нифай 11–28-ыг үзнэ үү). Ийм л их зүйлийг тэмдэглэдэг шүү дээ!

Тиймээс, Христийн амилсны баярын өдрүүдээ яагаад нэмж болохгүй гэж? Христийн амилсны баярын гайхамшгаас сэтгэлийн таашаал авахаа уртасгацгаая. Христийн амилсны баярын дараах 40 хоногийн туршид Христтэй

илүү адилхан болох ухамсартай хүчин чармайлт гарга. Сүнслэг өдөөлт авахын тулд ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны: “Есүс Хуучин Гэрээний Иехова тул Хуучин Гэрээн дээр Түүний хэлж, хийсэн бүх зүйлийг судлахад долоо хоног бүр цаг зав гарга. Тэрээр Шинэ Гэрээний Христ тул тэнд цэдэглэгдсэн Түүний хууль зарлигуудыг судал. Мормоны Ном дээр цэдэглэгдсэн Түүний сургаалуудыг судал. Учир нь Түүний үйл хэрэг, тохирууллын талаар үүнээс илүү тодорхой илчлэгдсэн өөр ном үгүй. Эцэст нь Сургаал ба Гэрээнд цэдэглэгдсэн Түүнийг үгсийг судал. Учир нь Тэрээр энэ эрин үед Өөрийн хүмүүст үргэлжлүүлэн заасаар байгаа”<sup>21</sup> гэсэн урилгыг бодож үзнэ үү.

### Таны уламжлалууд таныг хүлээж байна

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф “Түүхэн дэх хамгийн чухал өдрийг олъё гэвэл бид бараг хоёр мянган жилийн өмнө, Гетсеманийн цэцэрлэгт Есүс Христ өвдөг сөгдөн маш хүчтэй залбирч, Өөрийн биеийг бидний гэм нүглийн төлөө золиос болгон өргөсөн тэр үдэш рүү буцаж очих хэрэгтэй”<sup>3</sup> гэж заасан.

Түүхэнд болж өнгөрсөн хамгийн чухал үйл явдлын талаар жил бүр цаг зав гаргаж тунгаан бодвол зохино. Харин энд орсон эсвэл өөрийн тань сонгосон уламжлалууд бидэнд ийн үйлдэхэд тусалдаг.

Та энэ жил ямар уламжлалыг нэмэх вэ? ■

*Энэ Христийн амилсны баяраар, бидэнд өгсөн хамгийн агуу бэлгийг дурсан санахад илүү их цагийг зарцуулаарай.*

### ЭШЛЭЛҮҮД

1. Gordon B. Hinckley, “The Wondrous and True Story of Christmas,” *Ensign*, Dec. 2000, 5.
2. Russell M. Nelson, “Prophets, Leadership, and Divine Law” (worldwide devotional for young adults, Jan. 8, 2017), [broadcasts.lds.org](http://broadcasts.lds.org).
3. Дийтр Ф.Угдорф, “Энэ Хүнийг харатун!” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 134.



# Бурханы хайрын хамгийн агуу илрэл

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч  
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

**Б**урхан бидэнд өсөж хөгжиж, өөрсдийн чадавхад хүрэхэд туслах удирдамжийг өгөх замаар биднийг гэх Өөрийн хайрыг илэрхийлдэг. Бидний хэн болох талаар мөн чадавх, мөнхийн боломж бололцооны тухай хамгийн их мэдэх Тэрээр бидэнд тэнгэрлэг зөвлөгөө, зарлигуудыг гарын авлагадаа буюу ариун судруудад өгсөн. Бид тэдгээр зааврыг нь ойлгож, дуулгавартай дагах юм бол амьдрал маань зорилготой, утга учиртай болдог. Бүтээгч маань бидэнд хайртай бөгөөд биднийг аз жаргалтай байгаасай хэмээн хүсдэг. Биднийг гэх юутай ч зүйрлэшгүй бурханлаг хайрынхаа илрэл болгон Тэрээр Өөрийн Төрсөн Ганц Хүү Есүс Христийг илгээсэн.

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэдэг хэн ч мөхөхгүй харин мөнх амьтай болох юм.

Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ” (Иохан 3:16–17).

Есүс мөнх бус амьдралд төрсөн. Тэрээр төгс амьдралаар амьдарч байсан бөгөөд ийн бидний дагах замыг зааж өгсөн юм. Тэр шавь нартаа “Би бол Ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно” (Иохан 8:12) хэмээн заасан.

Христ бидний нүглийг цагаатгаж, “Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн” (Сургаал ба Гэрээ 19:18) зовлон шаналлыг үүрэхэд бэлэн байсан талаар бодож үзэх юм бол Түүний биднийг гэх хайр ямар гүн гүнзгий болохыг ойлгож эхэлж болох юм.


Христийн амилсны баярын энэ үеэр бүгдээрээ Түүний Хайрт Хүү Есүс Христийн Цагаатгал, Амилалтын төлөө Бурханд онцгойлон талархлаа илэрхийлцгээе. Энэхүү мөнх бус байдал зөвхөн Түүнд, Түүгээр мөн Түүгээр дамжин өөрчлөгдөшгүй, төгс оршихуйд болох боломжтой. Учир нь ямар ч үг бидний баяр баясгаланг илэрхийлж чадахгүй.

Байгалийн бүхий л гайхамшгаас Түүний бурханлаг хүч, хайрын илрэлийг цухасхан харах боломжтой. Гэсэн хэдий ч хамгийн агуу гайхамшиг биднийг хүлээж байгаа. Энэ нь үхэл болон булшнаас устаж алга болохгүй шинэ ертөнцөд Түүний хүчээр урагш гарч ирэн, хэрэв зохистой байвал Түүнтэй мөн Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт үүрд мөнхөд байх тэр цаг мөчид тохионо. ■

*1988 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.*

1950-иад оны эхээр аавынхаа

**машин зарж,  
борлуулах  
газарт ажиллаж,  
хамгийн сайн  
борлуулагч**  
болж байжээ.



Тэр 1928 оны  
10-р сарын 8-нд  
**Юта мужийн  
Солт Лэйк  
Ситид** төрсөн.



Тэр  
**Ютагийн  
Их  
Сургуульд**  
сурч байсан.

Ерөнхийлөгч

# М.РАССЭЛЛ БАЛЛАРД



Бүрэн цагийн  
номлолд  
**Англид  
үйлчилсэн.**



1974 оноос  
1977 он хүртэл  
Канадын Торонто  
**номлолын  
ерөнхийлөгчөөр**  
үйлчилсэн.



Тэр өөрийн эхнэр  
Барбара Бөүэнтэй  
Ютагийн Их  
Сургуулийн  
**“Танилцах  
өдрийн  
бүжиг”**  
дээр танилцжээ.



**Барбара  
Бөүэнтэй**  
1951 оны 8-р  
сарын 28-нд  
Солт Лэйк ариун  
сүмд гэрлэжээ.



**7** хүүхэд **43** ач,  
зээ, **91** ачинцар,  
зээнцэртэй.

Дүрвэгчдийн лагерь руу урт  
зам туулж ирснийхээ дараа  
хайрцаг жигнэмэг аваад, эхнийхээ  
жигнэмгийг ерөнхийлөгч Баллардад  
өгсөн бяцхан хүүгийн дурсгал болгон  
**Огео жигнэмгийг**  
ширээн дээрээ хадгалдаг.



**Эцгийн  
талын өвөө:**  
Арван хоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын  
ахлагч  
Мэлвин  
Ж.Баллард

**Эхийн  
талын өвөө:**  
Арван хоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын ахлагч  
Хайрум Мак  
Смит



Түүнийг 1985 оны  
10-р сарын 6-нд  
**Арван хоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгад**  
дэмжин баталсан.



Түүнийг Арван хоёр  
Төлөөлөгчийн Чуулгын  
**ерөнхийлөгч  
ийн үүрэг  
гүйцэтгэгчээр**  
2018 оны 1-р сарын 14-нд  
онцгойлон адисалжээ.

1980 оны Ерөнхий  
чуулганы дараа тэр  
гэрчлэлийн хувьд  
асуудалтай гишүүдэд  
урмын үгтэй  
**600 гаруй  
захидал**  
бичиж байжээ.



## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН ӨӨР ХУУДАСНУУД

Шинэ *Найз* сэтгүүлийг сайн ашигла. Хэрэв гэрт тань хүүхдүүд байхгүй бол та дараах зүйлсийг хийж болно. Тухайлбал:

- *Найз* сэтгүүлийг *Лиахона* сэтгүүл авдаггүй гэр бүлтэй хуваалцах
- Найздаа эсвэл хөршдөө өгөх
- Хүүхдийн хэсгийн удирдагч, багшид өгөх



ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ  
**ЧУХАЛ ШИЙДВЭР  
ГАРГАХАД ТАНЬ  
ТУСЛАЛЦАА ХЭРЭГТЭЙ  
БАЙНА УУ?**

42

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД  
ЗОРИУЛАВ  
**ӨӨРИЙГӨӨ БОЛОН  
БУСДЫГ АМАР  
АМГАЛАН БОЛГОХ НЬ**

52

ХРИСТИЙН АМИЛСНЫ БАЯР  
**ШИНЭ УЛАМЖЛАЛУУД**

62

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ



# Найз



**ХРИСТИЙН  
АМИЛСНЫ  
БАЯРЫН  
ТУХАЙ ТҮҮХ**  
4–6-р хуудсыг үзнэ үү





Ерөнхийлөгч  
Рассэлл  
М.Нэлсон

# Бурханы агуу БЭЛЭГ



Нэг өдөр Нэлсон эгч бид хоёр аквариумд байсан Нхалуун орны загаснуудыг харсан юм. Олон өнгийн, янз бүрийн хэлбэр дүрс, хэмжээтэй загаснууд урагш хойш сум мэт хурдан сэлцгээнэ. Би хажууд байсан ажилчнаас “Эдгээр үзэсгэлэнтэй загасыг хэн хооллодог юм бэ?” гэж асуув.

Тэр эмэгтэй “Би” гэж хариуллаа.

Тэгэхэд нь би “Тэд ер нь танд талархлаа илэрхийлж байсан уу?” гэж асуулаа.

Эмэгтэй “хараахан үгүй дээ!” гэж хариулав.

Зарим хүн яг эдгээр загастай адил байдаг. Тэд Бурханаа мөн Түүний сайн сайхан бүхнийг мэдэлгүй өнгөрдөг. Хэрэв бид Бурханы хайрыг ойлгон мэдэрч, Түүнд талархлаа илэрхийлдэг байсан бол хэчнээн сайхан байх вэ.

## Есүс Христэд талархах

Бурхан Өөрийн Хүү, Есүс Христийг бидэнд туслуулахаар илгээсэн. Тэр бидэнд маш их хайртай учраас үүнийг хийсэн.

Есүс биднийг **гэтэлгэхээр** ирсэн.

Тэр **Цагаатгал** хийсэн болохоор бид нас барсныхаа дараа амилуулагдах болно.

Түүний Цагаатгалын улмаас бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ мөнхөд хамт амьдрах боломжтой болсон.

Есүс ингэж тайлбарлажээ.

“Би бол амилалт ба амь мөн.

Надад итгэдэг хүн үхэвч амьдарна”  
(Иохан 11:25–26).

Энэ бол Христийн амилсны баярын гайхамшигт захиас билээ! ●

“Бурхандаа талархъя”  
үзээс авах, 2012 оны 4-р сарын  
Ерөнхий чуулган, 82–85.



### Гэтэлгэл:

Биднийг Бурханд эргэн очуулж болохын тулд бидний нүглийн төлөөсийг төлсөн.

### Цагаатгал:

Есүс Гетсеманийн цэцэрлэгт бидний үйлдсэн нүглийн төлөө зовж шаналан, Калваригийн загалмай дээр амиа өгсөн.



### Есүс бол миний Аврагч

Христийн амилсны баярын өглөө Есүс амилсан. Өгүүлбэрүүдийг уншаад, Тэр бидний төлөө юу хийснийг олж мэд. Өгүүлбэр бүрийг уншсанаах дараа нарны туяаг буд. Дараа нь зургаа бүхэлд нь будаарай.

Есүс Гетсемагид болон загалмай дээр бидний бүх нүглийн төлөө зовж шаналсан.

Есүс биднийг үхлээс аврахын тулд нас барж, амилсан.

Есүс бидэнд Өөрийг нь дурсан санахад туслахын тулд ариун ёслолыг өгсөн.


Есүс бидэнд бусдыг уучилж өршөөхийг зааж.

хэрхэн эелдэг зөөлөн байхыг харуулсан.

Есүсийн ачаар бид бүгдээрээ нас барсныхаа дараа амилуулагдах болно.



# Христийн амилсны баярын тухай түүх



Есүс найзууддаа хайртай байв. Тэр тэдний хөлийг угаасан юм. Дараа нь Тэр ариун ёслолыг тэдэнд түгээв. Тэр тэдэнд Өөрийг нь дурсан санаж мөн бие биенээ хайрла хэмээн хэлсэн.



Дараа нь Есүс цэцэрлэг рүү очиж, бид бүгдийн төлөө залбирсан юм. Тэр мөн бидний өвчин, нүглийн маань зовлон шаналлыг мэдрэв.




Уурлан хорссон хүмүүс  
Есүсийг авч явжээ. Тэд  
Түүнийг зовоосон ба  
Тэрээр загалмай дээр нас  
барсан юм. Найзууд нь  
Түүний биеийг хадан  
булшинд тавьсан.



Гурван хоногийн дараа найзууд нь эргэж иртэл булш хоосон байв.  
Тэнгэр элчүүд “Тэр амилсан” хэмээн тэдэнд хэлжээ. Есүс амилсан байлаа!  
Есүсийн ачаар бид ч бас нас барсныхаа дараа дахин амьдрах болно.





Есүс надад хайртай. Би Түүнийг дурсан санаж,  
Христийн амилсны баярыг онцгой болгож чадна. ●

*Христийн амилсан баярын өглөөний талаар Матай 28-аас уншина уу.*

# Түүн рүү эргэн очиход минь

Баяр хөөртэй ♩ = 90-96

Үг, аяыг Салли Дэфорд

F C Dm B<sup>b</sup> C F

1. Хонь-чин хур-га бү - рээ хайр-лана. Хол төө - рөн одо-ход нь Нэ -  
 2. Ав - рагч хүү-хэд бү - рээ хайр-лана. Алс төө - рөн одо-ход минь Ө -  
 3. Ав - рагч за-мыг минь ха - руул - даг. Амьд-рах ар - гыг заа - даг. Бу -

C7 Am Dm Gm C7

рээр нь бүг - дийг дуу-даад, Хой - ноос нь Тэр хай - даг. Хоньч-  
 дөр шө-нийн аль ч үед Тэр Үр - гэлж хай-саар бай - даг. На -  
 руу за-маар орж хол-доод, Бу - цаад ирэ-хэд өршөө - нө. Тий -

F Dm Gm C7 A A7 Dm

ны - хоо дууг тэд тани-маг - цаа Хурд-хан гүйн очи - ход нь Хайрт  
 майг гэх Түү - нийг би сон-соод, Найд-вар тээн, Түүнд очи - но. Түүн  
 мээс би Ав - раг - чийг сон-соно. Тэ - гээд нүг - лээс хол байна. Түүн

B<sup>b</sup> C7 F Dm B<sup>b</sup> C7 F

Хонь-чин маань га - раа алд-лаад, Хур - га бү - рээ тэвэр - нэ.  
 рүү эр - гэн очи - ход минь Тэр Тэв - рэн хайр-лаж уг - тана.  
 рүү эр - гэн очи - ход минь Тэр Тэв - рэн хайр-лаж уг - тана.

© 2019 by Sally DeFord. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг ашгийн бус зорилгоор Сүм дээр болон гэр орондоо ашиглахаар хувилж болно.

Энэхүү мэдэгдэл хэвлэсэн хувь бүр дээр байх ёстойг анхаарна уу.



## Жэйн Макбрайд

Бодит түүхээс сэдэвлэв

“Та нар сайныг үйлдээсэй” (2 Коринт 13:7).

Ээж надад “Чи дүүгээ харах хэрэгтэй байна. Би өвдсөн хүнд туслахаар аавтай чинь хамт явлаа” гэж хэллээ.

Би жижигхэн байшингийнхаа шалыг шүүрдэнгээ дээш харан, толгой дохив. Ээж минь Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч байсан бөгөөд тойргийнхоо эгч нарыг эргэж тойрохоор байнга явдаг байсан юм.

Ээж “Баярлалаа, Арлин” гээд, зулай дээр минь үнсэв. “Жон унтаж байгаа. Тавиур дээр талхны хөрөнгө тавьсан тул хүрч болохгүй шүү” гэлээ.

Би ээж, аав хоёр тэргээ унаад, шороон замаар явахыг хаалгаараа харлаа. Ээжийгээ надад итгэсэнд би баяртай байв.

Гал тогоогоо шүүрдэнгээ би талхны хөөсөн гурилыг харахаар зогслоо. Орой ээжийнхээ талх барихыг би тэсэн ядан хүлээж байлаа. Бид шинэхэн барьсан талхаа ихэвчлэн гэрийн жимсний чанамалтай хамт иддэг байв. Гэвч манай жимсний чанамал гурван сарын өмнө дууссан байлаа.

Жимсний чанамал! Ийн бодоход чихэрлэг зүйл идмээр санагдав. Би тавиурын дээр тавьсан элсэн чихрийн сав руу харлаа. Ээж жимсний чанамал хийхээр хадгалж байгааг нь би мэдэж байсан л даа.

Би элсэн чихрийн талаар бодох тусам улам бүр өлсөж байв. Эцэст нь би сандал дөхүүлж, тавиур руу гараа өргөв. Хурууны маань үзүүр элсэн чихрийн саванд дөнгөж хүрч байлаа. Би савыг тавиурын ирмэг рүү татаж авчрав. . . .

Гэтэл сав тавиураас гулгаад уначих нь тэр! Би савыг барьж авах гэж оролдсон боловч талхны хөөсөн гурилын яг голд чанга дуу гарган унав. Элсэн чихэр хөөсөн гурил болон тавцангаар мөн шалан дээгүүр асгарав.

“Үгүй ээ!” хэмээн би хашхирлаа. Үүнээс болж дүү маань сэрээд, уйлж эхлэв. Би ч гэсэн уйлмаар байв.



# Шударга байх сайхан



Ээж энэ эмх замбараагүй байдлыг хараад юу гэж хэлэх бол?

Би Жоныг тайвшруулсныхаа дараа элсэн чихрийг чадлаараа цэвэрлэлээ. Савыг нь гурилаас гаргаад, угааж цэвэрлэв. Би тавцанг бас шалаа ч цэвэрлэлээ. Гэвч талхны хөөсөн гурилаас элсэн чихрийг яаж ч гаргах боломжгүй байв.

Би савыг нь тавиур дээр буцааж тавих юм бол ээж хоосон гэдгийг нь анзаарахгүй өнгөрч магадгүй гэж бодлоо. Гэвч ингэх нь буруу гэдгийг би мэдэж байсан. Тиймээс би саваа ширээн дээр тавиад, ээж, аав хоёрынхоо ирэхийг хүлээлээ.

Ээж гэртээ ирээд, элсэн чихрийн савыг шууд олж харав.

Би сайн гэгч гүнзгий амьсгаа авлаа. “Би зүгээр л элсэн чихрээс амсах гэсэн юм. Тэгсэн чинь савыг нь тавиураас түлхээд унагаачихсан. Би цэвэрлэх гэсэн боловч талхны хөөсөн гурилаас салган авч чадаагүй” гэж шал ширтэн зогсож байхдаа дуржигнууллаа.

Ээж хэсэг зуур чимээгүй байв.

“Би их харамсаж байна” гэж би нэмж шивнэлээ.

Ээж санаа алдав. “За, за. Өнөөдрийн талх ч их чихэрлэг болох нь дээ” гэлээ. Би дээш харахад ээж над руу инээмсэглэн харж байлаа. “Бидэнд юу болсныг хэлсэнд чинь баярлалаа” гэв.

Тэр орой чихэртэй талхаа идэж суунгаа ээж, аав, бид гурав үнэнч шударга байхын талаар ярилаа.

Аав “Бид бүгдээрээ амьдралдаа олон алдаа гаргадаг. Гэхдээ бид үнэнч шударга байж, наманчлахыг хичээх юм бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр баярлана. Хэдийгээр эхлээд хэцүү мэт санагдаж болох ч бид үнэнч шударга байсныхаа төлөө үргэлж адислагдах болно” хэмээн аав хэлсэн юм.

Гэсэн ч би элсэн чихэр асгасандаа харамсаж байв. Миний гаргасан алдаанаас болж бид энэ жил хангалттай их жимсний чанамал хийж чадахгүй байх. Гэхдээ л би үнэнийг хэлсэндээ баяртай байв. Энэ сайхан мэдрэмжийг хэчнээн их элсэн чихэр байсан ч надад өгч чадахгүй байлаа. ●

*Зохиогч нь АНУ-ын Колорагод амьдардаг.*



“Бурханлаг зарлигуудыг сахих нь адислалуудыг үргэлж авчирдаг бол бурханлаг зарлигуудыг зөрчих нь адислалуудыг үргэлж алдаж байдаг!”

**Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Итгэлээ харуул,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 47.**



# Ахлагч Бэднар Энэтхэгт айлтчлав

Ахлагч Бэднар өөрийн эхнэр Сюзан Бэднартай хамт Энэтхэг дэх Сүмийн гишүүдэд Есүс Христийн талаарх гэрчлэлээ хуваалцахаар айлчлав. Энэтхэг бол дэлхийн хамгийн том орнуудын нэг юм. Удахгүй тэнд анхны ариун сүм баригдах болно.



Ахлагч Бэднар, Бэднар эгч хоёр Ражамундри хотод очсон юм. Төлөөлөгч тэр газарт өмнө нь огт очиж байгаагүй.



Хүүхдүүдэд ахлагч Бэднартай гар барих боломж тохиов.



Хидерабад хотод болсон уулзалт дээр энэ охинд ахлагч Бэднар асуулт тавих боломж олдсон.



“Би дэлхийгээр хэдий чинээ их аялж, олон улс орноор айлчилна, төдий чинээ олон зүйлийг сурч мэдэн адислагдаж, дэлхийн бүх хүн ерөнхийдөө адилхан юм байна гэдгийг олж мэддэг!”




Бүгд Бурханы төлөөлөгчийн гэрчлэлийг сонсож байгаадаа баяртай байв.




## ЗААНУУДЫГ ИЖИЛСҮҮЛ

Энэтхэг ойролцоогоор 30000 заантай. Та доороос хэдэн хос зааныг олж чадах вэ?

Та Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын бүтээсэн ямар амьтдад дуртай вэ?







# Бидний Бошиглогч, Төлөөлөгчид

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг Есүс Христ бошиглогч, төлөөлөгчдөөр дамжуулан удирддаг. Тэдний талаар доор бичсэнийг уншина уу. Дараа нь Н23-р хуудсан дээрх **зургуудыг хайчилж аваад**, хүснэгт дээр байрлуулна уу. Зураг бүрийн дээр скочоор нааж, дээш нь нээгээд, ард талд нь байх мэдээллийг уншаарай!

- Анхны ажил нь радио засварын газрыг цэвэрлэх ажил байсан
- Хуульч болсон ба Ютагийн дээд шүүхийн шүүгч болсон
- Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгч байсан

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

## Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс

- Зурхний мэс засалч байсан
- Мандарин гэх мэт хэд хэдэн хэл сурсан
- 10 хүүхэдтэй буюу 9 охин, 1 хүүтэй

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн 17 дахь ерөнхийлөгч

## Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

- Ахлах сургуульд байхдаа сагсан бөмбөг тоглодог байсан
- Аваараа гэрийнхээ самбар дээр физикийн хичээл заалгаж байсан
- Рикс коллежийн буюу одоогийн Айдахо дахь БИЯС-ийн ерөнхийлөгч байсан

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

## Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

- Өндөр жишгийг дагаж баримталдаг байсан учраас коллежид байхдаа "бишоп" гэдэг хоч авч байсан
- Автомашин зарж, борлуулдаг газартай байсан
- Англид номлогчоор мөн Канадын Торонтод номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

## Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

- Англид ахлагч Күктэй номлолын хамтрагч байсан
- Сүмийн Боловсролын Системд ажиллаж байсан
- БИЯС-ийн ерөнхийлөгч байсан

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

## Ахлагч Жэффри Р.Холланд

- Хүүхэд байхдаа хоёр удаа дүрвэж байсан
- Нисэх онгоцны ахмад байсан
- Хүүхдүүд, ач, зээ нартайгаа цанаар тулгах дуртай

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

## Ахлагч Дийтр Ф.Угдорф

- Ахлах сургуулийнхаа америк хөлбөмбөгийн багт дамжуулагч байсан
- Германд номлолд үйлчилснийхээ дараа аавыгаа Сүмийн гишүүн болгон, баптисм хүртээсэн
- Рикс коллежийн буюу одоогийн Айдахо дахь БИЯС-ийн ерөнхийлөгч байсан

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

## Ахлагч Дэвид А.Бэднар

- Ахтайгаа хамт судраас судалж, залбирсны дараа гэрчлэлтэй болсон
- Ирээдүйн эхнэрээ дунд сургуулийнхаа урлагийн тоглолт дээр харсан
- Филиппин болон Номхон далайн арлуудад Сүмийн удирдагчаар үйлчилсэн



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Квинтин Л.Кук

- Японд номлогчоор мөн дараа нь номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн
- Дасгалын тоног төхөөрөмж хийх, зарах бизнес эхлүүлсэн
- Сүмийг бүхэлд нь хариуцсан бишпоор үйлчилж байсан



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Гари И.Стивэнсон

- Бага байхдаа гэр бүлийнхэндээ талх барьж өгдөг байсан
- Өсвөр насандаа Нью-Йорк дахь Кумора гүвээн дээрх тоглолтод оролцож байсан
- Төлөөлөгчөөр дуудагдахынхаа өмнө хуульч байсан



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Д.Тодд Кристоферсон

- Дундах нэр нь Гуннар буюу "зоригтой цэрэг" гэсэн утгатай
- 11-тэй байхад нь түүний гэр бүл Шведээс Юта руу нүүсэн
- Зүрхний эмчээр ажиллаж байсан



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Дэйл Г.Рэнланд

- Айдахо дахь нэгэн сүүний ферм дээр өссөн
- Францад номлогчоор мөн номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн
- Франц, португал, испани, англи хэлээр ярьдаг



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Нийл Л.Андэрсэн


- Оцон шувуу гэх мэт амьтдад дуртай
- Улс орон бүрийн хүмүүстэй уулзаж, танилцах дуртай
- Ургийн бичиг нь МЭ 837 онд төрсөн Анхны Луу Гонг хүртэл хөтлөгдсөн байдаг



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Гэррит В.Гонг

- АНУ-ын Нью-Йорк Сити номлолын ерөнхийлөгч байсан
- Тэр "Хамгийн чухал зүйл бол хүмүүс" гэсэн уриатай
- Чех улсад хамгийн анхны Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн байрыг онцгойлон адисалсан



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Роналд А.Расбанд

- Бразилаас ирсэн бөгөөд тэндээ номлогч байсан мөн Португалын номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байсан
- Хүүхэд байхдаа гэр бүлийнхэнтэйгээ хамт Сүмийн талаар суралцсан
- 12 наснаасаа номлолд бэлдэж эхэлсэн



Арсан хоёр Төлөөлөгчийн Чуулгын

### Ахлагч Улиссэс Соарэс

Хариултаа [lds.org/prophets-and-apostles.ru](https://prophets-and-apostles.ru) орж шалгана уу.





# Алдсан ХҮРЭМ

Шэйла Киндрэд

Бодит түүхээс сэдэвлэв

*“Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” (Сургаал ба Гэрээ 64:10).*

“Эж ээ, миний хүрэм байхгүй байна!” хэмээн Брад хэллээ. Сүмээс гэртээ харих цаг болсон ч Брад хүрмээ өлгүүрээс олсонгүй.

“Чи яг наанаа өлгөсөн гэдэгтээ итгэлтэй байна уу?” гэж ээж нь асуув.

“Тийм ээ. Яг энд байсан даа” гэлээ. Брадын хүрэм тод цэнхэр, улаан өнгөтэй байсан тул өөр хүрэмтэй андуурах боломжгүй байлаа.

“Өөр газар тавьсан байж магадгүй. Байран дотуур хайя” гэж аав нь хэлэв.

Ээж, аав хоёр нь бас Брад өрөөнүүдийг шалгахаар салж явлаа. Тэд цуглааны байрныхаа алдсан зүйлсэд зориулсан хайрцаг, Брадын Ням гаргийн ангийн өрөө, Хүүхдийн хэсгийн өрөө болон бүх өлгүүрийг шалгав. Тэр ч бүү хэл ариун цэврийн өрөөгөөр хайсан ч хүрмийг олсонгүй.

“Хэн нэг нь андуураад авсан байлгүй дээ. Тэд өөрсдийнх нь биш гэдгийг мэдээд, дараагийн долоо хоногт авч ирэх байх” гэж аав нь хэлэв.

“Тэр хооронд чи хуучин хүрмээ өмсөж бай” гэж ээж нь хэллээ.

Брад хөмсгөө зангидав. Түүнд хуучин хүрэм нь таалагддаггүй байлаа. Тэр хүрэм нь нимгэн, өнгө алдсан бас багадсан байв. Улаан, цэнхэр өнгийн шинэ хүрэм нь түүнийг супер баатар мэт харагуулдаг нь түүнд таалагддаг байжээ.

“Хэн нэг нь миний хүрэм ямар гоё болохыг хараад хулгайлсан байх” гэж Брад бодов. Ийм



зүйл яаж Сүмд болдог байна аа? Тэнд ирсэн хүн бүр үнэнч шударга байх ёстой шүү дээ. Брад хулгайчийг зүгээр орхихыг хүссэнгүй. Түүнд нэг төлөвлөгөө байв. Дараагийн ням гарагт хэн хүрмийг нь өмсөж ирэхийг тэр сайтар харан, хүрмээ шүүрч аваад, “Хулгайч аа, зогсоорой” хэмээн хашхирна. Тэд ч авсандаа харамсана даа.

Брад төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд ням гараг болохыг тэсэн ядан хүлээж байлаа. Дараагийн, бүр түүний дараагийн ням гарагт хүрэм өмсөхөд хэт дулаахан байлаа.

Дахин нэг долоо хоног өнгөрсний дараах ням гарагт Брад Хүүхдийн хэсгийн эрэгтэй хүүхдүүдийн хэн нь хүрмийг маань хулгайлсан бол гэж хардаж харав. Энэ өндөр хүү авсан юм болов уу? Эсвэл тэр охин авсан юм болов уу? Тэр хэнд ч итгэж болохгүй юм байна гэж бодов. Брадад энэ мэдрэмж таалагдсангүй.

Сүмийн дараа Брад байраар тойрон гэр бүлүүдийг хүрмээ өмсөцгөөж байгааг харлаа. Харин хүрмийг нь өмсөж байгаа хүн харагдсангүй. Тэр бүр алдсан зүйлсэд зориулсан хайрцгийг дахин үзсэн ч хүрэм нь бас л байсангүй. Хаана байж болох вэ?

Гэртээ харих зам зуураа Брад өөр төлөвлөгөө гаргав. Тэр залбирахаар шийдлээ. Тэнгэрлэг Эцэг алдагдсан зүйлсийг олж чадна гэдгийг тэр мэдэж байв. Тэр орой Брад залбирч, “Тэнгэрлэг Эцэг минь, хэн миний хүрмийг авсан болохыг хэлээч. Би хүрмээ эргүүлж авмаар байна” хэмээн хэлэв.

Брад хулгайчийн нэр эсвэл царай санаанд нь орж ирэх байх хэмээн хүлээлээ. Харин үүний оронд тэр өөрийнхөө найз Карлын талаар бодох болов. Хүүхдийн ангид Брад ихэвчлэн Карлын хажууд суудаг байлаа. Тэд хамтдаа үргэлж инээдтэй алиа хошин зүйлс ярин, инээлддэг байв. Гэтэл Карл сүмдээ хэдэн долоо хоног ирсэнгүй. Брад түүнийг санаж байлаа.

*Карл* хүрмийг авсан байвал яах вэ? Карл Брадын найз байж чадахгүй гэдгээ мэдээд, одоо сүмдээ ирэхээс айж байж магадгүй. Брад Карлыг сүмдээ ирээсэй хэмээн хүсэж байлаа. Хэрвээ Карл хүрмийг авсан бол түүн рүү орилж хашхиралгүй, түүнийг уучлахаар шийдэв.

Брадыг орон дээрээ гарахад сэтгэл нь тайвширсан байлаа.

Дараагийн ням гаргийн Хүүхдийн хэсэгт Карл ирээгүй ч өөр нэгэн шинэ хүү ирсэн байв. Тэр улаан, цэнхэр өнгийн судалтай зангиа зүүсэн байлаа.

Тэр шинэ хүүгийн хажууд суугаад “Гоё зангиа байна шүү. Чамайг яг супер баатар шиг харагдуулж байна” гэв.

Нөгөө хүүг инээмсэглэхэд Брад ч хариуд нь инээмсэглэлээ. Тэр хулгайчийг хайхын оронд найзаа хайхаар болов. ●

*Зохиогч нь АНУ-ын Айова мужид амьдардаг.*



Сайн  
байна уу?  
Эстониос  
МЭНДЧИЛЖ  
байна!



Биднийг Марго,  
Паоло гэдэг. Энэ жил бид  
Бурханы хүүхдүүдийн  
талаар суралцахаар дэл-  
хийгээр аялж байгаа юм.  
Бидэнтэй хамт  
Эстониор аялна уу!



Энэ бол Эстониин нийслэл Таллин хот юм.  
Энэ хот 800 жилийн настай. Эстони нь ой мод,  
балчиг намаг гэх мэт байгалийн онгон газар  
ихтэй. Үнэндээ Эстониин газар нутгийн талыг  
ой мод эзэлдэг. Эстонид байгальд чөлөөт цагаа  
өнгөрүүлэх дуртай хүмүүс олон бий.

Эстон хэлээр “Сайн  
байна уу” гэдгийг

“Тэрэ!”

гэдэг. Харин  
Сүмийн нэрийг

Viimse Aja  
Pühade Jeesuse  
Kristuse Kirik  
гэдэг.

Эстони улс хойд Европт  
оршдог. Энэ улс 2000  
гаруй аралтай.  
Ойролцоогоор 1,3 сая  
хүн Эстонид амьдардаг.







Эстони оройн хоолондоо юу иддэг вэ? Гахайн мах эсвэл даршилсан загастай төмс, байцаа, зөөхий, хар талхтай байж болох юм. Үүнийг шпротны хачиртай талх гэж нэрлэдэг.



Эстони дахь Сүм жижигхэн ч гэсэн хүчтэй. Тэнд ойролцоогоор Сүмийн 1000 гишүүн байдаг. Хамгийн ойр байрлах ариун сүм бол Финландын Хельсинки дэх ариун сүм юм.



Та Хүүхдийн хэсэгт дуулах дуртай юу? Таван жил тутам эстоничууд улсынхаа баярыг тэмдэглэн, дуулж, бүжиглэхээр цугларцгаадаг.

**Та Эстонид амьдардаг уу?  
Бидэнд захидал бичээрэй! Бид таныг  
сонсохыг хүсэж байна.**

Эстониор бидэнтэй хамт аялсанд баярлалаа! Дараа дахин уулзацгаая!



### Эстонийн хоёр эгчтэй танилцана уу!



Орой орондоо орох гэтэл бамбарууш минь алга болсон байв. Би хайгаад олоогүй. Тэгээд би залбирав. Дараа нь би бамбаруушаа олсон бас сайхан зүүд зүүдэлсэн.

**Бианка Ж., 7 настай**



Манай гэр бүл бусдад үйлчлэх дуртай. Үйлчлэх нь бидэнд Ариун Сүнснийг мэдрэхэд тусалдаг ба энэ нь надад амар амгалангийн халуун дулаан мэдрэмжийг төрүүлдэг. Би эгч нартайгаа хамт бусдад хайрыг мэдрүүлэх дуртай тул хүмүүст бэлэг бэлддэг.

**Пийби Ж., 10 настай**



# Шинэ хүн БОЛСНОО МЭДРЭХ НЬ



**Жэссика Ларсэн**

Бодит түүхээс сэдэвлэв

*Эстони*

“Би гэнэтийн бэлэг бэлдсэн байгаа!” хэмээн *Эма* (Ээж нь) Расмусыг сургуулиас нь авахдаа хэлэв. Тэд өнгө алагласан барилгуудтай нарийхан гудамжаар хамтдаа уруудан алхлаа.

“Оройн хоолондоо *росолье* идэх юм уу?” гэж Расмус горьдон таалаа. Тэд үүнийг дөнгөж өнгөрсөн долоо хоногт, долоон насных нь төрсөн өдрөөр идсэн байв. Гэхдээ тэр үхрийн мах, төмс, даршилсан май загастай салатыг өдөр болгон идсэн ч чадахаар байлаа.

*Эма* инээмсэглэсээр толгойгоо сэгсрэв. “Би өглөө хоёр залуухан эмэгтэйтэй автобусанд таарсан. Тэд номлогч бөгөөд өнөө орой сүмийнхээ талаар ярихаар манайд ирнэ” гэв.

Расмус сонирхон дээш харлаа. Тэр өмнө нь номлогчидтой огт уулзаж байсангүй.

Номлогчдыг ирэхэд тэр галын машинаараа унтлагынхаа өрөөнд тоглож байв. “*Тэрэ! Тэрэ!* Сайн байна уу!” гэсээр тэд байранд нь орж ирэхдээ *Эматой*

мэндчиллээ. Тэд хүнд гутлаа тайлж, *Эмагийн* зочдоо зориулан хадгалдаг гэрийн углаашийг өмсөв. *Эма* тэднийг улбар шар өнгийн буйдан руу хөтөллөө. Гэвч Расмус хаалганыхаа хажуу талаас холдсонгүй.

Арай өндөр эмэгтэй түүнийг анзаарч хараад, инээмсэглэв. Хар өнгийн энгэрийн тэмдэг дээр нь *Крэйг* эгч гэсэн байлаа. Тэр “Ээж чинь чиний төрсөн өдөр сайхан болсон гэж хэлсэн. Бид чамд зориулан нэг юм авчирсан” гэв. Тэр жижигхэн карт өглөө. Расмус ойртуулан харав.

Тэр нь нэг эрэгтэй хүний зураг байлаа. Тэр хүн цагаан өмсгөлтэй бөгөөд гараа алдлан сунгасан байв.

“Энэ хүн хэн болохыг чи мэдэх үү?” гэж *Крэйг* эгч асуулаа.

Расмус тэр эрэгтэйн нэрийг мэдэхгүй байв. Тэрээр урьд нь энэ зургийг харж байгаагүй байжээ. Гэвч тэр эрэгтэй сайхан сэтгэлтэй, хүчтэй хүн шиг харагдав. “Би энэ хүнийг хаан гэж бодож байна!” гэж Расмус хэллээ.



Хоёр номлогч хоёулаа инээмсэглэв. “Тийм ээ. Тэр бол хаан! Тэр бол хаадын Хаан! Түүнийг Есүс Христ гэдэг” гэв. Крэйг эгч хөх хавтастай ном гаргаж ирлээ. “Харин энэ бол Түүний тухай заадаг Мормоны Ном” гэв.

Эма тэр хоёр Мормоны Номыг сургуульдаа явахад нь өмнө өдөр бүр уншдаг болов. Хичээлийнхээ үеэр Расмус ангийнхантайгаа гадуур алхаж, бас дугхийдэг байжээ. Хичээлийнхээ дараа Эма тэр хоёр номлогчидтой байнга уулздаг байв. Тэд номлогчидтой Мормоны Номоос уншсан зүйлээ ярилцдаг байлаа. Заримдаа Эма бүх хүнийг сүлжсэн шанцтай талх буюу *крингэлээр* дайлдаг байв. Амралтын өдрүүдэд Эма тэр хоёр дугуй унаж, далайн эргээр зугаалдаг. Харин заримдаа ой модонд эсвэл дуртай голынхоо эргээр удаан гэгч алхдаг.

Ойгоор ийнхүү алхаж байхад Эма түүнд баптисм хүртэхийг хүсэж байгаагаа хэлэв. Расмус инээлээ. Номлогчид Эмагаас баптисм хүртэхийг хүсэж байгаа эсэхийнхээ талаар залбирахыг хүссэн байж. Харин ингэж хэлсэн болохоор тэр хариултаа авсан бололтой!

“Би бас яг хаана баптисм хүртэхээ мэдэж байгаа. Чи таа даа?” хэмээн инээмсэглэсээр асуулаа.

Расмус номлогчдын баптисмын талаар заасан хичээлийг санав. Тэд Есүс, Иохан Баптист хоёрын голын эрэг дээр байгаа зургийг харуулсан байлаа. . . .

Тэр “Тол! Бидний дуртай гол” хэмээн баярлан хэлэв.



Долоо хоногийн дараа Расмус голын эрэг дээр номлогчид болон сүмийн өөр хэдэн хүний хамт зогсов. Эма баптисм хүртэхэд бэлэн болсон байлаа. Тэр Есүстэй адил усан доор бүхэлдээ оров. Уснаас гарч ирэхдээ тэр инээмсэглэж байлаа. Расмус энэ цаг мөчийг буюу цэнхэр ус, ногоон зүлгэн дээрх цагаан зэрлэг цэцэгс, ээжийнхээ инээмсэглэлийг үргэлж санахыг хүсэж байв.

Дараа нь тэрээр “Баптисм хүртэх ямар байсан бэ?” гэж хүмүүсийг номлогчдын авчирсан жигнэмгийг идэж байх зуур асуулаа.

“Гайхалтай. Би голоос гарч ирмээргүй байсан. Надад шинэ хүн болсон мэт санагдсан” гэж ээж нь хэлэв. Тэр хүүгээ чанга гэвэрлээ.

“Дараагийн төрсөн өдрөөрөө би Есүс, та хоёр шиг баптисм хүртмээр байна. Би ч бас шинэ хүн болсноо мэдрэхийг хүсэж байна” гэж тэр ээждээ хэлэв. ●

*Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.*







Халамжийн нийгэмлэ-  
гийн ерөнхий ерөн-  
хийлөгчийн зөвлөлийн  
хоёрдугаар зөвлөх  
**Рэйна И.Абурто**

# Би түүнийг дахин харна



**Б**и Никарагуад өсөж торнисон юм. Бага байхдаа би бүх зүйлээ ахтайгаа хамт хийдэг байлаа. Бид сургууль, дэлгүүр рүү хамт явдаг байв. Бас манай хашааны ар талд бөөн адал явдал болдог байлаа. Бид аз жаргалтай байв.

Харин дараа нь есөн нас хүрэхэд маш харамсалтай зүйл болсон юм. Ах маань газар хөдлөлтөөр нас барав. Эхлээд би түүний нас барсныг ухаарч ойлгоогүй. Тэр урд хаалгыг тогшин орж ирээд, хаа нэгтээ байж байгаад ирлээ гэж хэлнэ хэмээн төсөөлөн боддог байлаа. Би хаалга руу ширтэн, ийм юм болоосой хэмээн хүсдэг байв. Би түүнийг дахин харахыг маш их хүсэж байлаа.

Цаг хугацаа өнгөрсний дараа арай гайгүй болов. Би ахыгаа санадаг хэвээр байсан ч, дахин баяр хөөрийг мэдрэх болсон юм.

Тэр үед би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн байгаагүй. Харин өсөж том болсныхоо дараа би Сүмийн тухай сурч мэдэн, баптисм хүртсэн юм. Нэг өдөр би аяга тавгаа угааж байлаа. Яг тэр үед Христийн амилсны баяр болж байв. Би Амилалтын талаар мөн ахынхаа тухай бодсон.

Гэнэт надад нэгэн мэдрэмж төрөв. Өдрийн цагаар ахынхаа талаар бодсон бодол маань санаанд орж

ирэв. Энэ нь тийм ч тэнэг зүйл байсангүй! Энэ бодол Ариун Сүнснээс намайг тайвшруулж, удирдан чиглүүлэхээр орж ирсэн байлаа. Хэзээ нэгэн цагт ах минь үнэхээр амилах болно. Мөн би түүнийг үнэхээр дахин харна.

Хайртай хүн чинь нас барсан бол тэднийгээ санагалзаж, гашуудах нь байдаг л зүйл. Бэлэн болсон гэж бодогдох үедээ гэр бүлийнхэнтэйгээ эсвэл томчуудтай ярилцаарай. Тэнгэрлэг Эцэгт хандан өөрийн мэдрэмжийн талаар залбир. Тэрээр танд амар амгаланг дахин мэдрэхэд тусална.

Юу ч болсон бай, Есүс Христ таныг хайрладаг гэдгийг сана. Христийн амилсны баяраар бид Түүний бидний төлөө хийсэн золиослолыг дурсан санадаг. Түүний ачаар бид бүгдээрээ амилуулагдаж, гэр бүлүүдтэйгээ хамт мөнхөд амьдарч чадна. ●

## Тайтгаруулах карт

Эдгээр картыг хайчилж ав. Та картаа дундуур нь эвхэж, номын хавчуулга болгон ашиглаж болно.  
Хавчуургаа судартаа эсвэл уйтгарлан, ганцаардаж, айсан үедээ харж болох газарт хадгал.



“Би та нарыг  
өнгчрүүлж орхихгүй.  
Би та нар уруу ирнэ.”

Иохан 14:18



“Тэр тэдний нүднээс  
нулимс бүрийг  
нь арчина.”

Илчлэлт 21:4



“Зоригтой байгтун, мөн  
бүү эмээ, учир нь Их  
Эзэн бибээр та нартай  
хамт байна, мөн та нарын  
дэргэд зогсч байх болно.”

Сургаал ба Гэрээ 68:6





# Өөрийгөө таниулж, илтэрхийлэх боломж

Би ариун сүм харах дуртай

**Рэбэцца К., 9 настай, Венесуэл, Арагуа**



Нэгэн өдөр биднийг машиндаа суухад машин ассангүй. Бид хөдөлгүүрийг нь шалгасан боловч эвдрээгүй байв. Би залбирах хэрэгтэй гэж мэдэрсэн тул залбирсан юм. Хэсэг хормын дараа машин маань асав. Би Тэнгэрлэг Эцэг бидэнд байнга тусалдаг гэдэгт үнэхээр баяртай байна.

**Бруклин Б., 9 настай, Гватемало, Кесалтинанго**



Хоёр жилийн өмнө сургуулийн ангид маань шинэ хөвгүүн орж ирсэн юм. Тэр бусдад сайхан ханддаггүй байлаа. Бүгд түүнд дургүй болж, эелдэг харьцахаа болив. Энэ нь түүнийг гунигтай болгосон мэт санагдсан тул би бусдын адил зүйлсийг хийгээгүй. Хэдэн найз маань үүнийг анзаараад, миний үлгэр жишээг дагав. Хэрэв би Бурханы хүссэн зүйлийг хийх юм бол илүү их аз жаргалтай, хамгаалагдсан байна гэдэгт итгэдэг. Хэрэв зоригтой байж, санаа бодлоо илэрхийлбэл намайг байгаагаар минь хайрладаг найзуудыг олох болно гэдэгт би итгэдэг.




**Вэстина К., 11 настай, Литва, Вильнюс**



Би жоохон хүүхдүүдтэй хөл бөмбөг тоглож, шинэ ур чадварыг тэдэнд заах дуртай. Энэ нь миний үйлчлэл хийдэг аргуудын нэг юм.

**Саша К., 11 настай, Орос, Москва**

Эдгээр зургийг  
Н12–Н13 хуудсан  
дээрх хүснэгтийг  
дүүргэхэд ашигла.





# Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Энэ сарын *Найз* сэтгүүлд гэр бүлээрээ Христийн амилсны баярыг тэмдэглэхэд туслах түүх, үйл ажиллагаанууд орсон. Танай гэр бүл бүтэн сарын туршид Христийн амилсны баярын талаар бодож цагийг сайхан өнгөрүүлнэ гэдэгт бид найдаж байна!

- “Бурханы агуу бэлэг” (Н2)—Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны Христийн амилсны баярын захиас
- “Есүс бол миний Аврагч” (Н3)—Есүс Христийн Цагаатгал болон Амиалттай холбоотой будах үйл ажиллагаа
- “Христийн амилсны баярын тухай түүх” (Н4–Н6)—Зургаар дүрслэн өгүүлсэн судрын түүх
- “Түүн рүү эргэн очиход минь” (Н7)—Наманчлалын тухай шинэ сайхан дуу
- “Шинэ хүн болсноо мэдрэх нь” (Н18)—Есүсийн тухай сурч мэдсэн эстони хүүгийн түүх
- “Би Түүнийг дахин харна” (Н20)—Амиалтын талаарх Рэйна И.Абурто эгчийн гэрчлэл

Танай гэр бүл эдгээр түүх, үйл ажиллагааг хэрхэн ашигласан талаар бидэнд бичиж мэдэгдэнэ үү.

Христийн амилсны баяраар адислагдах болтугай!

*Найз*

## New Friend

50 E. North Temple Street,

Room 2393

Salt Lake City, UT 84105 USA

liahona@ldschurch.org



**Дотор нь нуусан  
Лиахонаг олоорой!**

## ГАРЧИГ

- Н2** Тэргүүн Зөвлөлөөс: Бурханы агуу бэлэг
- Н4** Судрын түүхүүд: Христийн амилсны баярын тухай түүх
- Н7** Дуу хөгжим: Түүн рүү эргэн очиход минь
- Н8** Шударга байх сайхан
- Н10** Төлөөлөгчид дэлхий даяар: Ахлагч Бэднар Энэтхэгт айлчлав
- Н12** Бидний бошиглогч, төлөөлөгчид
- Н14** Алдсан хүрэм
- Н16** Сайн байна уу? Эстониос мэндчилж байна!
- Н18** Шинэ хүн болсноо мэдрэх нь
- Н20** Би Түүнийг дахин харна
- Н22** Өөрийгөө таниулж, илэрхийлэх боломж
- Н23** Бошиглогч, төлөөлөгчид

**НАЙЗ СЭТГҮҮЛИЙН ХАВТСАН ДЭЭР**  
Зураг чимэглэлийг Патришиа Касталэо